

Лиахоноа

Гэрээнүүд: Бидний хамгийн чухал амлалт. 20-р хуудас

Хөрвөгчдөд заах дөрвөн түлхүүр, х. 12

Сургууль, ажил, болзоо— Төлөвлөгөө чинь бүтэлгүйтсэн үед юу хийх вэ, х. 42

Би гэрчлэлтэй болсноо хэрхэн мэдэх вэ? х. 54, 66, 68





© 2010 SANDRA B. RAST, ХУУЛБАРЛАЖ БОЛГОХҮЙ

Бөднө шувууны гайхамшиг, Сандра Б.Раст

Хожмын Үеийн Гэгээнтнүүдээс хамгийн сүүлд үлдсэн хэсэг Иллинойн Наувугаас 1846 онд хөөгдсөн. Тэдний олонх нь ядуу зүдүү, өвчин эмгэгтэй, өндөр настнууд байлаа. Тэд хомсхон хоол хүнс, хувцас хунар, эд юмстайгаа Миссури мөрнийг завиар гаталж, түр буудаллажээ. Зовж зүдэрсэн тэр цагт хэдэн зуун бөднө шувуу буудал руу нисч ирж буусан ажээ. Бөднө шувууд их номхон байсан болохоор Гэгээнтнүүд тэднийг гараараа барьж, өлөн зэлмүүн явсан өөрсдөд нь маш их хэрэгтэй байсан хүнснээсээ илүүчлэн шувуудыг тэжээж байв.



2012 оны долдугаар сарын Лиахона

ЗАХИАСУУД

- 4** Тэргүүн Зөвлөлийн захиас бичиг: Үргэлж төвд нь Ерөнхийлөгч Диетер Ф.Угдорф
- 7** Айлчлагч багшийн захиас бичиг: Хайр, үйлчлэлээр дамжуулан шавь гэдгээ харуулах нь

ОНЦЛОГ ӨГҮҮЛЛҮҮД

- 16** Бидний өвийн хүч нөлөө
Ахлагч Л.Том Перри
Анхдагчид цөлийг цэцэглэж буй сарнай лугаа адил болгосон шиг бид тэдний үнэт зүйлс болон уламжлалыг өвлөн авч хэрэгжүүлбэл амьдралаа өөд нь татаж чадна.
- 20** Бурхантай байгуулсан гэрээнүүдээ ойлгох нь: Бидэнд өгсөн хамгийн чухал амлалтуудын тойм
Бид Тэнгэрлэг Эцэгтээ юу амласан бэ? Тэр бидэнд юу амласан бэ?

- 24** Олон нийттэй харилцах алба Сүмийг нийгэмтэй холбож байна
Филип М.Вольмар
- 35** Ирээдүйг итгэл найдвараар угтах нь
Ахлагч Хосе А.Тейксера
Грило ах бүх эд хөрөнгөө алдсан ч өнөө үеийн талаар бодол санаа нь өөдрөг, ирээдүйдээ итгэл найдвар дүүрэн байгаа ажээ.

ХЭСГҮҮД

- 8** Дөрөвдүгээр сарын Чуулганы тэмдэглэлээс
- 10** Бид Христийн тухай ярьж байна: Амар амгалангийн ундарга
Ланис Хетон
- 12** Сүмд үйлчилсэн нь: Зүрх сэтгэлд хоногшин үлдсэн хичээл
Рассел Т.Осгурторп

- 30** Бидний гэр орон, гэр бүл: Хэзээ ч бүү бууж өг
Аль Фрай, Ева Фрай нар
- 38** Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн дуу хоолой
- 74** Сүмийн мэдээ
- 79** Гэр бүлийн үдшийн санаанууд
- 80** Биднийг дахин уулзтал: Дэлхийгээс бохирдолгүй
Жюли Томпсон

ХАВТСАН ДЭЭР

Урд: Кристина Смитийн авсан зураг
Хойно: Роберт Кэйсигийн авсан зураг

Мэдэгдэл: 2012 оны 6-р сарын Лиахона нь мэргэжлийн регби тоглогчийн гэрээгээ цуцалж, номлолд үйлчлэхээр сонгосон залуу эрэгтэйн зургийг багтаасан байгаа. Түүний албан ёсны багийн өмсгөл олон янзын худалдааны компаниудын логог сурталчилдаг. Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүм тэдгээр компаниудыг болон тэдний бүтээгдэхүүн, үйлчилгээг дэмжиж, сурталчилдаггүй.



42

42 Сайн төлөвлөгөөнүүд амжилтгүй болох үед

Стефани Ж.Бөрнс

Амьдралын нугачаатай замаар аялж буй залуу насанд хүрэгчдийн хувьд тойруу гэж бодсон зам зарим үед хүрэх ёстой газар руу нь хөтөлдгийг мэдэжээ.



Энэ дугаарт нуусан Лиахонаг олоорой. Санамж: шинэ хуудсыг эргүүл.

46 Санваарын адислалуудын ач холбогдол

Ахлагч Даллин Х.Өүкс

Мөнх амьдралд хүрэх зам дээрх саад тотгорыг даван туулахад тань санваарын адислалууд туслах болно.

49 Үзүүлэн: Гэрчлэл

50 Залбирлын хүч

Паул Ванденберг

Филиппиний Себу арлын өсвөр насны хэдэн залуус тэвдэж сандарсан үедээ залбирч, толгойгоо “усан дээр” гаргажээ.

53 Номлолын талбараас: Амлалт ба залбирал

Пабло Майрелис Веттс

54 Шударга гэрчлэл гэж юу вэ?

Элиз Александрия Холмс

Гэрчлэлтэй болох нь таавартай адил байж болох ч, нэг удаа нэг зүйлийг нэмээд байвал та сайн мэдээний үнэнүүдийн тухай мэдлэгтэй болж чадна.

58 Бусдад сүрхий болж харагдах гэж

Бриттани Томпсон



66

59 Нинжин сэтгэлийн шивнээ

Дебора Мооре

Сургууль дээр нэг нэгнээ дээрлэхдэг явдал сүмд илэрвэл Жеймс юу хийх вэ?

61 Онцгой гэрч: Эхэн үеийн анхдагчид олон жилийн тэртээ амьдарч байжээ. Би тэднээс юу сурч болох вэ?

Ахлагч Л.Том Перри

62 Түүх бүтээж байгаа нь

Чад Э.Фарез

Сома, Эштер, Ката нар Унгар дахь сүмд сайн үлгэр дуурайл үзүүлэхийг хичээж байна.

64 Хүүхдийн Хэсгийг гэртээ авчрах нь: Би сайн мэдээний зарчмуудаар амьдарснаар зөвийг сонгодог.

66 Томасын гэрчлэл

Жошуа Ж.Перки

Томас гэрчлэлээ хуваалцахаас өмнө гэрчлэл гэж юу болохыг мэдэх хэрэгтэй байлаа.

68 Гэрчлэлээ хэрхэн өсгөх вэ?

Нэг удаа нэг үнэнийг мэдэх замаар гэрчлэлээ өсгөн нэмэгдүүл.

69 Бидний хуудас

70 Бага насны хүүхдүүдэд зориулав



58

**2012 ОНЫ ДОЛДУГААР САРЫН ДУГААР 13 NO. 4
ЛИАХОНА 10487 363**

Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн
Сүмийн олон улсын сэтгүүл

Тэргүүн Зөвлөл: Томас С.Монсон, Хенри Б.Айринг,
Диетер Ф.Угдорф

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга: Боид К.Пакер,
Л.Том Перри, Рассел М.Нелсон, Даллин Х.Өүкс,
М.Рассел Баллард, Ричард Г.Скотт, Роберт Д.Хейлс,
Жеффри Р.Холланд, Давид А.Беднар, Квинтин Л.Кук,
Д.Тодд Кристофферсон, Нийл Л.Андерсен

Эрхлэгч: Пол Б.Пайпер

Зөвлөхүүд: Кейт Р.Эдвардс, Кристоффел Голден Бага,
Пер Ж.Малм

Гүйцэтгэх захирал: Давид Л.Фричнхт

Редакцийн захирал: Винсент А.Вон

Зургийн дарга: Аллан Р.Лоиборг

Гүйцэтгэх редактор: Р.Вал Жонсон

Гүйцэтгэх туслах редактор: Женифер Л.Грийнвүүд,
Адам К.Өүлсон

Туслах редактор: Сюзан Баррет, Раян Карр

редакцийн ажилтнууд: Бриттани Бетти, Давид
А.Эдвардс, Маттью Д.Флиттон, Ларина Портер Гаунт,
Карри Кастен, Женнифер Медди, Лиа МакКаллахан,
Меллиса Меррил, Майкл Р.Моррис, Салли Ж.Өүдкөрк,
Жошуа Ж.Перки, Чад И.Фарес, Жан Пинбороу, Паул
ВанДенберг, Мариса А.Виддисон, Мелиса Зентено

Гүйцэтгэх Зургийн захирал: Ж.Скотт Нудсен

Зургийн захирал: Скот Ван Кампен

Уран бүтээлийн менежер: Жейн Анн Петерс

Ахлах дизайнерууд: К.Кимбалл Ботт, Коллин Хинкли,
Эрик П.Жонсен, Скотт М.Моёо

Уран бүтээлийн ажилтнууд: Коллетт Небекер Аун,
Конни Бавторф Бридж, Ховард Ж.Браун, Жюли Бердетт,
Брайн В.Жижи, Катлийн Ховард, Денис Көрби, Жинни
Ж.Нилсон, Гейл Тейт Рафферти

Хэвлэлийн эх бэлтгэгч: Жефф Л.Мартин

Хэвлэлийн захирал: Крейг К.Седвик

Хуваарилалт хариуцсан захирал: Эван Ларсен,
Нэгдсэн Улс, Канадаас бусад орнууд дахь захиалга
болон үнийн талаар орон нутгийн Сүмийн хангамжийн
төв болон тойрог, салбарынхаа удирдагчтай холбоо
барина уу.

**Гар бичмэл болон асуултаа интернет веб сайт
liahona.lds.org руу; шуудангаар Liahona, Rm. 2420,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150-0024,
USA хаягаар; эсвэл э-мэйлийн: liahona@ldschurch
.org хаягаар ирүүлнэ үү.**

Лиэхона нь (Мормоны Номон дахь утгаараа бол
"луужин" буюу "залагч") албани, англи, армен,
бислам, болгар, вьетнам, гаити, герман, грек, дани,
индонез, ирланд, испани, итали, камбож, кирибати,
латви, литва, малагаш, маршалл, монгол, нидерланд,
норвеги, орос, польш, португали, румын, самоа,
себуано, солонгос, тагалог, тай, тахити, тонга, украин,
унгар, урду, физи, фин, франц, хорват, хятад,
хятад (хялбаршуулсан), чех, швед, эстони, япон хэлээр
нийтлэгддэг. (Жилд нийтлэгдэх дугаарын тоо улс бүрд
өөр байна.)

© 2012 by Intellectual Reserve, Inc. Бүх эрх
хамгаалагдсан. Америкийн Нэгдсэн Улсад хэвлэв.


Лиэхона дахь сэдэв, үзүүлэн, материалуудыг онцгой
тохиолдолд арилжааны бус зорилгоор сүм болон
гэрт ашиглахын тулд хувилж болно. Урлагийн
бүтээлийг хуулбарлахыг хориглосон бол үзүүлэнг
хувиан олшруулж болохгүй. Зохиогчийн эрхийн
талаарх асуултаа Intellectual Property Office, 50 E.
North Temple St., Salt Lake City, UT 84150, USA хаягаар;
эсвэл электрон шуудангийн: cor-intellectualproperty@
ldschurch.org хаягаар ирүүлнэ үү.

For Readers in the United States and Canada:
July 2012 Vol. 13 No. 4. LIAHONA (USPS 311-480)
Mongolian (ISSN 1525-7584) is published six times a
year (January, April, June, July, October, and December)
by The Church of Jesus Christ of Latter-day Saints,
50 E. North Temple St., Salt Lake City, UT 84150. USA
subscription price is \$5.00 per year; Canada, \$6.00
plus applicable taxes. Periodicals Postage Paid at Salt
Lake City, Utah. Sixty days' notice required for change
of address. Include address label from a recent issue;
old and new address *must* be included. Send USA and
Canadian subscriptions to Salt Lake Distribution Center
at address below. Subscription help line: 1-800-537-
5971. Credit card orders (Visa, MasterCard, American
Express) may be taken by phone. (Canada Poste
Information: Publication Agreement #40017431)

POSTMASTER: Send address changes to Salt Lake
Distribution Center, Church Magazines, PO Box 26368,
Salt Lake City, UT 84126-0368.

Дэлгэрэнгүй мэдээллийг

онлайнаас үзэж болно Liahona.lds.org



НАСАНД ХҮРЭГЧДЭД ЗОРИУЛАВ

Санваартны удирдагчид Сүмийн олон нийттэй харилцах албаны зөвлөлүүдээр дамжуулан нийгэм, хамт олонд тусламж үзүүлж байна (24-р хуудсыг үз). Та энэхүү үйл ажиллагааны талаар дэлгэрэнгүй мэдээллийг publicaffairs.lds.org вэб сайтаас (англи хэлээр) үзэж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Сүнслэг нөлөө бүхий дуу хөгжим та-
таж авч, видео бичлэг үзэж, *Залуучуу-
дын бат бөх байдлын төлөө* товхимол
дахь жишгүүдийн тухай өгүүллүүдийг
олж үзэхийн тулд youth.lds.org
хаягаар зочлоорой.

ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Унгарын Будапешт хотын Сома, Эш-
тер, Ката нартай танилцана уу, 62-р
хуудсыг үз. Тэдний бусад гэрэл зургийг
liahona.lds.org-аас үзнэ үү.

ЭНЭ ДУГААР ДАХЬ СЭДВҮҮД

*Тоонууд нь өгүүллийн эхний хуудсыг
зааж байгаа.*

- Адислалууд,** 46
- Айлчлагч**
- багшлагч,** 7
- Анхдагчид,** 16, 61
- Ариун Сүнс,** 12
- Ариун сүм,** 80
- Бэлтгэл,** 4
- Бэрхшээл,** 35
- Гэр бүл,** 16, 30, 41
- Гэрлэлт,** 30
- Гэрчлэл,** 30, 40,
49, 54, 66
- Гэрээнүүд,** 20
- Дуулгавартай**
- байдал,** 42
- Ерөнхий**
- чуулган,** 8
- Есүс Христ,** 10
- Ёслолууд,** 20
- Залбирал,** 38,
50, 64
- Зан төлөв,** 58
- Итгэл,** 35, 42
- Мацаг, мацаг**
- барилт,** 64
- Мормоны Ном,**
- 38, 53**
- Найдвар,** 35, 42
- Нинжин сэтгэл,** 59
- Номлолын ажил,**
- 4, 24, 38, 53**
- Олон нийттэй ха-**
- рилцах алба,** 24
- Санваар,** 46
- Сургалт,**
- сургаал,** 12
- Уурч мэдэх нь,** 12
- Уучлал,** 38
- Хөрвөлт,**
- хөрвүүлэг,** 30
- Шударга зан,** 70
- Үйлчлэл,** 7, 24, 80
- Үхэл,** 10

ТӨРӨЛХ ХЭЛЭЭРЭЭ

Лиэхона болон Сүмийн бусад материа-
луудыг олон хэлээр www.languages.lds.org-аас үзэж болно.

Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар зөвлөх
Ерөнхийлөгч
Диетер Ф.Угдорф



ҮРГЭЛЖ ТӨВД НЬ

Дэлхийн олон хуанлид долдугаар сар нь жилийн дунд үеийг тэмдэглэдэг. Юмсын эхлэл болон төгсгөлийг баяр ёслол болгон тэмдэглэхэд дунд үе нь ажиглагдаагүй үлдэх нь олонтоо тохиолддог.

Аливаа юмны эхлэл нь шийдвэр гаргаж, төлөвлөгөө боловсруулах хийгээд эрч хүч оргилсон үе байдаг. Төгсгөл нь үйл ажиллагаа суларч нэг бол дууссан эсвэл амжилтгүй болсон үе байдаг. Гэвч бид юмсыг зохих ёсоор үнэлж, өөрсдийгөө *төвд нь* тавьж харснаар амьдралыг илүү сайн ойлгох төдийгүй илүү утга учиртай амьдарч чадна.

Номлолын ажлын төвд

Би залуу номлогчдод номлолын ажлын гол цөм нь тэд өөрсдөө гэдгийг үргэлж хэлдэг. Тэд номлолд ирээд ганцхан хонож байгаа эсвэл маргааш нь номлолоосоо чөлөөлөгдөөд харих байсан ч ялгаагүй өөрсдийгөө ямагт номлолын ажлын төвд байгаа гэж бодохыг би тэднээс хүсдэг байлаа.

Шинэ номлогчид туршлагагүйгээсээ болоод үр өгөөжтэй зааж чадахгүй гэж боддог байж магадгүй. Энэ шалтгаанаас болж тэд үгээ итгэл дүүрэн зоригтойгоор хэлэхээ хойшлуулдаг. Номлолоо дуусгаж байгаа туршлагатай номлогчид номлолынхоо дараа хийх зүйлээ төлөвлөх талаар дутмаг байж мэднэ.

Тэд ямар ч нөхцөлд, хаана ч үйлчиллээ гэсэн үнэн гэдэг бол Их Эзэний номлогчдын өдөр бүр хийдэг тоо томшгүй олон сайн зүйлсийн үр жимс байдаг. Тэднийг

үргэлж номлолын ажлын төвд байгаагаар харах нь Их Эзэний эдгээр итгэлтэй төлөөлөгчдөд урам зориг, эрч хүч хайрладаг. Зөвхөн бүрэн цагийн номлогчдод төдийгүй бид бүгдэд ч мөн ийм байдаг.

Бид үргэлж төвд нь байдаг

Мөнхийн хэтийн төлөвт гардаг өөрчлөлт нь өнгөцхөн төдий зүйл биш. Бид үргэлж орон зайн төвд байдаг нь маргашгүй үнэн юм. Хэрэв бид байгаа газраа газрын зураг дээрээс харвал дөнгөж эхэнд байна шүү дээ хэмээн бодож магадгүй. Гэвч бид илүү ойртож харвал том газар нутгийн төвд нь байж ч болно.

Газар нутгийн хувьд ийм байдаг бол цаг хугацааны хувьд бас л ийм байдаг. Бид өөрсдийгөө амьдралынхаа эхэнд эсвэл төгсгөлд байна хэмээн бодож болно. Гэвч мөнх амьдралын хувьд бид хаана байгаагаа тунгаан бодох юм бол Есүс Христийн төгс золиослол хийгээд Цагаатгалын ачаар бидний сүнс цаг хугацаа болон хэмжилт хийх бидний чадвараас үл хамааран үүрд мөнх орших болно. Бид үнэхээр амьдралын аяныхаа төвд нь байгаагаа олж мэдэх болно.

Эцэг эхийнхээ шарилын хөшөөг засъя гэсэн бодол саяхан надад төрлөө. Шарилын газар он цагийн уртад гандаж гундсан байв. Тэдний үлгэр жишээч амьдралыг дурсаад би шинэ хөшөө босгох хэрэгтэй юм байна гэж бодсон. Амьдралын тодорхой хугацааны бэлгэдэл--- хөшөөн дээрх төрсөн болон нас барсан он сар өдрийн хоорондох зураасыг хартал үй олон дурсамж миний



оюун ухаан, зүрх сэтгэлийг дүүргэлээ. Зүрх сэтгэлийн эдгээр эрхэм нандин дурсамжууд эцэг эхийн минь болон миний амьдралын дунд үе дээр тогтож байлаа.

Нас болон амьдарч байгаа газраас үл хамааран бидний амьдралд болж өнгөрдөг зүйлсийн хувьд бид үргэлж төвд нь байдаг. Юу ч боллоо гэсэн бид үйл явдлын төвд үүрд байх болно.

Үйл явдлын төвд байх найдвар

Тийм ээ, амьдралд эхлэл, төгсгөл заавал байдаг ч эдгээр нь мөнх амьдрал дахь дунд үеийн зөвхөн эхлэл, төгсгөлийг л харуулдаг. Бид эхлэлд эсвэл төгсгөлд байна уу, хөгшин эсвэл залуу байна уу хамаагүй Их Эзэнд үйлчлэх чадварыг маань хязгаарладаг бодол санааг хойш тавьж, амьдралаа төвхнүүлэх боломжийг Түүнд олговол Их Эзэн Өөрийн зорилгыг хэрэгжүүлэх зэмсэг болгон биднийг ашиглаж чадна.

Дууллыг зохиогч “Энэ бол ЭЗЭНий

зохиосон өдөр юм. Үүнд хөгжилдөн баярлацгаая” (Дуулал 118:24) хэмээн өгүүлжээ. Амюлек бидэнд “Энэ амьдрал бол хүмүүн Бурхантай уулзахаар бэлтгэх үе; тийм ээ, болгоогтун, энэ амьдралын өдөр бол хүмүүн өөрсдийн хөдөлмөрийг гүйцэтгэх өдөр юм” (Алма 34:32; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн) хэмээн сануулсан. Нэгэн яруу найрагч “Үүрд мөнх нь үй олон одоогийн зүйлсээс бүрдэнэ” хэмээн бичжээ.¹

Үргэлж төвд байх гэдэг нь ажил үйлс хэзээ ч дуусахгүй, итгэл найдвар хэзээ ч алга болдоггүй, ялагдал хэзээ ч эцсийнх байдаггүй гэсэн үг юм. Бид ямар нөхцөлд, хаана байгаа нь хамаагүй мөнхийн эхлэл болон төгсгөл бидний өмнө ээлжлэх болно.

Харин бид үргэлж төвд нь байдаг. ■

Эшлэл

1. Эмили Дискенсон, “Forever—is composed of Nows,” *The Complete Poems of Emily Dickinson*, эмхтгэсэн Томас Х.Жонсон (1960), 624.

ЭНЭ ЗАХИАСЫГ ЗААХ НЬ

Ямар нэг зүйлийг эхэлж, дуусгаж байдаг ч тэд “үргэлж төвд нь” байдгийг очиж заадаг гэр бүлтэйгээ ярилцахаар төлөвлө. Өнгөрсөн үеэсээ салж, дараагийн үйл ажиллагаа буюу төслийг хүлээхгүйгээр одоогийнхоо ажил үйлсийг бүх хүчээ дайчлан хийхэд гэр бүлийн гишүүдийг дэмж. Энэ зөвлөгөөг хэрэгжүүлэхийн тулд ямар нэг зүйлийг гэр бүлээрээ санаачлан хэрэгжүүлэхээр сонгож, зорилгоо биелүүлж дүгнэх өдрийг товлохыг та уг гэр бүлд зөвлөж болно.

ЗАЛУУЧУУДАД ЗОРИУЛАВ

Номлолын бэлтгэлийнхээ төвд бай

Ерөнхийлөгч Угдорф номлогчдод хандан номлолынхоо төвд нь байхыг тэднээс хүсч байна. Та нар 12-той эсвэл 18-тай байна уу хамаагүй, энэ санааг номлолд үйлчлэхээр бэлтгэхдээ мөн ашиглаж болно.

Номлолын бэлтгэлийнхээ “төвд” байхын тулд та нар юу хийж болох вэ?

- Үргэлж Ариун сүмд орохоор зохистой бай.
- Ариун Сүнсний өдөөлтийг таньж, тэмдэглэлдээ бичин, үүний дагуу ажил үйлсээ зохицуулж сур.
- Номлогчдын төлөө залбирч бай.
- Номлолд үйлчлэхээр бэлтгэхийн тулд юу хийх ёстойг орон нутагтаа үйлчилж байгаа номлогчдоос асуу.
- Үйлчлэл хийх, судар судлах, тэмдэглэл хөтлөх зэрэг чухал үйл ажиллагаануудад цагаа үр ашигтай зохицуулж сур.
- Хамгийн сүүлд өөрт чинь сүнслэгээр нөлөөлсөн судрыг гэр бүлийн нэг гишүүнтэй хуваалц. Энэ судрын талаарх бодол санаагаа хуваалц.
- Найз нараасаа явдаг сүмийнх нь тухай, итгэл бишрэлийнх нь тухай асуу. Өөрийнхөө итгэл, бишрэлийг хуваалцахад бэлэн бай. Тэднийг сүмд буюу сүмийн үйл ажиллагаанд урь.

Та нар номлолын бэлтгэлийнхээ төвд байгааг мэдсэн үед амьдрал тань Их Эзэний итгэлийг хүлээх хийгээд Сүнсний нөхөрлөлд тэнцэхээр зохистой байж чадна.



ХҮҮХДЭД ЗОРИУЛАВ

Хүн бүр одоо ямар нэг зүйл хийж чадна

1. Та нар хэдэн настай байх нь хамаагүй бусдад туслахын тулд ямар нэг зүйл хийж чадна гэж Ерөнхийлөгч Угдорф заажээ. Тэмдэглэлдээ эсвэл цаасан дээр авьяас чадваруудаа бич. Өөрийн авьяас чадварыг эцэг эхээсээ асуу.
2. Доорх нөхцөлд бусдад туслахын тулд чи авьяас чадвараа хэрхэн ашиглах вэ?



3. Авьяас чадварынхаа жагсаалтын төгсгөлд энэ долоо хоногт бусдад туслах нэг арга замыг бич.





Энэ материалыг залбирч судлан гэрт нь очиж заадаг эгч нартайгаа аль болох ойлгомжтойгоор ярилц. Эгч нарыг бэхжүүлэх болон Нийгмийн Халамжийн Бүлэг амьдралд тань идэвхтэй үүрэг гүйцэтгэхэд туслах асуултуудыг асуу.

Хайр, үйлчлэлээр дамжуулан шавь гэдгээ харуулах нь

Есүс Христ мөнх бус амьдралынхаа туршид бусдад үйлчлэхдээ тэднийг хайрлах хайраа харуулсан юм. “Хэрэв та нар бие биеэ хайрлах юм бол үүгээр чинь бүх хүн та нарыг Миний шавь нар мөн гэдгийг мэдэх болно” (Иохан 13:35) хэмээн Тэрбээр хэлсэн билээ. Тэрбээр бидэнд үлгэр дуурайл үзүүлэн, [бидний] “халамжаар дутагдах тэднийг халамжлахыг” (Мозая 4:16) биднээс хүсдэг билээ. Тэрбээр Өөртэйгөө хамт ажиллуулахаар шавь нараа үйлчлэлд дуудаж, бусдад үйлчлэх болон Түүнтэй илүү адилхан болох боломжийг олгодог.¹

Айлчлагч багш нар бид дараах зүйлсийг хийснээр гэрээр нь очиж заадаг эгч нартаа хайрладаг хайраа харуулбал бидний үйлчлэл Аврагчийн үйлчлэлтэй адилхан болох болно.²

- Тэдний нэрийг гэр бүлийн гишүүдийнх нь нэртэй тогтоож, тэдэнтэй дотно танилц.
- Тэднийг бүү шүүмжил, харин хайрла.
- Тэднийг харж хандан, Аврагчийн адил “нэг нэгээр” нь итгэлийг нь бэхжүүл (3 Нифай 11:15).
- Гэрээр нь очиж заадаг эгч нартай чин сэтгэлээсээ нөхөрлөж, гэрт нь болон бусад газарт уулзаж ярилцаж бай.
- Эгч бүрийг анхаарч халамжил. Төрсөн өдөр, сургууль төгссөн, хурим хийсэн, баптисм хүртсэн зэрэг тэдний хувьд чухал бусад өдрүүдийг тогтоож ав.



- Шинэ болон идэвх султай гишүүдэд тусал.
- Ганцаардсан буюу тайтгарал хэрэгтэй хүмүүст тусал.

Судруудаас

3 Нифай 11; Моронай 6:4; Сургаал ба Гэрээ 20:47

Эшлэл

1. *Daughters in My Kingdom: The History and Work of Relief Society* (2011), 105-ыг үз.
2. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 3.2.3-ыг үз.
3. *Daughters in My Kingdom*, 3.
4. *Daughters in My Kingdom*, 6.

Би юу хийж чадах вэ?

1. Би бусдыг халамжлах чадвараа хэрхэн дээшлүүлэх вэ?
2. Анхаарал тавьдаг эгч нартаа тэднийг хайрладаг гэдгээ харуулахын тулд би юу хийж болох вэ?

Итгэл, Гэр бүл,
Халамж

Бидний түүхээс

“Есүс Христэд итгэх итгэлийг хөгжүүлсэн нэртэй, нэргүй эмэгтэйчүүдийн тухай олон шастир Шинэ Гэрээнд гардаг. . . . Эдгээр эмэгтэйчүүд үлгэр жишээч шавь нар байлаа. . . . [Тэд] Есүс болон Түүний Арванхоёр Төлөөлөгчтэй хамт аялж байв. Тэд эд хөрөнгөө Түүний үйлчлэлд туслахаар өгч байлаа. Түүний үхэл болон Амилалтын дараа, [тэд] итгэлтэй хэвээр байсан юм.”³

“Чуулганы үйлчлэгч” Фойбе (Ром 16:1) гэгч эмэгтэйн тухай Паул бичсэн байдаг. Паул хүмүүсээс “та нарын хэрэг байж болох аливаа юманд нь түүнд туслаарай. Учир нь тэр өөрөө олон хүнд, мөн надад ч тусалж байсан” (Ром 16:2) хэмээн хүсчээ. “Фойбе болон Шинэ Гэрээн дэх бусад агуу эмэгтэйчүүдийн үзүүлдэг байсан үйлчлэлийг өнөөдөр Нийгмийн Халамжийн Бүлгийн гишүүд — удирдагчид, айлчлагч багш нар, эхчүүд болон бусад хүмүүс үргэлжлүүлэн олон хүнд тусалж байна.”⁴

Дөрөвдүгээр сарын Чуулганы ТЭМДЭГЛЭЛЭЭС

“Их Эзэн миний бие ярьснаа би ярилаа, . . . харин миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38).

2012 оны 4-р сарын ерөнхий чуулганы талаар эргэн санаж амьд бошиглогч, төлөөлөгчдийн сүүлийн үед заасан зүйлсээс сурч, амьдралдаа хэрэгжүүлэхийн тулд та нар эдгээр хуудсуудыг (мөн дараагийн дугаарууд дахь Чуулганы тэмдэглэлүүдийг) ашиглаж болно.

ЧУУЛГАНЫ ТҮҮХҮҮД

Санваарын хүч

Дэлхийн II дайны үеэр 1944 оны эхээр Хавайн Сонинд ажиллаж байсан Сүмийн гишүүн бус нэгэн сурвалжлагчтай тохиосон зүйл санваартай холбоотой билээ. . . . Тэр бусад сурвалжлагчийн хамт Кважалейн Атолл арал дээрх тэнгисийн явган цэргийнхний ард хоёр дахь давалгаанд байлаа. Тэднийг давших үед тэд усан дээр нүүрээрээ доош харан, харваас хүндхэн шархадсан нэгэн залуу усан цэрэг хөвж явааг харжээ. Түүний эргэн тойрон дахь гүехэн ус түүний цусанд будагдан улаан болсон байв. Тэгээд дараа нь тэд бас нэг өөр усан цэрэг шархадсан хамтрагчийнхаа зүг сэлж явааг харжээ. Хоёр дахь усан цэрэг бас шархадсан байв. Зүүн гар нь дэмий унжин, хажуугаараа налан сэлүүрдэнэ. Тэр түүнийг живэхээс хамгаалан усан дээр хөвж явсан нэгэн рүү толгойгоо дээш өргөв. Сандарсан хоолойгоор тусламж эрэн ориллоо. Тусламж үзүүлэн, эргэн “Хүү минь, энд энэ хүүд туслах хэн нэгэн байна уу?” хэмээн орилох хүү рүү сурвалжлагчид дахин харлаа.

“Дараа нь би өмнө нь хэзээ ч харж байгаагүй нэгэн зүйлийг харсан” хэмээн сурвалжлагч бичсэн байлаа. Өөрөө хүнд шархадсан ч энэ хүү өөрийн найз усан цэргийн амьгүй болсон мэт биеийг эрэг дээр гаргахаар зүтгэн явлаа. Тэр “толгойгоо хамтрагч найзынхаа өвдөг дээр тавьлаа. . . . Эдгээр хоёр мөнх бус биеэр шархадсан хөвгүүд хоёул цэвэр ариун, гайхалтай харагдах залуус тэр бүү хэл өөрсдийн гаслантай нөхцөл байдалд ч ямар гайхамшигтай байсан гэвч. Тэгээд нэг хөвгүүн толгойгоо нөгөөгийнхөө дээр бөхийн, ‘Би чамд Есүс Христийн нэр дээр, санваарын хүчээр чамайг эмнэлгийн тусламжинд хүрэх хүртэл амьд байхыг тушааж байна.’” гэж хэллээ. Сурвалжлагч өөрийн өгүүллийг: “Бид гурав [хоёр усан цэрэг ба би] энд эмнэлэгт байна хэмээн



төгсгөжээ. Эмч нар мэдэхгүй [үүнийг тэд хэрхэн амьдруулсныг] харин би мэднэ.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Үйлчлэхийг хүсэх ба үйлчлэх зохистой байх” *Лиакхона*, 2012 оны 5-р сар, 67, 68.

Бодож тунгаах асуултууд:

- Санваарын хүчээр дамжуулан Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд ямар адислалууд ирдэг вэ?
- Санваарыг атгагчид ба адислалуудыг хүлээн авагч нарын хувьд итгэл ба санваар хэрхэн холбогддог вэ?

Өөрийн бодол санааг тэмдэглэлийн дэвтэртээ бичиж, энэ талаар бусадтай харилцан ярилц.

Энэ сэдвээрх нэмэлт эх сурвалжууд: LDS.org дээр Сэдвийн дагуу судлах дээр “Санваар”; Жюли Б.Бек “Урсах адислалууд”, *Лиакхона*, 2006 оны 5-р сар, 11–13; *Сайн мэдээний зарчмууд* (2009), “Санваар,” 67–71.

Ерөнхий чуулганы үгсийг conference.lds.org-оос уншиж, үзэж, сонсох боломжтой.



СҮМИЙН ГЭРЭЛ ЗУРАГ

Гишүүнчлэл (2011 оны байдлаар)	14,441,346
Гадас ба дүүрэг	3,554
Тойрог, салбарууд	28,784
Номлол	340
Бүрэн цагийн номлогчид	55,410
Сүмийн үйлчлэлийн номлогчид	22,299
Баптисм хүртсэн хөрвөгсөд	281,312
Үйл ажиллагаа явуулж байгаа ариун сүмүүд.	136

СУРАЛЦАХ БУЛАН

Зэрэгцээ зураг: Гэр бүл

Зарим маш чухал сэдвүүд ерөнхий чуулган дээр нэг биш удаа давтагдан яригддаг. Гэр бүлийн тухай дөрвөн яриа өгөгч юу гэж хэлснийг энд үзүүлээ. Ерөнхий чуулган дээр хэлсэн үгсийг судлахдаа бусад төстэй яриануудыг хайхыг хичээгээрэй.

- “Эхнэр нөхрүүд хэзээ ч дуудлагаасаа чөлөөлөгдөхгүй бөгөөд эхлээд бие биенээ, харин дараа нь хүүхдүүдийнхээ төлөө байна гэдгээ ойлгох ёстой.”¹—Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч, Ерөнхийлөгч Боид К.Пакер
- “Бид юмсыг зөв дараалаар хийх ёстой! Эхлээд гэрлэлт дараа нь гэр бүл. Дэлхий дээр маш олон хүмүүс энэ бодит дарааллыг умартан, тэд үүнийг өөрчилж чадна эсвэл тэр бүү хэл урвуулан цуцалж болно гэж боддог.”²—Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Расселл Баллард
- “Гэр бүлээрээ судраас судлах, гэр бүлийн үдэш зохион байгуулах оролдлого бүр төгс болдоггүйг би мэднэ. Тулгарах саад бэрхшээлүүдээс бүү шантар.”³—Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Квүнтэн А.Күк
- “Хүүхдүүдээ ойлгохыг заах нь зүгээр мэдээлэл дамжуулахаас илүү зүйл юм. Энэ нь тэдний зүрх сэтгэлд сургаалыг суулгахад тусалж байна гэсэн үг.”⁴—Хүүхдийн хэсгийн Ерөнхий Ерөнхийлөгчийн зөвлөлийн хоёрдугаар зөвлөх Черил А.Эсплин

ЭШЛЭЛ

1. Боид К.Пакер, “Нэгэн бяцхан хүүхэд тэднийг удирдах болно” *Лианхона*, 2012 оны 5-р сар, 8.
2. М.Расселл Баллард “*Лианхона*”, 2012 оны 5-р сар, 100.
3. Квүнтэн А.Күк, “*Лианхона*”, 2012 оны 5-р сар, 44.
4. Черил А.Эсплин, “Хүүхдүүдээ ойлгохыг заах нь” *Лианхона*, 2012 оны 5-р сар, 10.

Бошиглогдсон амлалт

“Энэ удаагийн ерөнхий чуулганыг хаахдаа та бүгдийн хүн нэг бүрийн дээр тэнгэрийн адислалууд ирэх болтугай хэмээн залбирч байна. . . . Та бүхэн сонссон үнэнүүдийнхээ тухай тунгаан бодож, тэдгээр нь ерөнхий чуулган эхлэх үед байснаасаа бүр илүү өөрийгөө өсгөхөд тань туслах болтугай.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон, “Бид энэ чуулганаа хаангаа” *Лианхона*, 2012 оны 5-р сар, 116.

Амар амгалангийн ундарга



ХЭДИЙГЭЭР ТЭГЭХГҮЙ БАЙСАН Ч

“Итгэл бишрэлтэй хүмүүс энэ дэлхийн үйл явдлуудаас дархлагдсан лугаа адил ангид байхгүй. Тиймээс аюултай нөхцөлд зоригтой байсан Шадрах, Мешах, Абед-него гурав бол бидний хувьд үлгэр жишээг нь дагах ёстой баатрууд юм. Өөрсдийг нь Бурхан аврах болно гэдгийг тэд мэдэж байлаа. ‘Хэдийгээр тэгэхгүй байсан ч’ тэд Бурханд үйлчлэх болно хэмээн андгайлсан юм (Даниел 3:16–18-ыг үз).”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл (1926–2004), “Encircled in the Arms of His Love,” *Лиакона*, 2002 оны 11-р сар, 17.

Би тохиолдсон уй гашууг эс хайхран Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд итгэх итгэл найдвараар хүч чадал олж, гутарч цөхрөөгүй юм.

Ланис Хетон

Ууган хүү минь ослоор нас барсан тэр өдөр зүрх шимширч, уй гашууд автаж билээ. Гэвч Аврагчийн цагаатгагч хүч элэг эмтрэм уй гашууг даван туулахад туслах болно гэдгийг би мэдэж байсан ба үүнд найдвар тавьж байсан юм. Нөхөр бид хоёрт адислал өгөөч гэж гэрийн багш нараасаа гуйлаа. Ингэснээр бидэнд хүч чадал өгөгдөх болно гэдгийг би мэдэж байсан. Биднийг сэтгэлийн зовлонтой үед ганцааранг нь орхихгүй гэдгийг Аврагч амласан билээ (Иохан 14:18-ыг үз). Энэ амлалт биелэгдэнэ, Аврагч амласандаа заавал хүрнэ гэдэгт би бат итгэлтэй байсан юм.

Аврагч бол “уй гашуугийн хүн бөгөөд өвчин зовлонг мэдсэн” (Исаиа 53:3) хэмээн Исаиа заасан. Хэрэв бидэнд хэн нэгэн тусалсан бол Аврагч л тусалсан хэрэг. Хэрэв Тэр биднээс уй гашууг тэр дор нь зайлуулчих юм бол өсөлт хөгжилт, ухаан сууж туршлагажих явдал байхгүй гэдгийг би бас мэдэж байлаа.

Зүрх шимшрэм уй гашуу тохиолдсон ч би Аврагчаас ундаргатай амар амгаланг үргэлж мэдэрдэг (1 Нифай 20:18-ыг үз). Онцгой хүнд хэцүү хором, өдөр, тэр ч байтугай долоо хоногуудад Түүний амар амгалан миний уйтгар гунигийг арилгадаг. Ийм амар амгаланг би зөвхөн хэрэгтэй үед л гуйдаг. Мөнх бус амьдралын бартаат аяныг бид ганцаараа даван туулахыг Тэнгэрлэг Эцэг хүсдэггүй.

Хүүгийн минь алтан амийг авч одсон ослын тухай бодох бүрт Хуучин Гэрээний дараах шастир санаанд минь орж ирдэг:

“Бидний үйлчилдэг Бурхан биднийг дүрэлзсэн галтай зуухнаас аварч чадах бөгөөд хаан минь, Тэр биднийг таны гараас аварна.

Хэдийгээр тэгэхгүй байсан ч, хаан минь, бид таны бурхдад үйлчлэхгүй” (Даниел 3:17–18; онцлон тэмдэглэлт нэмэгдсэн).

Энд хамгийн чухал хэсэг нь “Хэдийгээр тэгэхгүй байсан ч” гэсэн



үгс юм. Бид юу ч тохиолдлоо гэсэн итгэлтэй хэвээр байх ёстой. Тэнгэрлэг Эцэг миний хүүг аюултай замаас зайлуулж чадах байсан ч тэгсэнгүй. Энэ нь бидний сэтгэлийг ариусгаж, бид тэнгэр дэх гэртээ Түүнд очиход бэлтгэгдэх болно, ингэснээр бүх юм сайн сайхан болно гэдгийг Тэр мэдэж байжээ. Гэвч энэ нь бид ерөөсөө гашуудаж, уйлахгүй байх хэрэгтэй гэсэн үг биш. Уй гашуу бидний хайрын илрэл хэдий ч, зүрх сэтгэлийг шархлуулах ёсгүй.

Хөшигний хоёр талд байгаа хүмүүст бидний өгч чадах хамгийн сайн бэлэг бол Тэнгэрлэг Эцэг, Есүс Христэд итгэх итгэл найдвараар улам хүчирхэгжиж, алхам бүрд нулимс мэлмэрч байлаа ч үргэлж урагш ахих явдал юм. Учир нь “булшинд ялаат гэж үгүй, мөн үхлийн гашуун нь Христээр залгигдсан юм” (Мозая 16:8) хэмээн бидэнд амласан билээ. Нэгэн цагт “Эзэн БУРХАН бүх нүүрнээс нулимсыг арчина” (Исаиа 25:8). ■

БИД УЙ ГАШУУГ ХЭРХЭН ДАВАН ТУУЛАХ ВЭ?

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жозеф Б.Вертлин (1917–2008) энэ асуултыг 2006 оны аравдугаар сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгэндээ тавьжээ:

“Энэ дэлхийн түүх эхэлсэн цагаас хойш бүх өдрөөс хамгийн хар бараан нь баасан гараг [Аврагч цовдлогдсон өдөр] байсан гэж би боддог.

Гэвч тэр хар өдөр удаан үргэлжилсэнгүй.

Тэрхүү уй гашуу удаан үргэлжилсэнгүй. Учир нь ням гарагт Их Эзэн үхлийн хүлээсийг тас татсан. Тэрбээр булшнаас бүх хүн төрөлхтний Аврагч болон ялгууснаар босч ирэн, нулимс дүүрсэн нүд агшин зуурт хуурай болсон юм. Гай зовлон, уй гашуугийн залбирлыг шивнэн хэлсэн уруул эдүгээ үхэл гэдэг бол гайхамшигтай шинэ туршлагын эхлэл гэдгийг харуулсан Амилалтын анхны үр жимс болон босч ирсэн Есүс Христ, амьд Бурханы Хүүд ерөөл магтаал өргөж байлаа. . . . Дэлхийн Аврагчийн амьдрал, мөнхийн золиослолын ачаар бид хорвоог орхисон дотны хайртай хүмүүстэйгээ дахин учран золгох болно.”

“Sunday Will Come,” *Лиэхона*, 2006 оны 11-р сар, 30.

Одоо болох гэр бүлийн үдшээр үхэл, Амилуулалт, авралын төлөвлөгөөний тухай ярилц. Жишээ нь, 2 Нифай 9, Алма 11–12-ыг үз.



Ням гарагийн хичээлийн
ерөнхий ерөнхийлөгч
Рассел Т.Осгудорп

ЗҮРХ СЭТГЭЛД ХОНОГШИН ҮЛДСЭН ХИЧЭЭЛ

*Бид суралцагч бүрийн гайхалтай чадварыг
хүлээн зөвшөөрснөөр тэднийг Бурхан яаж
хардагтай адилаар харж эхэлдэг.*

Эхнэр бид хоёр Перугийн Каскод томилолтоор очсон үедээ Нийгмийн Халамжийн Бүлэг, Санваартнуудын нэгдсэн хичээлд суусан юм. Тэр өдөр хичээл заасан багш нь Сайн мэдээний сургаалын багш байлаа. Эхний хоёр хичээлээр заасан сэдэв том байсан учраас бэлтгэсэн хичээлээ заахад тэр багшид ердөө 20 орчим минут л үлдсэн байлаа.

Тэрээр сүүлийн хоёр жилийн дотор Сүмд элссэн бүх гишүүдийг босохыг хүссэнээр хичээлээ эхлэв. Таван гишүүн бослоо. Багш 5-ын тоог самбар дээр бичээд “Ах, эгч нар аа, Сүмд элсээд удаагүй байгаа таван гишүүн бидэнтэй хамт байгаа нь ямар сайхан хэрэг вэ. Харин нэг асуудал байгаа нь сүүлийн хоёр жилд бид тойрогтоо 16 шинэ хөрвөгчид баптисм хүртээсэн” гэлээ.

Тэгээд тэр 16-гийн тоог 5-ын тооны дараа бичээд, “Ах, эгч нар минь ээ, одоо бид яах вэ? Юу хийе гэж бодож байна?” гэж чин сэтгэлээсээ асуув.

Нэг эгч гараа өргөөд “Бид тэднийг олж, сүмдээ эргүүлэн авчрах хэрэгтэй” гэлээ.

Багш зөвшөөрч, *аврах* гэдэг үгийг самбар дээр бичлээ. “Бид 11 шинэ гишүүнийг сүмдээ эргүүлэн авчрах хэрэгтэй байна шүү дээ” гэж багш хэллээ.

Тэгээд тэр аврах ажил хэчнэн чухал болох талаар Ерөнхийлөгч Томас С.Монсонгийн үгнээс эш татав. Багш бас Шинэ Гэрээнээс Аврагч алдагдсан нэг хонио эрэхээр хэрхэн явсан тухай суралцагчдад уншиж өглөө (Лук 15:6-г үз). Тэрээр “Бид тэднийг яаж эргүүлэн авчрах вэ?” гэж асуулаа.

Олон хүн гараа өргөхөд тэр нэг нэгээр дуудаж асуув. Тэд гэр бүлээрээ болон хувиараа шинэ хөрвөгчдийг сүмд эргүүлж авчрахад туслахын тулд хэрхэн хамтран ажиллаж болох тухай саналаа хэллээ. Дараа нь багш ингэж асуув. “Хэрэв таныг гудамжаар явж байтал зүс таних саяхны хөрвөгч гудамжны нөгөө талд явж байвал та яах вэ?” “Тэгвэл би гудамж хөндлөн гарч түүнтэй мэндлээд, таныг сүмдээ эргэж ирэн бидэнтэй хамт байхыг бид маш их хүсэн хүлээж байна, та бидэнд их хэрэгтэй байна” хэмээн түүнд хэлнэ гэж нэг гишүүн хариуллаа.

Ангийн бусад гишүүд түүнтэй санал нэг байснаас гадна идэвх султай буюу идэвхгүй болсон гишүүдэд туслах тухай өөр саналуудыг хэллээ. Анги дахь уур амьсгал өөдрөг өрнүүн болж, баптисм хийлгээд удаагүй байгаа хөрвөгчдөд бүрэн идэвхтэй болж, сүмдээ эргэж ирэхэд нь туслахын тулд ангийн гишүүд шаардлагатай ажлыг хийх шийдвэр төгс байлаа.

Эхнэр бид хоёр Сүмд дахин идэвхтэй болоход нь хэн нэгэнд туслахын тулд ямар нэг зүйл хийх өрнүүн хүсэлтэйгээр энэ хичээлээс гарч билээ. Ангид байсан хүн бүр ингэж бодсон гэдэгт би итгэлтэй байна. Би энэ хичээлийн тухай эргэцүүлэн бодоод: Энэ богинохон хичээлийг юу ийм их үр өгөөжтэй болгов оо? хэмээн өөрөөсөө асууж билээ. Яагаад хүн бүр тэр хичээлээс гарч явахдаа сайн мэдээгээр улам бүрэн дүүрэн амьдрах өрнүүн хүсэл эрмэлзэлтэй болсон юм бол?

Би энэ хоёр асуултыг эргэцүүлэн бодоод уг хичээлийг үр өгөөжтэй сурах, заах туршлага болгосон дөрвөн зарчим байна гэж үзсэн юм:



1. Хичээлийн зорилго нь хөрвөлт байлаа.
2. Хайр бол хөрвөлтийн хөдөлгөгч хүч мөн.
3. Сургаал бол хичээлийн түлхүүр.
4. Сүнс бол багш нь юм.

Хичээлийн зорилго нь хөрвөлт байлаа.

“Мэдээллийг зүгээр л ангийн гишүүдийн оюун ухаанд юүлэхийг” хичээх биш харин дээрх багш шиг “*аль нэг зүйлийн талаар эргэцүүлэн бодоход хүмүүст сүнслэгээр нөлөөлж, улмаар сайн мэдээний зарчмуудаар амьдрахын тулд ямар нэг зүйл хийхэд нь тэднийг өвөөдөг байхыг Ерөнхийлөгч Монсон бидэнд анхааруулсан билээ.*”¹

Товчоор өгүүлбэл, энэ багшийн зорилго нь ангийн гишүүдэд тэдний хийгээгүй ямар нэг зүйлийг эсвээс

хичээлд ирээгүй хүмүүст зориулж ямар нэг зүйл *хийхэд* нь туслах явдал байлаа. Тийнхүү *хийх зүйл нь* Аврагчийн жинхэнэ шавь *болоход* нь хүн бүрт туслах явдал байв.

Ийм байдлаар заахын зорилго нь *хөрвөлт юм*. Хөрвөлт *гэдэг үг* нь шинэ үзэл бодол, зан суртахуунтай болж, шинэ байдлаар амьдрах гэсэн утгатай. Хөрвөлт буюу жинхэнэ шавь болох нь нэг удаагийн үйл явдал биш тэнэ хичээл дээр ангийн гишүүд ямар нэг зүйлийг *хийх нь* зөвхөн ангийн гишүүдэд төдийгүй идэвхжүүлэхийг хүсч буй саяхны хөрвөгчдөд туслах явдал байлаа. Бид сайн мэдээгээр бүрэн дүүрэн амьдарсан үед хэн нэгэн нь шууд буюу шууд бусаар адислагддаг. Энэ шалтгааны улмаас сайн мэдээнээс суралцах болон заах нь нэн өвөрмөц онцлогтой юм. Сайн мэдээнээс суралцах нь хүнийг зөвхөн мэдлэг эзэмшихэд төдийгүй бас хөрвөлт рүү хөтөлдөг.



Хэрэв Аврагч Хичээлийн танхимд байсан бол яаж заах байсны адилаар заахад хайр бидэнд тусалдаг.

Хайр бол хөрвөлтийн хөдөлгөгч хүч

Би Перуд ням гарагийн хичээлд сууж байхдаа тэр багш хичээлдээ ирсэн болон идэвхжүүлэхийг ангийн гишүүдээс хүссэн саяхны хөрвөгчдийг аль алиныг нь хайрладаг болохыг мэдэрсэн юм. Хичээлийн танхимд хайр нь багшаас суралцагчид, суралцагчаас багшид, нэг суралцагчаас нөгөөд, нийт суралцагчдаас саяхны хөрвөгчдөд гэхчлэн шилжиж байх шиг мэдрэгдэж билээ.

Хэрэв Аврагч хичээлийн танхимд байсан бол яаж заах байсны адилаар заахад хайр бидэнд тусалдаг. “Хичээлдээ няхуур бэлтгэж, үр өгөөжтэй заахад чухамдаа хайр бидний хөдөлгөгч хүч болдог билээ.”³

Багш нар хичээл заахдаа суралцагч бүрийн хэрэгцээг харгалзахаас илүүгээр хичээлийн материал дээр анхаарлаа төвлөрүүлдэг. Перугийн тэр багш хичээлийн бүх материалыг *заах* гэж хичээх хэрэггүйг харуулсан юм. Тэрээр ах эгч нартаа хайраар туслахад нь ангийн гишүүдэд сүнслэгээр нөлөөлөхийг л хүссэн. Их Эзэнийг хайрлах хайр, бие биеэ хайрлах хайр хичээлийн танхимд чиглүүлэгч хүч болж байлаа. Хайр тэр хичээлийн хөдөлгөгч хүч байлаа. Хайр бидний хөдөлгөгч хүч болсон үед Их Эзэн хүүхдүүддээ туслах зорилгоо хэрэгжүүлэхийн тулд бидэнд хүч чадал өгөх болно. Бид багшийн хувьд *юуг хэрхэн* заахад Тэрбээр бидэнд сүнслэгээр нөлөөлөх болно.

Сургаал бол хичээлийн түлхүүр

Перугийн багш хичээлээ заахдаа гарын авлагаас уншуулсангүй. Тэр багш хичээлдээ бэлтгэхдээ гарын авлага, чуулган дээр хэлсэн үгсийг ашиглаад харин хичээлээ судруудаас заадаг юм байна гэдэгт би итгэсэн. Тэр төөрсөн хонины тухай түүхийг дурдаад дараах шүлгийг уншиж билээ: “Чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” (Лук 22:32).

Сайн мэдээ-
нээс сурал-
цах болон заах нь
мэдээ баримтуу-
дыг мэдэж эзэм-
ших явдал биш
харин Христийн
шавь нар боло-
ход суралцах
явдал мөн.

Замаасаа хазайсан хүмүүсийг аврахад Сүмийн бүх гишүүдийг урьсан Ерөнхийлөгч Монсонгийн урилгыг тэр хуваалцсан. Энэ хичээлийн гол сургаал нь итгэл, энэрэл байлаа. Үгийг үйлдэл болгох хангалттай итгэл ангийн гишүүдэд хэрэгтэй байлаа. Тиймээс тэд үйлдлээ хайраар хэрэгжүүлэх хэрэгтэй байв.

Есүс Христийн сэргээгдсэн сайн мэдээний сургаалыг амьдралын тодорхой жишээн дээр итгэл үнэмшилтэйгээр заасан үед Их Эзэн багш, суралцагч хоёуланд нь хүч чадал өгдөг. Ангийн гишүүд идэвх султай ах эгч нартаа туслах саналуудыг гаргах тусам дэлхийн үйлчлэлийнхээ үед бусдад үргэлж тусалдаг байсан Аврагчид улам ойр дотно болж байлаа. Сургаал бол сайн мэдээнээс үр ашигтай суралцах болон заах түлхүүр юм. Мөн энэ нь зүрх сэтгэл, оюун ухааныг нээдэг түлхүүр юм.

Энэ түлхүүр хичээлд оролцсон хүн бүрт сүнслэгээр нөлөөлөх замыг Бурханы Сүнсэнд нээж өгдөг.

Сүнс бол хичээл дээрх жинхэнэ багш нь

Сайн мэдээний хамгийн шилдэг багш нар өөрсдийгөө хичээл дээрх жинхэнэ багш нар гэж үздэггүй. Сайн мэдээг Сүнсээр дамжуулан зааж, Сүнсээр дамжуулан суралцаж ойлгодог билээ. Сүнсгүйгээр сайн мэдээний үнэнүүдийг заах нь сурч, мэдэхэд хөтөлдөггүй (С ба Г 42:14-ийг үз). Багш үгийг үйлдэл болгох сүнслэг нөлөө бүхий урилгыг хэдий чинээ их өгнө, хичээл дээр Сүнс төдий чинээ их байх болно. Перугийн багш сүнслэг нөлөө бүхий урилгыг суралцагчдадаа өгснөөр ангийн гишүүд идэвх султай ах, эгч нараа идэвхжүүлэх саналаа хэлэхэд Сүнсийг мэдрэх нь улам өсөн нэмэгдэж, хүн бүрд хүч чадал өгч байлаа.

Тэр багш хичээлийн бүх материалыг нэгд нэгэнгүй *заахыг* хичээсэнгүй. Харин суралцагчдын мэддэг зүйлийг идэвх султай ах эгч нараа сүмд эргүүлж авчрах *үйлдэл болгохыг* хичээсэн юм. Ангийн гишүүдийг Сүнсний хүчээр дамжуулан урьснаар багш үг яриаг үйлдэл болгох буюу ах, эгч нартаа хайраар туслах хүслээ хэрэгжүүлэхэд тэдэнд тусалсан. Ангийн гишүүд санаа бодлоо хуваалцсанаар бие биедээ сүнслэгээр нөлөөлсөн. Учир нь тэд Сүнсээр улам ойртон нэгдэж байлаа.

Бид эргэн тойрныхоо хүмүүст тусалж, сайн мэдээгээр амьдрахыг хичээвэл Их Эзэн бидний хийх ёстой зүйлд сүнслэг нөлөө үзүүлэх болно. Хичээлийн танхимд Сүнсний аль болохоор их байлгах нь багш нар бидний үүрэг мөн. Иймд бид ангийн гишүүдийг сайн мэдээгээр улам бүрэн дүүрэн амьдрахыг урих хэрэгтэй. Бид сайн мэдээний аль нэг зарчмаар



бүрэн дүүрэн амьдрах шийдвэр төгс байвал Бурханд улам ойртож, Бурхан бидэнд улам ойртох болно (С ба Г 88:63-ыг үз).

Суралцагч бүрийн чадавхийг дайчил

Бид сайн мэдээг зөвхөн мэдлэг олгох зорилгоор заадаггүй мөн ийм зорилгоор ч суралцдаггүй. Харин өргөмжлөлд хүрэхийн тулд сайн мэдээг зааж, үүнд суралцдаг. Сайн мэдээнээс суралцах болон заах нь мэдээ баримтуудыг мэдэж эзэмших биш харин Христийн шавь нар болоход суралцах явдал мөн. Бид гэртээ хүүхдүүдэд эсвэл тойрог, салбарын гишүүдэд анги танхимд зааж байна уу ялгаагүй хичээл маань л суралцагчийн сэтгэлд хоногшин үлдэх ёстойг санах хэрэгтэй. Эцэг эх, багш байх бидний үүрэг бол зүрх сэтгэлийн мэдрэмж, оюун ухааны чадавхаа

илрүүлж, үйлдэл болгоход нь суралцагчдад туслах явдал мөн.

Бид суралцагч бүрийн гайхалтай чадварыг хүлээн зөвшөөрснөөр тэднийг Бурхан яаж хардагтай адилаар харж эхэлдэг. Ингэсэн тохиолдолд Түүний хэлүүлэхийг хүссэн зүйлийг бид хэлж чадна мөн Түүний хийлгэх гэсэн зүйлийг бид хийж чадна. Бид суралцах болон заах энэхүү замаар замнасан үед хөрвөлт бидний зорилго, хайр биднийг хөдөлгөгч хүч, сургаал энэ бүхний түлхүүр, Сүнс багш нь байх болно. Бид ийнхүү суралцаж, заасан үед “бүгдээрээ бүхнээс сэнхэрсэн байж болохын тулд” (С ба Г 88:122) Их Эзэн багш, суралцагч хоёуланг нь адислах болно. ■

Эшлэл

1. Томас С.Монсон, Conference Report, 1970 оны 10-р сар, 107.
2. Далин Х.Өүкс, “The Challenge to Become,” *Лиакхона*, 2001 оны 1-р сар, 40–43-ыг үз.
3. *Teaching, No Greater Call* (1999), 32.

Хичээлийн
Хтанхимд
Сүнсийг аль болохоор их байлгах нь багш нар бидний үүрэг мөн. Иймд бид ангийн гишүүдийг сайн мэдээгээр улам бүрэн дүүрэн амьдрахыг урих хэрэгтэй.





ГАР ГЭЭГТЭЙ АНХДАГЧИД, МИННЕРВА ТЕЙЧЕРТ © IRI, СУМИЙН ТУУХИЙН МУЗЕЙН ЗӨВШӨӨРЛӨӨР НИЙЛЛЭВ



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч
Л.Том Перри

Бүдний ӨВИЙН ХҮЧ НӨЛӨӨ

*Анхдагчдын итгэл аль ч үед хэрэгтэй
байсан шигээ өнөөдөр ч хэрэгтэй байна.*

Би анхдагчдын түүхүүдийг сонсоод үргэлж сэтгэл догдолдог билээ. Намайг бага байхад эмээ маань зэргэлдээ хаалганд амьдардаг байв. Эмээ найман настай байхдаа хээр талын ихэнхийг явганаар туулсан гэдэг. Эмээгийнхээ дэргэд олон цаг сууж, яриаг нь сонсох үед тэрээр анхдагчдын гайхалтай түүхүүдээр намайг гайхан бишрүүлдэг байж билээ.

Ерөнхийлөгч Бригам Янг (1801–1877) бол миний шүтэн биширдэг онцгой баатруудын нэг юм. Аливаа асуудалд өгсөн түүний хариулт голыг нь олсон, оновчтой бөгөөд үргэлж хүмүүст ашиг тусаа өгдөг байлаа. Гэгээнтнүүдийг өрнөд рүү удирдах үеийн түүний өөдрөг сэтгэл, урам зоригийг би гайхан биширдэг.

Европоос шинэ хөрвөгчид Ютад шилжиж ирэх зардал хүч хүршгүй болсон үед гэгээнтнүүд гар тэргээр ачаагаа түрж, уудам хээр талыг туулж болох юм гэсэн санаа

Ерөнхийлөгч Янгд төрсөн ажээ. Хүмүүс агуу зориг хатуужил, амьдрах чадвартайгаа харуулан, алс хол газрыг явган туулж, Солт Лейк хотод ирэх нь зөвхөн зардал хэмнэх төдийгүй, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх давуу талтайг Ерөнхийлөгч Янг олж харсан байлаа. Тэрбээр ийн хэлжээ:

“Тэргээ түрж цуваагаар явах нь үхэр тэргээр явснаас хурдан байх болно гэдэгт бид итгэлтэй байна. Саах хэдэн сайн үнээ, хүнсэнд хэрэглэх махны хэдэн үхэр авч явах хэрэгтэй. Гарз хохирол, эрсдэл ихтэй энэ аянд саад бэрхшээл, гай зовлон, өвчин эмгэг зайлшгүй тохиолдоно. Бид ах эгч нараасаа олныг нь хүнд хүчир аяны үед алдаж мэдэх ч гэгээнтнүүд энэ бүхнийг амжилттай даван туулах болно.

Бид дээрх зөвлөгөөг газар дээр нь хэрхэн хэрэгжүүлж болохыг магадлахын тулд итгэлтэй бөгөөд туршлагатай хүмүүст зохих заавар өгч, тэднийг илгээхээр төлөвлөж

*Анхдагчдын
итгэл аль ч үед
хэрэгтэй байсан
шигээ өнөөдөр
ч хэрэгтэй. Бид
энэхүү өвийг
мэдэх хэрэгтэй
байна. Бид энэ
өвийг зааж,*

байна. Иймд ирэх жил аян замд гарахаар зэхэж буй гэгээнтнүүд хээр талыг ачаагаа түрж явганаар туулах болно гэдгийг ойлгог. Өөр ямар ч арга байхгүй тохиолдолд тэдэнд [Цагаачлалын Тасралтгүй] сангаас тусламж үзүүлэх болно.”¹

1856–1860 онд хэдэн мянган Гэгээнтэн тэрэгтэй ачаа хөсгөө гараараа түрж, 1,300 бээр (2,090 км) газрыг амжилттай туулжээ. Зөвхөн хоёрхон баг—Вилли болон

тэрээр хүссэн юм. Тэгээд юу болсныг харъя.

Туслах эхний баг ердөө маргааш нь буюу даваа гарагт аян замд гарчээ. Тусламжийн эхний баг хүрч ирэхэд Виллигийн багийнхан хэчнээн их баярлан, сэтгэл догдолсныг дүрслэхийн аргагүй юм. Багийн ахмад Вилли цөөхөн хүнтэй бүлгээ орхин, тусламжийн цувааг угтахаар нэг хүнтэй хамт явсан ажээ.

Түүхийн баримтад өгүүлсэн нь: Ахмад Виллиг явснаас хойш гурав дахь өдрийн орой алс тэртээх толгодын цаагуур нар үзэсгэлэнтэйгээ жаргах үеэр манай буудлаас чанх баруунтаа нэг жижигхэн гүвээн дээр дөрвөн моринд хөллөсөн, бүтээлэгтэй ачаатай нэлээд хэдэн морин тэрэг биднийг чиглэн ирж явлаа. Энэ мэдээ өвсөнд ассан түймэр лүгээ адил тэр дорхноо буудал даяар тархаж, орноосоо босч чадах бүхэн тэднийг харахаар *олноороо* гадаа гарчээ. Тэд хэдэн минутын дараа цувааг нэлээд ойртсон үед итгэлт ахмад нь цувааны түрүүнд ирж явааг харжээ. Баярлан хашгирах чимээ буудлыг тэр чигт нь доргиож, нүүрэндээ үрчлээтэй, наранд борлосон хүдэр чийрэг эрс нулимс урсган уйлж, бяцхан хүүхдүүд юу болоод байгааг сайн ойлгохгүй, зарим нь баярласандаа дэвхцэн бүжиглэж бай-



*үүгээр бахархан,
хойч үедээ
хадгалж үлдээх
хэрэгтэй.*

Мартинь багууд өвөл эрт орсон цасанд боогдож, аянаа амжилттай дуусгаж чадаагүй юм. Ерөнхийлөгч Янг тэднийг аврахад онцгой үүрэг гүйцэтгэсэн билээ. Тэрбээр 1856 оны аравдугаар сарын ерөнхий чуулганыг гай зовлон тохиолдсон эдгээр Гэгээнтнүүдэд туслахад бүхэлд нь зориулсан юм. Зовж зүдэрсэн гэгээнтнүүдэд туслахын тулд сар байтугай долоо хоног ч хүлээлгүй үтэр түргэн хөдлөхийг тэрээр ах нарт зааварлажээ. Цасанд боогдож, амь нас нь хутганы ирэн дээр байгаа Гэгээнтнүүдэд туслахын тулд дараагийн өдөр буюу даваа гарагт дөрвөлсөн морин тэрэг нэлээд хэдийг аян замд гарахад бэлэн болгохыг

лаа. Ах нарыг буудалд хүрч ирэхэд баяр хөөрөөр дүүрч эгч нар тэднийг тэврэн дахин дахин үнсэж байлаа. Ах нар ярьж ч чадахгүй, хэсэг хугацаанд чимээгүйхэн мэгшин уйлав. . . . Гэвч удалгүй сэтгэл хөдлөл арай намдаж, хүмүүс гар барин мэндэлж, ийнхүү ховорхон тохиох Бурханы адислал гэнэт тэдэн дээр юүлэгдсэнд баяр талархлын үгс урсган, даруухнаар залбирч эхэллээ!”²

Бат бөх гэр бүлүүдийг төлөвшүүлэх нь

Нэгдсэн Улсын өрнөд хэсэгт болон дэлхийн бусад хэсэгт улс нийгэмдээ их хувь нэмэр оруулсан, одоо оруулж байгаа бат бөх

гэр бүлүүдийг бий болгон төлөвшүүлсэн уламжлал нь эдгээр хүчирхэг анхдагчдаас эхлэлтэй юм.

Хэдэн жилийн өмнө би Солт Лейкийн бүсэд дөрвөн дэлгүүр нээсэн жижиглэнгийн худалдааны компаний ивээн тэтгэсэн зоогонд уригдсан. Жижиглэнгийн худалдааны туршлагатай хүний хувьд би шинэ зах зээлд нэг зэрэг дөрвөн дэлгүүрийг яасан зоригтой нээж байгаа юм бэ хэмээн нэг ширээнд сууж байсан компаний ерөнхийлөгчөөс асуув. Түүний хариулт яг миний бодож байсан шиг байлаа. Түүний компани Нэгдсэн Улсын бүх том хотуудын бүсэд хүн амын судалгаа хийсэн гэж тэр хэллээ. Тэр компани залуу гэр бүлүүдэд үйлчлэх их дэлгүүр нээхэд хамгийн их боломжтой газрыг эдгээр бүсүүдээс тогтоох зорилго тавьсан гэнэ. Эхэн үеийн анхдагчдын зорьж ирсэн нутаг Солт Лейкийн бүс улс орон даяар хийсэн судалгаанд тэргүүн байр эзэлсэн ажээ.

Тус компаний хийсэн судалгаа Солт Лейкийн бүс дэх ажиллах хүч хэр үнэнч шударга, хөдөлмөрч болохыг бас тогтоосон гэнэ. Анхдагчдын өв энэ бүс нутагт гурав дахь, дөрөв дэх үеийнхэнд нь уламжлагдан ирснийг харж байгаа биз дээ.

Гэвч саяхан ирсэн статистикийн мэдээг үзээд би балмагдав. Өнөөдөр Нэгдсэн Улсад бүх хүүхдийн дөнгөж 7 хувь нь эцэг нь ажил хийдэг, эх нь гэртээ үр хүүхдээ өсгөн хүмүүжүүлдэг нэг буюу түүнээс олон хүүхэдтэй гэр бүлд өсөн хүмүүжиж байгаа ажээ.³ Уламжлалт гэр бүл алга болж байгаагийн уршигт үр дагаврыг бид өдөр бүр харж байна. Хүчирхийлэлд өртсөн эхнэрүүд, бие бядрын болон бэлгийн хүчирхийллийн золиос болсон хүүхдүүд, сургуулийн сурагчдын бүдүүлэг зан авир, өсвөр үеийнхний дундах гэмт хэрэг, гэрлээгүй залуу эмэгтэйчүүдийн жирэмслэлт, үр хүүхэд, ач зээ нарынхаа зулай үнэрлэлгүй өтөлж байгаа хүмүүсийн тоо өсөн нэмэгдэж байгаа нь сэтгэл түгшээж байна.

Гэр бүл бол нийгмийг аврах үндсэн газар гэдгийг бошиглогчид бидэнд анхааруулсаар байгаа билээ.⁴ Залуу эрэгтэй, эмэгтэй

хоёр бие биедээ хайр сэтгэлтэй болж гэрлэснээр төлөв төвшин гэр бүл аяндаа бий болдоггүй. Энэхүү өв нь анхдагчдын гэр оронд хэвшил болон тогтсон итгэл бишрэл, эрэлхэг зориг, сахилга бат, чин үнэнч зүрх сэтгэл зэрэг гэр бүлийг бат бөх болгодог үнэт зүйлс юм. Анхдагчид цөлийг цэцэглэж буй сарнай лугаа адил болгосон шиг бид тэдний үнэт зүйлс болон уламжлалыг өвлөн авч хэрэгжүүлбэл амьдралаа өөд татаж чадна. Тийм ээ, анхдагчдын итгэл аль ч үед хэрэгтэй байсан шигээ өнөөдөр ч хэрэгтэй. Бид энэхүү өвийг эдүгээ шинээр нээж ойлгох хэрэгтэй байна. Бид энэ өвийг зааж, үүгээр бахархан, хойч үедээ хадгалж үлдээх хэрэгтэй.

Бид маш их адислагдсан хүмүүс! Анхдагчдын тухай бидний мэдлэг хийгээд ойлголт үүрэг хариуцлагыг дагуулдаг. Америкийн агуу гольф тоглогч Арнольд Пальмер, “Ялалт биш, харин ялах хүсэл бүх зүйл мөн” хэмээн хэлсэн гэдэг. “Ялах хүсэл” гэгч хэчнээн агуу үг билээ.


Бурханаас хүүхдүүддээ өгсөн бүх бэлгээс хамгийн агуу нь болох мөнх амьдралын бэлгийг олж авах хүсэлтэй байхыг Бурхан бидэнд соёрхох болтугай. Бурханаас Өөрийн хүүхдүүд бидэнд соёрхсон агуу бэлгүүдийг мэдэж, өөрсдийн чадавхийг ойлгон, бидэнд уламжлагдаж ирсэн өвийг судлан мэдэж, хөгжүүлэх бэлгээр Тэр биднийг адислах болтугай. Бурхан амьд, Есүс бол Христ, Түүний зам биднийг мөнх амьдрал өөд хөтлөх болно гэдгийг би хүндэтгэлтэйгээр гэрчилж байна. ■

Бригам Янгийн Их Сургууль дээр 1980 оны 8-р сарын 3-нд болсон галын дэргэдэх ярилцлага дээр хэлсэн үгнээс. Англи хэлээрх бүрэн эхийг <http://speeches.byu.edu>-оос үзнэ үү.

ЭШЛЭЛ

1. Бригам Янг, В.Н. Roberts, *A Comprehensive History of the Church*, 4:85.
2. Жон Числет, *A Comprehensive History of the Church*, 4:93–94.
3. Population Reference Bureau, www.prb.org/Articles/2003/TraditionalFamiliesAccountforOnly7PercentofUSHouseholds.aspx-ийг үз. 1980 онд энэхүү захиасыг тараах үед энэ нь 13% байсан.
4. Жишээ нь, Томас С. Монсон, “Heavenly Homes, Forever Families,” *Лиахона*, 2006 оны 6-р сар, 66–71; Спенсер В. Кимбалл, “Home: The Place to Save Society,” *Ensign*, 1975 оны 1-р сар, 3–10.

Энэхүү өв нь анхдагчдын гэр оронд хэвшил болон тогтсон итгэл бишрэл, эрэлхэг зориг, сахилга бат, чин үнэнч зүрх сэтгэл зэрэг гэр бүлийг бат бөх



болгодог үнэт зүйлс юм. Анхдагчид цөлийг цэцэглэж буй сарнай лугаа адил болгосон шиг бид тэдний үнэт зүйлс болон уламжлалыг өвлөн авч хэрэгжүүлбэл амьдралаа өөд татаж чадна.

Бурхантай ГЭРЭЭНҮҮДЭЭ ОЙЛГОХ НЬ

БИДЭНД ӨГСӨН
ХАМГИЙН ЧУХАЛ
АМЛАЛТУУДЫН
ТОЙМ



“Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд бид ариун гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандаж, эдгээрт чин үнэнч байх нь аз жаргалд хүрэх шаардлага мөн. Тийм ээ, би баптисмын гэрээ, санваарын гэрээ түүнчлэн гэрлэлтийн гэрээг жишээ болгон хэлж байна” хэмээн Ерөнхийлөгч Томас С.Монсон тайлбарлажээ.¹

Сүм дэх ёслол бол санваарын эрх мэдлээр албан ёсоор гүйцэтгэгддэг ариун зан үйл юм. Зарим ёслол бидний авралд нэн чухал юм. Бид эдгээр “авралын ёслолуудыг” хүлээн авснаар Бурхантай ариун гэрээ байгуулдаг.²

Гэрээ бол нөхцөлийг нь Бурхан тогтоосон хоёр талын амлалт юм.³ Бид Бурхантай гэрээнд орсноор гэрээний нөхцөлүүдийг биелүүлэхээр амладаг бол Тэрбээр хариуд нь тодорхой адислалуудыг бидэнд амладаг билээ.

Бид авралын ёслолуудыг хүлээн авч, эдгээртэй холбоотой гэрээнүүдийг сахих юм бол Есүс Христийн

Цагаатгал бидний амьдралд үр нөлөөгөө өгч, бид Бурханы хамгийн агуу адислалыг хүлээн авч Тэрбээр бидэнд мөнх амьдралыг соёрхох болно (С ба Г 14:7-г үзнэ үү).

Гэрээнүүдээ сахих нь энэ амьдрал дахь бидний аз жаргалд амин чухлаас гадна үүний ачаар бид эцэстээ мөнх амьдралтай болох учраас Тэнгэрлэг Эцэгтээ хийсэн амлалтуудаа ойлгодог байх нь чухал юм. Доор дурдсан зүйлс бол авралын ёслолуудтай холбогдуулан бидний хийдэг гэрээнүүдийн тойм болон хаанаас та нар энэ талаар илүү ихийг мэдэж болох тухай зөвлөмж юм.

Баптисм болон гишүүний баталгаа

Эрх мэдэлтэй хүнээр хийлгэсэн усанд умбуулах баптисм бол сайн мэдээний авралын анхдагч ёслол бөгөөд Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүн энэ ёслолыг заавал хийлгэх ёстой. Баптисмаас салгаж үл болох, үүнтэй хамт гүйцэтгэдэг ёслол бол гар



тавилаар Ариун Сүнсний бэлэг олгож, гишүүнээр батлах ёслол юм.

Бид баптисм хүртсэнээр Есүс Христийн нэрийг өөр дээрээ авч, үргэлж Түүнийг санан, зарлигуудыг нь сахих гэрээ хийдэг. Бид бас “эцсийг хүртэл түүнд үйлчлэхээр” (С ба Г 20:37; мөн Мозая 18:8–10-ыг үз) амладаг.

Хэрэв бид нүглээ наманчилбал Тэнгэрлэг Эцэг хариуд нь биднийг уучилж, (Алма 7:14-ийг үз), “Өөрийн Сүнснийг [бидэнтэй] үргэлж байлгах” (С ба Г 20:77) амлалт өгдөг бөгөөд Ариун Сүнсний бэлгээр дамжуулан энэхүү амлалт хэрэгждэг билээ.

Баптисм болон гишүүний баталгааны ёслол нь мөнх амьдралыг өвлөн авахыг хүсдэг хүн бүхний дамжин орох ёстой хаалга мөн (Иохан 3:3–5-ыг үз). Баптисмын гэрээндээ хүндэтгэлтэй хандах нь мөнх амьдралын зам руу хөтлөгч авралын бусад бүх ёслолоос ирдэг гэрээнүүд рүү чиглүүлдэг бөгөөд эдгээр гэрээний чухал хэсэг юм (2 Нифай 31:17–21-ийг үзнэ үү).

БАПТИСМЫН ТУХАЙ УЛАМ ИХИЙГ МЭД

Роберт Д.Хейлс, “The Covenant of Baptism: To Be in the Kingdom and of the Kingdom,” Лиахона, 2001 оны 1-р сар, 6.

Ариун ёслол

Баптисмын болон гишүүнээр батлагдах авралын ёслолуудыг хүлээн авсан хүмүүс гэрээнүүдээ шинэчлэхийн тулд долоо хоног бүр ариун ёслолоос хүртдэг. Бид талх, уснаас хүртэхдээ өөрсдийнхөө төлөө хийсэн Аврагчийн золиослолыг санадаг. Түүнээс гадна, бид Есүс Христийн нэрийг өөр дээрээ авч, үргэлж Түүнийг санан, зарлигуудыг нь сахих талаар хийсэн гэрээнүүдээ тунгаан боддог. Үүний хариуд Бурхан

Гэрээ бол хоёр талын амлалт. Гэрээ хийх үед хүлээн авсан нөхцөлүүдээ биелүүлсний хариуд Бурхан бидэнд тодорхой адислалуудыг амладаг.

Өөрийн Сүнснийг бидэнтэй үргэлж хамт байлгах амлалтаа сунгадаг (С ба Г 20:77, 79-ийг үзнэ үү).

Ариун ёслол бол Аврагчийн цагаатгагч ач ивээлийг хүртэгчид байх боломжийг бидэнд олгодог ариун гэрээнүүдээ долоо хоног бүр шинэчлэх боломж мөн. Энэ нь сүнслэг байдлын хувьд ариусгагч үр нөлөөгөөрөө баптисм ба гишүүний баталгаатай адил юм.

Бид ариун ёслолоос хүртсэнээрээ зөвхөн баптисмын гэрээгээ төдийгүй “Их Эзэнтэй хийсэн бүх гэрээгээ” шинэчилдэг.⁴

АРИУН ЁСЛОЛЫН ТУХАЙ УЛАМ ИХИЙГ МЭД.

Даллин Х.Өүкс, “Sacrament Meeting and the Sacrament,” Лиахона, 2008 оны 11-р сар, 17-г үзнэ үү.

Санваарын тангараг ба гэрээ

Санваар хүлээн авснаар ирдэг гэрээнүүдээ сахьдаг санваартнуудад тодорхой адислалууд өгөхөө Тэнгэрлэг Эцэг андгайлдаг (баталгаа өгдөг).

Эрэгтэйчүүд Аароны болон Мелкизедек санваар авахаар зохистой амьдарч, “дуудлагаа эрхэмлэн биелүүлбэл,” “биеэ шинэчлэхэд нь [тэднийг] Сүнсээр ариутгах” болно хэмээн Бурхан амладаг. Тэд Мосе, Аарон, Абрахам нарт өгсөн амлалтуудыг өв залгамжлан авах болно. (С ба Г 84:33–34-ийг үзнэ үү.)

Эрэгтэйчүүд Мелкизедек санваартай байх нь ариун сүмд ороход зайлшгүй шаардлагатай. Ариун сүмд гэрлэснээр эрэгтэй, эмэгтэйчүүд санваарын бүрэн адислалуудыг хүлээн авдаг.

Бүх хүмүүс санваарын аврагч ёслолуудыг хүлээн авснаар “Эцэгт байгаа бүхнийг” өвлөн авна гэсэн амлалт

АСУУЛТУУДАД ХАРИУЛАХ НЬ

Та өөрөө болон таны харилцаатай байдаг хэн нэгэн чинь “Ариун сүмүүдийг яагаад олон нийтэд нээлттэй болгож болдоггүй юм бэ?” гэж бодож болно. ХҮГ-дийн ариун сүмүүдийг бүх хүмүүст зориулсан ариун ёслолын цуглаан болох ням гарагийн шүтлэг бишрэлийн үйл ажиллагаанд зориулан ашигладаггүй. Ариун сүмүүдэд эрхэм нандин ёслолууд гүйцэтгэгддэг учраас эдгээр ёслолуудыг хүлээн авахад өөрийгөө тэнцэхээр болгосон гишүүдэд баптисм хүртээхийн тулд ариун сүмүүд үйл ажиллагаа явуулдаг.

Шинэ ариун сүм баригдсаны дараа тухайн ариун сүмийн нээлтийн үйл ажиллагааны үеэр олон нийтэд үзүүлдэг. Ариун сүмийг Их Эзэнд онцгойлон адисалсны дараа ариун сүмийн гаднах талбайг олон нийтэд үзүүлж болно. Харин ариун сүм нь зөвхөн ариун сүмийн хүчинтэй эрхийн бичигтэй хүмүүст нээлттэй байдаг.

Нэмэлт мэдээллийг Mormon.org-оос “Temples” гарчгийн доорх олон удаа асуудаг асуултууд дотроос үзнэ үү.

Тэдэнд биелэгдэх болно (С ба Г 84:35–38-ыг үзнэ үү).

“Энэхүү амлалт хийгээд гэрээнээс урьд хожид үзэгдээгүй олон адислал дэлхий даяарх эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд, хүүхдүүдэд ирнэ” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Рассел М.Нелсон заажээ.⁵

САНВААРЫН ТАНГАРАГ БА ГЭРЭЭНИЙ ТУХАЙ УЛАМ ИХИЙГ МЭД

Хенри Б.Айринг, “Faith and the Oath and Covenant of the Priesthood,” *Лиахона, 2008 оны 5-р сар, 61-ийг үзнэ үү.*

Ариун сүмийн хишиг

Ариун сүмийн хишиг бол хүч хийгээд мэдлэг авчирдаг бэлэг юм.

Бид ариун сүмийн хишиг хүртэх үед мөнхийн өргөмжлөлтэйгөө холбоотой заавруудыг авч, гэрээнүүдийг хийдэг. Угаалгын, тос түрхэлтийн болон ариун гэрээнүүдийн сануулагч болох ариун сүмийн гарментаар хувцаслах зан үйл бол хувийн хишигтэй холбоотой ёслолууд юм.⁶ Ариун сүмийн ёслолууд ариун нандин учраас ариун сүмээс гадуур нарийвчлан ярилцдаггүй. Үүний улмаас Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Боид К.Пакер, “Эдгээр ёслолуудыг гүйцэтгэх үед амлагдаг адислалууд болон тэдгээр нь ямар нөхцөлд биелэгдэхийг та бүхэн анхааралтай сонсох нь чухал” хэмээн зөвлөжээ.⁷

Эсэргүүцлийг ялж, Сүмийг хөгжүүлэх бурханлаг хүчийг хүлээн авах түлхүүр бол “ариун сүмд бидний хийдэг гэрээ юм. Энэ гэрээгээр бид Тэнгэрлэг Эцэгийг дуулгавартай дагаж, Түүнд бие сэтгэлээ зориулан, золиослол хийх үүрэг хүлээдэг бол Тэр биднийг агуу хувийн хишгээр адислах амлалт өгдөг” хэмээн Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд заажээ.”⁸

Бид дараах зүйлсийг судалснаар хувийн хишиг хүлээн авах үед хийдэг гэрээнүүдэд агуулагддаг зарчмуудын тухай дэлгэрэнгүй мэдэж чадна:

- “Дуулгавартай байдал,” *Сайн мэдээний зарчмууд* (2009), 221–227.

- М.Рассел Баллард, “The Law of Sacrifice,” *Лиахона*, 2002 оны 3-р сар, 10.
- On “the law of [the] gospel” (С ба Г 104:18), Сургаал ба Гэрээ 42-ыг үзнэ үү.
- “Ариун явдлын хууль,” *Сайн мэдээний зарчмууд* (2009), 249–257.
- Д.Тодд Кристофферсон, “Reflections on a Consecrated Life,” *Лиахона*, 2010 оны 11-р сар, 16.

ХУВИЙН ХИШГИЙН ТУХАЙ УЛАМ ИХИЙГ МЭД

Preparing to Enter the Holy Temple (2002), 28–35; Давид А.Беднар, “Honorably Hold a Name and Standing,” *Лиахона*, 2009 оны 5-р сар, 97-г үзнэ үү.

Лацдалт

“Ариун сүмийн гэрлэлт” буюу “лацдалт” гэгддэг ариун сүмийн ёслол нь хэрэв гэр бүлийн хос итгэлтэй байх юм бол үхлийн дараа эхнэр, нөхөр хоёрын хооронд үүрд мөнх үргэлжлэх харилцааг бий болгодог. Эцэг эх, хүүхдийн харилцаа нь мөнх бус амьдралын дараа үргэлжилж, олон үеийнхнийг мөнхийн гэр бүлийн харилцаанд нэгтгэж чадна.

Хувь хүн ариун сүмд гэрлэлтийн гэрээг Бурхантай *болон* нөхөр буюу эхнэртэйгээ хийдэг. Гэр бүлийн хос бие биедээ болон Бурханд үнэнч итгэлтэй байхаар амладаг. Өргөмжлөл болон үүрд мөнх үргэлжлэх гэр бүлийн харилцааг Бурхан тэдэнд амладаг билээ (С ба Г 132:19–20-ийг үзнэ үү). Ариун сүмд лацдан холбуулсан гэр бүлийн хост төрсөн хүүхдүүд эсвээс хожим нь эцэг эхтэйгээ лацдан холбуулсан хүүхдүүд мөнхийн гэр бүлийн гишүүд байх эрхтэй юм.

Бид бусад ёслолуудын нэгэн адил, гэрээнүүддээ үнэнч байснаар дэлхий дээрх лацдалтын ёслолыг Амалтын Ариун Сүнс тэнгэрт хүчинтэй болгодог.⁹ Эхнэр буюу нөхөр нь лацдан холболтын амлагдсан адислалуудаа аддлаа ч гэсэн гэрээнүүдээ чанд сахьдаг хүмүүс байдаг.

ЛАЦДАЛТЫН ТУХАЙ УЛАМ ИХИЙГ МЭД

Рассел М.Нелсон, “Generations Linked in Love,” *Лиахона*, 2010 оны 5-р сар, 91-ийг үз.



Ариун гэрээнүүд хийж, сахих нь

Бид эдгээр чухал гэрээнүүдийг хийснээр шинэ бөгөөд үүрдийн гэрээг, “бүр [Есүс Христийн сайн мэдээний] бүрэн байдлыг хүлээн авагчид болдог билээ” (С ба Г 66:2). Шинэ бөгөөд үүрдийн гэрээ нь бидний хийдэг сайн мэдээний бүх гэрээнүүд болон хүлээдэг үүргүүдийн нийлбэр бөгөөд¹⁰ Эцэгт байдаг бүхэн, түүний дотор мөнх амьдралын адислалууд энэхүү гэрээнээс үүдэлтэй юм.

Бид гэрээнүүдээ ойлгож, сахих нь хийх ёстой юмсын зүгээр нэг жагсаалт биш харин Аврагчтай адилхан болох шийдвэр төгс хүсэл эрмэлзэл гэдгийг санах ёстой.

“Эцсийн Шүүлт бол бидний хийсэн бүх сайн, муу үйлст үнэлэлт өгөх явдал биш гэж Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Даллин Х.Өүкс заажээ. Энэ бол бидний үйл хэрэг, бодол санаа буюу бид ямар хүмүүс болсны эцсийн үр дүн юм. Ямар нэг зүйлийг үл суурьтай бодохгүйгээр хийх нь сайн үр дүнд хүргэдэггүй. Зарлигууд, сайн мэдээний ёслолууд болон гэрээнүүдийг чанд сахих нь тэнгэр дэх гэртээ эргэж очихын тулд бид бүхний зайлшгүй хийх ёстой зүйл мөн. Есүс Христийн сайн мэдээ бол Тэнгэрлэг



Бид гэрээнүүдээ биелүүлснээр Аврагчтай адил чин хүсэл эрмэлзэлтэй болдог.

Эцэг биднийг ямар хүмүүс болохыг хүсэн хүлээдэг шиг тийм хүмүүс хэрхэн болохыг бидэнд харуулдаг төлөвлөгөө юм.”¹¹ ■

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Happiness—the Universal Quest,” *Лиахона*, 1996 оны 3-р сар, 5; *Ensign*, 1993 оны 10-р сар, 4.
2. *Гарын аавлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 20.1.
3. Рассел М.Нелсон, “Covenants,” *Лиахона* ба *Ensign*, 2011 оны 11-р сар, 86-г үзнэ үү.
4. Делберт А.Стейли, Conference Report, 1965 оны 10-р сар, 14; мөн *Teachings of Gordon B. Hinckley* (1997), 561; *The Teachings of Spencer W. Kimball*, эмхтгэсэн Эдвард А.Кимбалл, (1982), 220-ийг үз.
5. Рассел М. Нелсон, “Covenants,” *Лиахона* ба *Ensign*, Nov. 2011 оны 11-р сар, 88.
6. Рассел М.Нелсон, “Prepare for the Blessings of the Temple,” *Лиахона* ба *Ensign*, 2010 оны 10-р сар, 46-г үзнэ үү.
7. Бойд К.Пакер, “Come to the Temple,” *Лиахона*, 2007 оны 10-р сар, 16; *Ensign*, 2007 оны 10-р сар, 20.
8. Жеффри Р.Холланд, “Keeping Covenants: A Message for Those Who Will Serve a Mission,” *Лиахона*, 2012 оны 1-р сар, 50; *New Era*, Jan. 2012, 4.
9. “Holy Ghost,” *Итгэлдээ үнэнч байх нь* (2004), 82; мөн С ба Г 132:7, 18–19, 26-г үзнэ үү.
10. Жозеф Фиелдинг Смит, *Doctrines of Salvation*, эмхтгэсэн Брус Р.МакКонки, боть 3. (1954–1956), 1:156.
11. Даллин Х.Өүкс, “The Challenge to Become,” *Лиахона*, 2001 оны 1-р сар, 40; *Ensign*, 2000 оны 11-р сар, 32.

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБА

СҮМШИГ НИЙГЭМТЭЙ

*Санваартны
удирдагчид
гадас, дүүр-
гийн олон
нийттэй
харилцах ал-
баны зөвлөл-
тэй хамтран
ажилласнаар
нийгмээ хөг-
жүүлэх бо-
лон дэлхий
дээрх Бурханы
хаант улсыг
төлөвшүүлэ-
хэд тусалж
чадна.*



ХОЛБОЖ байна



Филип М.Волмар

Сүмийн сэтгүүлүүд

Карол Витт Крисченсен Канзас мужийн Топека гадасны олон нийттэй харилцах албаны захирлаар үйлчлэхээр дуудагдахдаа гадасны удирдагчдыг төлөөлөн сонины сурвалжлагчид, редакторуудтай нүүр тулж ярилцахаас “эмээж, энэ ажил өөрт нь ахадсан” мэт санагдсан гэнэ.

“Хэвлэл мэдээллийн хүмүүстэй анх удаа харилцаа холбоо тогтооно гэхээс бага зэрэг айж байсан шүү. Тэр коллежид англи хэлээр мэргэжил эзэмшсэн ч, “хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ярилцлага өгч мэддэггүй байсан” хэмээн хэллээ.

Крисченсен хэдийгээр итгэл муутай байсан ч өөрийн гэрчлэлдээ бас амьдардаг газарт нь хүмүүс түүнийг сайн мэддэгт, түүний дуудлагыг сүнсээр нөлөөлөгдсөн санваартны удирдагчид өгсөн гэдэгт найдвар тавихаар шийджээ. Тэр Олон Нийттэй Харилцах Албаны сургалтанд сууж, “[өөрийн] үүргийг мэдэж, томилогдсон албан тушаалдаа бүхий л хичээл зүтгэлээр ажиллажээ” (С ба Г 107:99).

Крисченсен эгч орон нутгийн сонины шашны долоо хоног тутмын булангаас ашигтай мэдээлэл олох гэж анхааралтай уншдаг байлаа. Сонинд өгөх анхны ярилцлагын эцсийн хугацааг мэдэхээр тэр шашны сэдвээр бичдэг сэтгүүлч рүү утасдсан аж.

“Сонинд нийтлэгдсэн жижигхэн мэдээ уншигчдын анхаарлыг сонирхолтой хүмүүс болон сүмийн үйл ажиллагаануудад хандуулдгийг би ажигласан” хэмээн тэр хэллээ.

Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй харилцах нь аль нэг түүхийг зүгээр нэг санал болгохоос илүү чухал зүйл болохыг Крисченсен эгч мэджээ. Энэ нь бас хэвлэл мэдээллийн хэрэгслийг мэдэж, сурвалжлагчдыг ажлаа хийхэд нь дэмжлэг үзүүлэхийн сацуу Сүмийг ойлгоход нь тэдэнд туслах явдал мөн.

Нэлээд хэдэн удаа нийтлэл, түүний дотор орон нутгийн сонинд гадасны семинарын тухай өгүүлэл хэвлүүлсний дараа тэр “Сүмийг тодорхой бус байдлаас гаргах энгүй их хүсэлтэй болсон” хэмээн хэллээ (С ба Г 1:30-ийг үз). Эдүгээ олон жилийн дараа ч Крисченсен эгч гадасныхаа олон нийттэй харилцах албаны захирлаар үйлчилсэн хэвээр байгаа бөгөөд “Сүмийг олон нийтэд таниулах оргилуун хүсэл минь ундарсаар байна” гэжээ.

ГЭРЭЛ ЗУРАГ ЧИМЭГЭЛЛИЙГ ДАВИД СТОКЕР



Нэгдсэн Улсын Канзасын Ленекса Гадас хандивын концертыг зохион байгуулахдаа сүүлийн хоёр жил бүс нутгийн бусад сүмүүдтэй хамтран ажиллаж байна. Концертын тасалбарын төлбөрт нэг уут хүнсний зүйл өгөх ёстой бөгөөд үүнийг орон нутгийн ядуу хүмүүст үнэгүй өгдөг ажээ. 2011 онд ойролцоогоор 1,000 орчим иргэд, сүмийн болон төр засгийн удирдах ажилтнуудаас хандивын концертыг үзжээ.



Тэрээр “олон нийтгэй харилцах албанд бидний хийдэг ажлын ихээхэн хэсэг нь бид Есүс Христийг хайрлаж, Түүнд итгэн, Түүнийг шүтэн биширдгийг мөн оршин суугаа газрынхаа хүмүүст найз нөхөр нь байж тэдэнтэй хамтран ажиллаж, ах эгч нартаа үйлчилж, сэргээгдсэн сайн мэдээ болон Сүмийн талаар нааштай санаа бодолтой байхад нь хүмүүст тусалдгийг харуулдаг” гэж хэлжээ.

Дэлхий даяарх санваартны удирдагчид олон нийтгэй харилцах албаны зохицуулагчдыг удирдан, ажилд нь дэмжлэг үзүүлж, оршин суугаа газрынхаа хүмүүстэй хэрхэн хамтран ажиллах талаар зөвлөгөө өгч, сүмийн талаарх буруу ойлголтыг нь залруулан, Сүмийн гишүүд Есүс Христийг дагадаг гэдгийг харуулдаг.

Хэвлэл, мэдээллийн хэрэгсэлтэй харилцах нь Крисченсен эгчийн үндсэн ажил боловч Сүмийн олон нийтгэй харилцах албаны зөвлөлүүд нийгмийг болон Бурханы хаант улсыг төлөвшүүлэхэд санваартны удирдагчдын сүнслэг нөлөө бүхий удирдамжийг дагадаг.

Нийгэм болон засгийн газрын байгууллагуудтай харилцах нь

Канзас мужийн Топекагаас 105 км зайтай орших Ленексад гадасны ерөнхийлөгч Брус Ф.Прайди, гадасны олон нийтгэй харилцах албаны захирал Карол Дешлер эгч хоёр оршин суудаг газрынхаа нөлөө бүхий гишүүдтэй сайн харилцаа тогтоохын төлөө хамтран ажиллаж байна. Хожмын Үеийн Гэгээнтнүүд бол “нийгэмд сайн нөлөө үзүүлдэг сайн хөршүүд бөгөөд Есүс Христийн дагалдагчид мөн гэдгийг хүлээн зөвшөөрөхөд нь иргэдэд туслахыг хүсдэг” хэмээн ерөнхийлөгч Прайди хэллээ.

Гадасны ерөнхийлөгчийн зөвлөл болон гадасны олон нийтгэй харилцах албаны зөвлөлийн бусад гишүүдтэй хамтран ажилладаг Дешлер эгч оршин суугаа бүс нутгийнхаа иргэдэд улам сайн үйлчлэхийн тулд бусад сүмүүд болон иргэний байгууллагуудтай хамтран ажиллах боломжийг эрж байна.

“Нийгмийн байгууллагуудтай хамтран ажилласнаар бидний олсон бүх амжилт тэдэнтэй бүтдтэй нь сайн хөршийн харилцаатай байсных юм” гэж Дешлер эгч

яриу. Жишээ нь, өөр сүмийн нэг гишүүн, гадасных нь нэг гишүүнтэй үдийн хоол хамт идэх үеэрээ нийгэмдээ сайн үйлс бүтээх арга замуудын тухай ярилцжээ. Уг ярилцлага хоёр сүмээс тус бүр гурван хүн бүгд зургаан хүн нийлж, хамтран ажиллах санаануудыг хэлэлцэх “Хамтын хүч” хороо байгуулахад хөтөлсөн ажээ.

Тэдний хамтын ажиллагааны үр дүнд 2010 оны хандивын концертод нэлээд хэдэн сүмийн найрал дуучид оролцжээ. Концертод орохын тулд нэг уут хүнсний зүйл хандивлах хэрэгтэй бөгөөд ядуу хүмүүс хандивын хүнснээс үнэгүй авч гэртээ хоол хийж идэж болох ажээ. Шинээр барьсан гадасны төвд зохион байгуулсан энэхүү үйл ажиллагаанд тэр хавийн оршин суугчдаас 700 орчим хүн оролцсон гэнэ. Нийгмийн болон шашны удирдагчдад концертын өмнө санал бодлоо солилцох боломж олгохын тулд хүлээн авалт зохион байгуулжээ.

Концертын дараа өөр дөрвөн сүм, хотын зөвлөлийн хоёр гишүүн, цагдаагийн газрын даргаас сар бүр хуралддаг Хамтын хүч хорооны бүрэлдэхүүнд орж ажиллахыг хүсчээ. Хандивын концертыг 2011 онд дахин зохион байгуулсан ба энэ удаад тоглолтыг өөр сүм зохион байгуулж, нийт долоон сүм, 1,000 орчим иргэд оролцжээ.

“Есүс Христийн дагалдагчдад байдаг сайн санааны үйлс хийгээд эв нэгдэл сүмүүдийн дунд гайхалтай арга замаар бий болсон юм” хэмээн Дешлер эгч яриу. Ерөнхийлөгч Прайди гэрээсээ 1600 км хол нисэх онгоцны буудал дээр ирээд ийм мэдрэмжийг мэдэрчээ. Огт танихгүй нэг эмэгтэй хүрч ирээд түүнийг Хамтын хүч хорооны хандивын концертын үеэр мэддэг болсноо мөн тоглолт гайхалтай сайхан санагдсан гэдгийг хэлжээ.

Мөн тэр эмэгтэй “Би эдгээр үйл явдлуудад оролцсоноор бусад хүмүүсийг хэзээ ч хайрлаж байгаагүйгээр хайрласан. Ийм концертыг ивээн тэтгэсэнд их баярлалаа. Би өөр сүмд явдаг ч Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийг гүнээ хүндэтгэн, гайхан биширдэг” гэдгээ хэлжээ.

“Энэ бол олон нийтгэй харилцах албаны

ажлын үр дүн” гэж ерөнхийлөгч Прайди хэлэв. Бид зорилгодоо хүрэх шинэ арга замуудыг эрэлхийлснээр олон сайн найз нөхөдтэй болж, бие биеийнхээ итгэлийг хүндэтгэн, бие биеэ жинхэнэ ёсоор хайрладаг болсон.”

Ийм хамтын ажиллагаанд хүрч, иргэний удирдагчдын зүгээс хүндэтгэл үзүүлсэн нь Дорнод Европт ч үр дүнгээ өгсөн юм. Украйны олон нийттэй харилцах албаны зөвлөлийн захирал Катя Сердюк олон нийттэй харилцах албаны зөвлөлийн номлогчид болон орон нутгийн санваартны удирдагчидтай хамтран Сүмээс нийгэмтэй харилцах харилцааг сайжруулахын төлөө ажиллаж байна. “Олон хүн Сүмийн талаар буруу ойлголт, мэдээлэлтэй байдаг” гэж Сердюк эгч хэллээ. “Санваартны удирдагчидтай хамтран ажилладаг олон нийттэй харилцах албаны зөвлөлийн зохицуулагчид бид иргэний байгууллагуудын удирдагчид, хэвлэл мэдээллийнхэн болон олон нийттэй ажилласнаар нийгмийн дундах буруу ойлголтыг өөрчлөхийг хичээж байна. Олон нийттэй харилцах албаны хүч чармайлт нийгмийн дунд нөлөө бүхий хүмүүс Сүмд зорилгодоо хүрэхэд нь тусалж, бид тэдэнд зорилгоо биелүүлэхэд нь туслах уур амьсгалыг бүрдүүлдэг.”

Украйны Житомирт Сүмийн гишүүдэд зориулсан хүлээн авалтыг зохион байгуулсан хотын захирагч Олександр Миколаевич Бочковский Сүмийн хүмүүнлэгийн тусламж хотын долоон сургуулийг маш их хэрэгтэй тоног төхөөрөмжөөр хангасанд талархал илэрхийлжээ. Түүнчлэн тус хотын Гагарины нэрэмжит цэцэрлэгт 2011 оны дөрөвдүгээр сард зохион байгуулсан Сүмийн үйлчлэлийг бас онцлон тэмдэглэсэн байна. Житомир салбарын ерөнхийлөгч Александр Давидов Сүмийг төлөөлөн хотын удирдлагад талархал илэрхийлжээ.

Үйл явдлыг төлөвлөх нь

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл болон нийгэмтэй тогтоосон харилцаанаас гадна олон нийттэй харилцах өөр нэг боломж нь үйл явдлуудыг төлөвлөж, хэрэгжүүлэх явдал юм хэмээн Карибын тэнгисийн бүсэд олон нийттэй харилцах албаны номлолоо дуусгасан Даниел Мехр, Ребека Мехр нар яриу.

“Соёлын үйл ажиллагаа, зоогт урих, үйлчлэлийн төсөл гэхчлэн бусад уламжлалт үйл явдлуудаар дамжуулан найз нөхдөө хөгжүүлж, боловсруулахад гишүүдийг оролцуулах нь тэдний хооронд хэлхээ холбоог бий болгодог онцгой үр нөлөөтэй” гэж Мехр эгч хэллээ.

Гэвч олон нийттэй харилцах албаны зохицуулагчдын гаргаж мэдэх нэг том алдаа бол “нийгэм, хамт олны



САНВААРТНЫ УДИРДАГЧДАД ӨГӨХ ЗАХИАС

“Гадас, дүүргийн ерөнхийлөгчид болон Бүсийн Далуудыг гадасны болон гадас дундын олон нийттэй харилцах албаны зөвлөлийг дуудаж, ажилд нь сурган дадлагажуулахыг бид дэмжиж

байна. Зарим дүүрэг болон Сүм хөгжиж байгаа бүсүүдэд эхний үед олон нийттэй харилцах албаны ажил бага байж болох ба бүрэн хэмжээгээр зохион байгуулагдсан зөвлөл шаардлагагүй байж болно. Танай бүсийн олон нийттэй харилцах албаны захирал сургалт зохион байгуулж, чухал эх сурвалжуудыг олоход танд тусалж чадна.

“Санваартны зорилгуудыг хэрэгжүүлэх, иргэний байгууллагуудын удирдагчид, хэвлэл мэдээллийнхэн болон нөлөө бүхий бусад удирдагчидтай хамтран ажиллахад олон нийттэй харилцах албаны ажил хэрхэн гайхамшигтай зэмсэг болж чаддагийг та бүхэн мэдэх болно. Энэ ажилд анхаарлаа хандуулж, бид Есүс Христийг дагадаг гэдгийг ойлгоход нь хүмүүст тусалснаар Сүмийн нэр хүнд өсөх болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Л.Том Перри, Олон Нийттэй Харилцах Хорооны дарга

хэрэгцээг харгалзалгүйгээр санваартны удирдагчдын зөвлөмжгүйгээр үйл ажиллагаа төлөвлөж, хэрэгжүүлэх явдал” гэж Мехр ах анхаарууллаа.

Ахлагч Мехр болон Мехр эгч гадас, тойргийн санваартны удирдагчдаас зөвлөмж болгон өгсөн жил тутмын төлөвлөгөө нь үйл явдлыг эхлэлээс нь төлөвлөж, хэрэгжүүлэхэд туслах нэг арга зам мөн гэдэгт итгэдэг ажээ. Жил тутмын ийм төлөвлөгөө гаргахад стратегийн үр дагавар, нийгэм, хамт олны хэрэгцээ, орон нутгийн санваартны удирдагчдын зорилго дээр анхаарал төвлөрүүлсэн, дөрвөн алхамт төлөвлөлтийн үйл явцыг Мехр эгч санал болгож байна:

- Нийгэмд хамгийн тулгамдсан ямар хэрэгцээ байна вэ?
- Манай бүс нутагт ямар асуудлууд Сүмийн өсөлт хөгжилтөд сайнаар бас муугаар нөлөөлдөг вэ?
- Нийгмийн хэрэгцээ болон тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхийн тулд бид нийгэм, хамт олны ямар удирдагчидтай хамтран ажиллаж болох вэ?
- Бид эдгээр удирдагчидтай харилцаа, хамтын ажиллагаагаа хэрхэн сайжруулж, хөгжүүлж болох вэ?

Санваартны удирдагчид болон олон нийттэй харилцах албаны зөвлөлдүүд эдгээр асуултуудад хариулахдаа ямар ч үйл ажиллагааг “зөвхөн үйл ажиллагаа

явуулахын төлөө' зохион байгуулахаас зайлсхийх ёстой" гэж Мехр эгч хэлэв. Үүний оронд зөвлөлүүд нь нийгэм, хамт олон болон санваартны удирдагчдын хооронд итгэлцлийг хөгжүүлэх үйл ажиллагаануудыг төлөвлөж хэрэгжүүлэх хэрэгтэй. Эдгээр үйл ажиллагаанууд иргэд болон Сүмийн гишүүд аль алинд нь хамтын ажиллагаа, найрамдал нөхөрлөлийг хөгжүүлэх боломжийг олгодог.

Жишээ нь, 2010 онд Бүгд Найрамдах Доминикан Улсад санваартны удирдагчид, олон нийттэй харилцах албаны зөвлөлүүд болон иргэд Мормоны Тусламжийн Гар хөтөлбөрт хамтран оролцжээ. Мехр ах, Мехр эгч хоёр өөрийн хамтран ажилладаг байсан, улс орондоо нэрд гарсан хүндтэй нэлээд хэдэн хүнийг урьжээ.

"Олон байгууллагыг төлөөлсөн нэрд гарсан хүмүүс бидний зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцсоноос гадна Сүмийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл бас хүрэлцэн ирсэн.

Үйл ажиллагаа их амжилттай болсон шүү. Улам олон хотын захирагч, байгууллагууд цэвэрлэгээ хийх ажилд туслахыг биднээс хүсэх болсон. Түүнээс гадна олон байгууллага Сүмийн талаар зөв ойлголттой болж байна" гэж Мехр ах ярилаа.

Үйл явдлыг төлөвлөхөд санваартны удирдамж шийдвэрлэх ач холбогдолтой ч энэ нь аль нэг үйл ажиллагааг зохион байгуулахад шаардлагатай цорын ганц зүйл биш юм. Кати Марлер АНУ-ын Калифорний Сан Диегод гадас дундын олон нийттэй харилцах албаны зөвлөлд үйлчилж байна. Хожмын Үеийн Гэгээнтнүүд өөрийнхөө Сүмийн ивээн тэтгэдэг үйл ажиллагаануудад бусдыг урихдаа сайн ч бусад сүмүүдийн үйл ажиллагаанд хүмүүстэй хамтран ажилладаггүй гэж өөр сүмийн нэг найз нь түүнд хэлжээ.

Марлер эгч найздаа "Та нар зөвхөн бусдыг л урьдаг шүү дээ. Харин та нар биднээс тусламж хэрэгтэй эсэхийг асуувал тийм ээ гэж бид хариулах болно" гэжээ.

Олон нийттэй харилцах албаны зөвлөл бусдын хэрэгцээг тодорхойлсноор өөрсдөө үйл ажиллагаа зохион байгуулснаас илүүгээр нийгэмд тусалж чадна.

Харилцааны доголдол ба зохицуулалт

Олон нийттэй харилцах албаны ажлыг нийгмийн амьдралын янз бүрийн нөхцөл байдалд гадас, улс орон, Сүмийн аль нэг бүсийн хэмжээнд тохиолдсон онцгой байдлын үеэр зохион байгуулдаг ба өнгөрсөн жил Японд тохиолдсон онцгой байдлын үеэр олон нийттэй харилцах албаны ажлыг өргөн хүрээтэй зохион байгуулсан билээ.

Азийн Хойд бүсийн Ерөнхийлөгч агсан Тэргүүлэх бишоп Гари Э.Стивенсон 2011 оны газар хөдлөлтийн үеэр хэвлэл мэдээллийн хэрэгслийн хандлага маш түргэн өөрчлөгдсөнийг санадаг ажээ. "Японы зүүн хойд эргийг нээд нь сүйрүүлсэн газар хөдлөлт, цунамиг бүх дэлхий нүд ширтэн харж, чих тавин чагнаж байлаа.

Тэрхүү гамшиг Японд хүмүүнлэгийн тусламж үзүүлэх болон сайн дурынхны үйл ажиллагааг 'эрчимтэй өрнүүлсэн' бөгөөд тусламж үзүүлэхэд Сүм идэвхтэй оролцсон" хэмээн бишоп Стивенсон хэлжээ.

Цунамигийн үед гамшигт нэрвэгдсэн сүмийн гишүүд, гишүүн бус хүмүүс аль алинд нь Сүм эн тэргүүний хэрэгцээт зүйлсээр тусламж үзүүлсэн юм. "Дотоодын болон олон улсын хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл явдал бүрийг шуурхай мэдээлж байлаа" гэж бишоп Стивенсон мэдэгджээ.

Сүм 250 тонн хүмүүнлэгийн тусламжийн эд зүйлсээр хангаж, 180,000 гаруй цагийн үйлчлэл үзүүлсэн 24,000 сайн дурынхныг гамшигт нэрвэгдэгсдэд туслахаар илгээсэн юм. Тусламж үзүүлэх ажил орон нутгийн төр, засгийн удирдагчдын анхаараад ямагт байсан хэмээн бишоп Стивенсон дурсаж байна. Хүн амынх нь дөнгөж хоёр хүрэхгүй хувь нь Христэд итгэгчид энэ оронд зарим удирдагчид нь тусламжийн ажилд Сүм ямар үүрэг гүйцэтгэснийг илүү тодорхой мэдэхийг хүсч байлаа. Тэдний энэхүү сонирхлыг олон нийттэй харилцах албаны зохицуулагчид зөвхөн гамшигт нэрвэгдэгсдэд туслах төдийгүй олон нийттэй хэлхээ холбоо тогтоож, харилцан ойлголцох боломж гэж үзсэн юм хэмээн тэр ярилаа. Жишээ нь, цунами Японыг нэрвэснээс хойш долоо хоногийн дараа нэг сурвалжлагч "Мормоны Сүмийг бусдаас илүү чадвартай болгодог цорын



Японд 2011 онд болсон газар хөдлөлтийн дараа санваартны удирдагчид Мормоны Тусламжийн Гар хөтөлбөрөөр дамжуулан олон нийттэй харилцах албаны зохицуулагчидтай хамтран тусламжийн үйл ажиллагааг зохион байгуулжээ. Хүмүүнлэгийн тусламжийн тухай нэг сурвалжлагчийн бичжээ: "Мормоны Сүмийг бусдаас илүү чадвартай болгодог цорын ганц зүйл бол онцгой байдлын үед түргэн шуурхай ажилладаг чадвар нь юм."



ганц зүйл бол онцгой байдлын үед түргэн шуурхай ажилладаг чадвар нь юм. . . . Энэ сүм зөвхөн өөрийнхөө сүрэгт анхаарал тавьдаггүй” гэж бичжээ.¹

Сонины энэхүү эерэг мэдээ олон нийттэй олон жилийн турш сайн харилцаатай байсны үр дүн юм. 2010 оны наймдугаар сард Хойд Азийн Бүсэд олон нийттэй харилцах албаны төлөөлөгчдөөр үйлчилсэн Конан Греймис, Синди Греймис нар “Япон дахь олон нийттэй харилцах албаны зөвлөл улс орныхоо төр засгийн удирдагчидтай олон жил хамтран ажиллаж байна. Энэхүү нөхөрсөг харилцаа манай тусламжийг хүлээн авах хүсэлтэй байгаагаар илэрхийлсэн орон нутгийн байгууллагуудыг бидэнд нээлттэй болгосон юм” гэж ярьсан байна. Эхнэрийнхээ хамт Япон дахь Сүмийн олон нийттэй харилцах албаны зөвлөлийн захирлаар үйлчилж байсан Ясуо Нияама, “Японы засгийн газрын удирдагчид ч манай Сүм тусламж үзүүлэх ажилд хэрхэн шуурхай, үр ашигтай ажиллагчийг мэддэг болсон” хэмээн ярьж байна.

Орон нутгийн санваартны удирдагчид алслагдсан нутаг дахь сургуулиуд дээр хоргодох байр барих шаардлагатайг тогтоосны дараа Сүм энэ ажилд цагаа олсон тусламж үзүүлснийг Японы удирдагчид өндөр үнэлжээ. Санваартны удирдагчид олон нийттэй харилцах албаны зөвлөл болон Сүмийн орон нутгийн халамжийн менежертэй хамтран цунамид нэрвэгдсэн, түр хоргодох байранд амьдарч байсан ойролцоогоор 270 хүнийг хүнс болон бусад зүйлсээр хангажээ.

Түр хоргодох байранд амьдарч байсан хүмүүс Христийн сүмээс тусламж хүлээн авсандаа эхлээд гайхсан ч Мормоны Тусламжийн Гар хөтөлбөрийн сайн дурынхан шар хантаазтайгаа хоёр дахь удаагаа туслахаар хүрч ирэхэд нэг хүүхэд “Тэд хүрээд ирлээ! Энэ удаа юу авчирсан бол!” хэмээн дуу алдсан гэдэг.

Хоргодох байрны зохицуулагч тусламж хүлээн аваад, “Газар хөдлөлтийн дараа бидний идсэн анхны хоол, шинэ ногоог танай сүмээс авчирч өгсөн” гэж Ахлагч Греймис, Греймис эгч хоёрт хэлсэн ажээ.

“Зөвхөн түр хоргодох байранд төдийгүй, тусламж хэрэгтэй хүмүүст дэмжлэг үзүүлэхийн тулд маш хүнд нөхцөлд ажиллаж байсан санваартны удирдагчдад тусалсан нь сайхан санагдсан” хэмээн Греймис эгч хэллээ.

Олон нийттэй харилцах зөвлөлийн ажлын үр дүнгийн тухай Ахлагч Нияама: “Сүмийн тусламжийн үйл ажиллагааны тухай мэдээллийг гишүүд болон сүмийн бус байгууллагын нэр хүнд бүхий удирдагчидтай хуваалцах нь олон нийттэй харилцах албаны зөвлөлийн зорилгыг биелүүлэхэд нэн чухал юм байна” хэмээн тайлбарлажээ. Өнөөдөр Японд сүмийн гишүүн бус хүмүүс Сүмийн талаар нааштай бодол санаатай болж, гишүүд Сүмийн хүч чадалд илүү итгэлтэй болжээ.”

Олон нийттэй харилцах албаны ажил бол орон нутгийн санваартны удирдагчдын хувьд чухал арга хэрэгсэл мөн

Дэлхий даяар олон нийттэй харилцах үйлсэд чухал үүрэг гүйцэтгэдэг санваартны удирдагчдад орон нутгийн нөхцөл байдлыг сайн мэддэг бөгөөд нийгэм, хамт олны хэрэгцээнд тохируулан үйлчлэх чадвартай олон нийттэй харилцах албаны зөвлөлүүд тусалж чадна. “Санваартны удирдагчид олон нийттэй харилцах албаны ажлыг зорилгодоо хүрэх зэмсэг болгон хэрхэн чадварлагаар ашиглаж байгааг харах нь үнэхээр сайхан байдаг. Мормоны Тусламжийн Гар хөтөлбөрөөр дамжуулан нийгэмд үйлчлэх нь тойрог, салбарын гишүүдийн эв нэгдлийг бэхжүүлэхийн хамт Сүм болон орон нутгийн иргэдийн хооронд ойр дотно харилцааг хөгжүүлэхэд тусалдаг” гэж Украйны Сердюк эгч хэллээ. ■

publicaffairs.lds.org дахь Сүмийн олон нийттэй харилцах албаны вэб сайтаас нэмэлт мэдээллийг англи хэлээр үзэж болно.

Эшлэл

1. Кари Хьюс, “In Japan, the Mormon Network Gathers the Flock,” НБС Ньюсийн Дэлхийн Блог, 2011 оны 3-р сарын 18, http://worldblog.msnbc.msn.com/_news/2011/03/18/6292170-in-japan-the-mormon-network-gathers-the-flock.

ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ АЛБАНЫ АЖИЛТАЙ ХОЛБООТОЙ БОШИГЛОЛЫН УДИРДАМЖ

Дараах хэлсэн үгс нь олон нийттэй харилцах албаны ажил нийгэм, хамт олныг бэхжүүлж, санваартны удирдагчид болон олон нийттэй харилцах албаны зөвлөлүүд, бусад гишүүдэд санваартны зорилгуудыг хэрэгжүүлэхэд хэрхэн тусалдгийг илүү сайн ойлгоход дөхөм болж чадна.

- Л.Том Перри, “Perfect Love Casteth Out Fear,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 41–44.
- М.Рассел Баллард, “The Importance of a Name,” *Лиахона*, 2011 оны 11-р сар, 79–82.
- М.Рассел Баллард, “Faith, Family, Facts, and Fruits,” *Лиахона*, 2007 оны 11-р сар, 25–27.
- Гордон Б.Хинкли, “What Are People Asking About Us?” *Ensign*, 1998 оны 11-р сар, 70–72.
- Эзра Тафт Бенсон, “May the Kingdom of God Go Forth,” *Ensign*, 1978 оны 5-р сар, 32–35.



ГЭРЭЛ ЗУРГИЙН ЧИМЭГЛЭЛИЙГ КРЕЙГ ДАЙМОНД

Хэзээ ч бүү бууж өг

*Эхнэр нөхөр хоёр 35 жилийн зөрөөтэй Есүс Христийн
сайн мэдээнд хөрвөсөн тухайгаа ярьж байна.*

Аль Фрай, Ева Фрай нар

Эхнэрийнх нь түүх

Би нөхрөө Сүмийн гишүүн болохыг 35 жил хүлээсэн хүн дээ. Тэрхүү урт удаан гучин таван жил миний зүрх сэтгэлийн залбирлаар дүүрэн байсан ч чухамдаа гурван залбирал л амьдралд минь шийдвэрлэгч өөрчлөлт авчирсан юм.

Аль бид хоёр 1959 онд гэрлэсэн. Арван жилийн дараа бид хоёр гурван хүүхэдтэй болж, Канадад нэг жижигхэн хотод амьдарч байсан юм. Аль барилгын бизнес эрхэлж, би заримдаа нөхрийнхөө ажилд туслан, гэртээ хүүхдүүдээ хардаг байлаа. Долоо хоногийн амралтын өдрүүдэд Аль бид хоёр найз нартайгаа үдэшлэг зохиоходоо үргэлж архи уудаг байв. Аав маань архианд орсон болохоор би архидалтыг үзэн яддаг байсан ч архидалт бидний амьдралын томоохон хэсэг болж, найз нөхөд, танил талтай болох нэг арга зам болсон байлаа.

Миний амьдрал зогсонги байдалд орсныг мөн хүүхдүүд маань бидний өгч байгаагаас илүү зүйлийг хүртэх эрхтэй гэдгийг би 1969 онд ухаарсан юм. Нэг орой үдэшлэг дээр архи уусныхаа дараа би өвдөг сөгдөн “Хайрт Бурхан минь ээ, хэрэв Та үнэхээр байдаг бол амьдралаа өөрчлөхөд надад туслаач” хэмээн залбирч билээ. Би дахин хэзээ ч архи уухгүй хэмээн Түүнд амлаж, тэр үеэс хойш амлалтаа сахьсаар байгаа билээ.

Энэ бол миний сэтгэлд хоногшин үлдсэн анхны залбирал. Хариу нь түргэн ирсэн юм. Хадам эгчийн минь охин, миний зээ дүүг Хожмын Үеийн Гэгээнтэн найз нь Хүүхдийн Хэсэгт урьжээ. Хадам эгч маань Сүмийн тухай тодорхой мэдсэний дараа Сүмийн сэтгүүлүүдийн захиалгыг надад илгээхээр сүнсэлгээр өдөөгдсөн

байлаа. Уг захиалгыг би анхны залбирал хэлснээсээ хойш сарын дараа авсан. Мормон хүн гэж ямар хүн байдгийг би мэдэхгүй ч сэтгүүлүүдийн захиасыг эхнээс нь эцсийг хүртэл унших дуртай байлаа. Би Сүмийг сонирхон судлахаар шийдсэнээр асуултынхаа хариуг олж, амьдралаа *өөрчлөн* 1970 оны зургадугаар сарын 19-нд баптисм хүртэв.

Аль миний хүслийг хуваалцаж, дэмжсэнгүй. Түүнд бидний хуучин амьдрал таалагддаг учир амьдралаа өөрчлөхийг хүссэнгүй. Тэр хэдийгээр сайн нөхөр, эцэг, гэр бүлээ тэтгэгч хэвээр байсан ч дараагийн 35 жилд би гэрээсээ ганцаараа сайн мэдээгээр амьдарсан юм.

Би хүүхдүүдээ Сүмд өсгөсөн ч ганц хоёрхон жилийн дараа тэд ням гарагт надтай хамт сүмд очихын оронд аавтайгаа завиар зугаалахаар явдаг боллоо. Иймд би их гутардаг болов. 1975 онд би гадасны ерөнхийлөгчтэйгөө ярилцаж, сүмд явах нь миний гэр бүлийг бусниулахад хүргэж байгаа учир Сүмийг орхихоор шийдсэнээ хэллээ. Тэр миний үгийг анхааралтай сонссоноо “Хийх ёстой зүйлээ хий, гэхдээ Тэнгэрлэг Эцэг сайшаах зүйлийг л хий” хэмээн хэлж билээ. Тиймээс би гэртээ ирээд мацаг барьж залбирав. Энэ бол миний сэтгэлд хоногшин үлдсэн хоёр дахь залбирал байсан юм. Би бол гэр бүлийнхээ хувьд сайн мэдээний гинжин холбоос бөгөөд хэрэв энэ холбоос тасарвал гэр бүл бүхлээрээ сүйрнэ гэсэн мэдрэмж дээрх залбирлын хариу болон ирсэн. Залбирлын хариу Бурханаас ирснийг би мэдэж байсан болохоор Сүмийг хэзээ ч орхихгүй хэмээн шийдэж, хэлсэндээ хүрсэн юм.



САЙН МЭДЭЭГЭЭР АМЬДАРЧ, ҮҮНИЙ ТӨЛӨӨ ЗАЛБИР

“Дэлхий дээрх амьдралынхаа туршид төгс төгөлдөр гэр бүлээр дамжуулан энэ амьдралын хамгийн чухал зорилгыг хэрэгжүүлэхийн төлөө хичээнгүйлэн эрэлхийл. Та нар энэхүү төгс зорилгод хараахан хүрч амжаагүй байсан ч Их Эзэнд итгэн, Түүнд улам ойр бөгөөд дуулгавартай байж, зорилгодоо хүрэхийн төлөө чадах бүхнээ хий. Зорилгоо биелүүлэхэд чинь юу ч та нарт саад бүү болог. . . . Хэрэв одоохондоо ариун сүмд лацдан холбуулах зөв шударга хамтрагчаа олоогүй бол түүнийгээ олохын төлөө амьдар. Үүний төлөө залбир. Олж авсан итгэлээ ашигла. Өөрийг чинь зохисгүй болгох юуг ч бүү хий. Мөнхийн гэрлэлтийн зорилго чинь бүтэлгүйтсэн бол дахин зорилго тавьж ажилла. Хэрэв мөрөөдөл чинь тэвчээр шаардах аваас тэвчин хүлээ. Сүмийн гишүүн ээж, гишүүн бус аав хоёрыгоо ариун сүмд лацдан холбуулахын төлөө ах дүүс бид 30 жил залбирч, ажилласан юм. Хэт их айж, түгшин санаа зовох хэрэггүй. Чадах бүхнээ хий. Бид адислалыг энэ амьдралд авах уу эсвэл ирэх амьдралд авах уу гэдгийг хэлж чадахгүй. Харин Их Эзэн амлалтаа биелүүлэх болно.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Ричард Г. Скотт, “First Things First,” *Лиакона*, 2001 оны 7-р сар, 7.

Итгэлээ хадгалж үлдэх нь амаргүй байсан ч Аль сайн мэдээний талаар анхаарч эхлэх хүртэл итгэлтэй хэвээр байж, тэвчээртэй хүлээхэд хэд хэдэн зүйл надад тусалсан:

- Би Алийг үргэлж хайрлан, түүнд анхаарал халамж тавьж, арван хуруу тэгш, чин үнэнч эхнэр байхын төлөө чадах бүхнээ хийдэг байлаа.
- Би байнга залбирдаг байсан. Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёр миний сайн мэдээний хамтрагчид болсон юм. Аль сайн мэдээний жишгүүдээр амьдардаггүй байсан учир түүнтэй хамт байхад надад хэцүү үе байдаг байсан. Тийм үед би Тэнгэрлэг Эцэгтээ хандан ярьж, Аврагчаа мэддэг болсон.
- Би судруудыг болон Сүмийн бусад гарын авлага, товхимлуудыг түүний дотор *Ensign*, *сэтгүүлийг тогтмол уншдаг болов*. Судрын хоёр шүлэг ялангуяа, 3 Нифай 13:33, Сургаал ба Гэрээ 75:11 миний хувьд чухал учир холбогдолтой бөгөөд амьдралд минь онцгой нөлөө үзүүлсэн билээ. Энэ хоёр шүлэг нөхөр, хүүхдүүдийн минь зүрх сэтгэлд өөрчлөлт

гарахыг хүлээх тэвчээр, хүч чадлыг надад өгсөн.

- Би сүмд гурван хүүхдээ эргэж ирэх хүртэл ганцаараа явдаг байлаа. Өнөөдөр хүүхдүүд минь бүгдээрээ идэвхтэй байгаа. Тэднийг том болоод төрж өссөн гэрээ орхин явахад би сүмд дахиад ганцаараа явдаг болсон.
- Бид гэр бүлийн үдшээ Альгүйгээр хийдэг байсан ч бидний юу хийж байгааг тэр мэддэг байлаа. Би хоолны цагаар аль нэг сэдвийг хөндөж яриа өрнүүлэхэд бид гэр бүлээрээ ярилцдаг байв.
- Бас дуулгавартай байж, үргэлж зөв зүйл хийхийг хичээдэг байлаа.
- Би санваарын адислал хүсч нэмэлт хүч чадал олж авдаг байлаа.
- Мөн санваартны удирдагчдаас зөвлөгөө авдаг байв.
- Сүмийн найз нартаа ч гэр бүлийн гишүүний адилаар ханддаг байсан юм.
- Би ариун сүм рүү хувийн хишгээ авахаар явлаа. Энэ шийдвэрийг гаргахад надад олон жил шаардагдсан бөгөөд Альтай харилцах харилцааг минь улам төвөгтэй болгож мэднэ хэмээн би айж байсантай холбоотой. Эцэстээ энэ бол миний хувьд хамгийн зөв шийдвэр гэдгийг би ойлгосон. Ариун сүм явах миний шийдвэрийг Аль дэмжсэнд би хөл газарт хүрэхгүй баярлаж билээ. Хувийн хишгээ хүлээж авсны дараа би Алийг ариун сүмд явж чадахгүй байсны шалтгаан гэж үзэхээ больж, түүнд дургүйцэхээ больсон юм. Мөн би ариун сүмийн ёслолуудад оролцсон үедээ Алийн нэрийг залбирлын жагсаалтанд олон удаа оруулсан.

Би үндсэндээ Сүмийн итгэлтэй гишүүний амьдралаа үргэлжлүүлсээр байлаа. Нөхөр маань сайн мэдээг сонсох хүсэлгүй хэвээр байсан ч би түүнтэй сайн мэдээг өчүүхэн бөгөөд энгийн арга замаар хуваалцахыг хичээдэг байлаа. Ариун Сүнс зөв зүйлийг зөв арга замаар зөв цагт нөхөр, хүүхдүүдэдээ хэлэхэд надад нөлөөлнө гэдгийг би мэдсэн юм. Нөхөртөө үнэнч итгэлтэй байснаар Сүнс Альд үе үе хүчтэй нөлөөлдөг байсныг би хожим нь мэдсэн.

Тэр нэлээд хэдэн удаа номлогчийн хичээлүүдийг сонсохыг зөвшөөрч байв. Гэвч тэр амьдралын хуучин хэв маягтаа эргээд ордог байсан учраас миний сэтгэл зүрх шархиран өвддөг байлаа. Ийнхүү санаагаар унасан үед ч гэсэн Тэнгэрлэг Эцэг миний дээрээс харж, Түүний адислалуудыг хүлээн авахад шаардлагатай зүйлсийг надад зориулж бэлтгэдэг байлаа. Энэ бүхний үр дүнд Алийн зүрх сэтгэлд ямар нэг өөрчлөлт гарч байгааг би мэдэрсэн.

Нөхөрт минь алгуураар өөрчлөлт гарч, бүдүүлэг үг

хэлэхээ больж, тамхи татахаа болив. Аль надтай урьд өмнөхөөс ч илүү сайхан харьцдаг болж, сүмд явдаг болов.

Би ч байнга залбирсаар байлаа.

Сэтгэлд хоногшин үлдсэн гурав дахь залбирлын хариу 2005 оны дөрөвдүгээр сард ирсэн юм. Аль ер нь Есүс Христийн сайн мэдээг хүлээж авах болов уу гэж бодох бүрт миний сэтгэл санаа тавгуйтдэг байсан учраас Тэнгэрлэг Эцэгээс тусламж гуйдаг байлаа. Аль 7-р сарын 9-нд баптисм хүртсэн нь зөв цаг үе нь байв.

Энэхүү баярт мөчийг иртэл надад амар байгаагүй ч итгэлгүй зүрх сэтгэлийг итгэлтэй болгон өөрчилсөн Бурханы гайхамшигт хүчийг гэрчилсэндээ би баяртай байдаг. 35 жилийн турш миний хэлсэн үй олон залбирлыг Бурхан сонсож хариулсныг би мэднэ. Миний залбиралд өгсөн Түүний хариултуудын ачаар би зүрх сэтгэл нь өөрчлөгдсөн нөхөртэйгөө хамт амьдарч байна. Нөхөр минь яг над шиг Тэнгэрлэг Эцэгтэй хайртай. Бас бид хоёр бие биеэ урьд өмнөхөөсөө ч илүү ихээр хайрладаг болсон.

Хайртай хэн нэгэн нь Сүмд ирэхийг хүлээж, найдвар тавин залбирч байгаа хүмүүс байгааг би мэднэ. “Надад ирэгтүн” (Алма 5:34) гэсэн Аврагчийн урилгыг зөвхөн хайртай хүмүүсийнхээ төлөө төдийгүй өөрсдийнхөө төлөө хүлээн авахад нь би эдгээр ах, эгч нарыг дэмжихийг хүсдэг. Өөр юу ч өгч чадахгүй хүч чадлыг энэхүү хүсэл өгдгийг би туршлагаасаа мэднэ. Тэнгэрлэг Эцэгтэй ойр байж Түүний зарлигуудыг дуулгавартай дагаж, адислалуудыг нь хүртэх нь бидэнд аз жаргалыг авчирч, биднээр дамжуулан ажиллах боломжийг Түүнд олгодог билээ.

Бурхан бидний залбирлыг сонсдог гэдгийг би гэрчилж байна. Их Эзэний хүслийг болон залбиралд хариу өгөх Түүний тогтоосон цагийг итгэлээр тэвчээртэй хүлээх нь амаргүй ч гэсэн Түүний цаг хугацаа үргэлж зөв байдгийг би мэднэ.

Нөхрийнх нь түүх

35 жилд олон хүн сайн мэдээг надтай хуваалцсан. Сайн мэдээний тухай ярих боломжийг эхнэр минь хэзээ ч алддаггүй байснаас гадна, Мормоны Ном эсвэл *Ensign* сэтгүүлийг ил харагдах газарт тавьдаг байлаа. Мэдээж хэрэг би тэдгээрийг огт сөхөж хардаггүй байсан. Эхнэр минь олон үйл явдлыг тохиолдуулан номлогчдыг урьсан. Тэднээс хоёр, гурав нь бүр номлогчийн хичээлийг заасан гээч.

Гэвч баптисмын усанд ороход намайг юу саатуулж байсан юм бол?

Би үргэлж шалтаг олдог байсан. Олон цагаар ажилладаг байсан болохоор сайн мэдээнд зориулах цаг огт


гардаггүй байлаа. Мөнгө олох гээд би ихэд завгүй байлаа. Тиймээс би Евад “Ажил төрөл гайгүй болж, завтай болсон үедээ Мормоны Номыг уншина” гэдэг байв.

Гэвч би Мормоны Номыг уншаагүй юм. Түүнээс гадна би ном огт уншдаггүй байсан. Тиймээс Библийг унших гэж хэчнээн хичээсэн ч нэг л болж өгдөггүй байлаа. Гэвч би ийм байдалд цэг тавьж чадсан.

Сүмд нэгдэхэд надад саад болсон илүү ноцтой өөр нэг зүйл байсан нь миний амьдрал нүглээр дүүрэн байсан явдал юм. “Тэрээр Ариун Сүнсний таталтанд [автагдахгүй бол] . . . эгэл хүн бол Бурханы дайсан” (Мозая 3:19) гэдгийг Хаан Бенжамин бидэнд сургасан билээ. Би сайн мэдээг хүлээн авах эсэхээ шийдэж чадалгүй тээнгэлзсээр байлаа. “Надтай хамт байдаггүй хүн Миний эсрэг байна” (Матай 12:30) хэмээн Аврагч хэлсэн юм. Өнгөрсөн амьдралаа бодож үзээд би үнэхээр Түүний эсрэг байснаа ойлгосон бөгөөд амьдралаа өөрчлөх хэрэгтэй байв.

Сайн мэдээгээр амьдардаг хань минь дэргэд байсан атал би сайн мэдээгээр амьдарч байсангүй харин

Би охиныхоо захиаг уншаад цаашид шалтаг заах аргагүй болсноо мэдлээ.



олон жил өнгөрсөн хойно Сүнсийг мэдэрсэн юм. Би архиддаг үдэшлэгт оролцохоо больсон. Ийм өөрчлөлт хийсэн үед Сүнсийг улам ихээр мэдрэх болсон. Гэвч өөрчлөх ёстой зүйл надад олон байсан. Миний хэл яриа тийм ч зохистой биш, зарим муу зуршлаасаа салж чадаагүй байсан ч аажмаар надад өөрчлөлт гарч байсан юм.

Тэгтэл нэг өдөр би боодолтой зүйл хүлээн авлаа. Үүнийг охин Линда минь явуулжээ. Энэ нь олон шүлэг, судруудыг дээр нь тэмдэглэж тодотгосон Мормоны Ном, Библи хоёр байлаа. Охин минь надад хэчнээн их хайртайгаа бас өөрийнхөө мэддэг зүйлийг намайг мэдээсэй гэж хүсдэг тухайгаа бичжээ.

“Есүс Христийн сайн мэдээ үнэн үү гэдгийг мэдэх цорын ганц арга бол чин сэтгэлтэйгээр, үнэн хүсэлтэйгээр Бурханаас асуух явдал мөн” хэмээн охин минь бичжээ.

Линда минь олон судрыг надтай хуваалцсан бөгөөд эдгээр судрууд намайг залбирахад мөн судар судлахад хөтөлсөн юм.

“Аврагч болон Тэнгэрлэг Эцэгээ мэддэг болсон миний цорын ганц арга зам бол залбирч, Тэдний тухай судруудаас уншсан явдал” гэж Линда бичсэн байлаа.


Бас даруу зан хэчнээн чухал болохыг дурдаж, хэрэв амьдралд нь Бурхан байгаагүй бол охин минь амар амгаланг мэдэрч чадахгүй байснаа бичжээ. Тэгээд эцэст нь, “Ямар ч юмыг бүү хойшлуулж бай. Танд маш их зүйл өгөгдсөн. Одоо Тэнгэрлэг Эцэгтээ эргүүлж өгөх цаг болжээ. Энэ бол жинхэнэ аз жаргалд хүрэх цорын ганц зам” гэж тэр бичсэн байлаа.

Үүнээс хойш би аливаа шалтаг заахаа больсон юм. Ажил төрлөө зохицуулж, өөртөө зориулан цаг гаргадаг болов. Охиныхоо тэмдэглэж ирүүлсэн судруудыг уншиж, судалдаг болсон нь Мормоны Номыг бүхэлд нь унших хүслийг надад төрүүлсэн юм. Гэвч миний ойлгохгүй өдий төдий зүйл судруудад байлаа.

Энэ үед эхнэр минь надад сүмд очиж, дэргэд нь суу-вал мөн ч сайхан байхсан гэж хэлсэн учраас би ариун ёслолын цуглаанд явдаг болов. Тэр бас Сургаал ба Гэрээг уншихыг надад зөвлөв. Би судрын энэ номыг уншаад нэлээд сайн ойлгосон юм. Дараа нь эхнэрийнхээ тусламжтайгаар Мормоны Номыг уншиж, судруудыг амьдралдаа хэрэгжүүлэх тухай бага ч гэсэн ойлголттой боллоо. Олон удаа залбирсны дараа Сүнс надад хүчтэй нөлөөлж эхлэв.

Надад ямар өөрчлөлт гарав? Ариун Сүнс болон судруудын мэдлэг. Энэ хоёр зүйл надад амьдралаа өөрчилж, Сүмд нэгдэхэд саад болж байсан нүглүүдийг уучлахыг Бурханаас гуйх зоригийг өгсөн.

Нүглээ хүлээх нь маш хэцүү байлаа. Би сэтгэлийн шаналал зовлонд автаж, гурван өдөр орондоо хэвтэхэд



Бид сайн мэдээнд нэгдсэн учраас бидний амьдралд агуу аз жаргал ирсэн юм.

хүрсэн юм. Гэвч би Есүс Христийн Цагаатгалын ачаар уучлагдсан билээ. Сэтгэлийн зовлонгоо орхиж шинэ амьдралаа эхлэх хүч чадлыг Тэнгэрлэг Эцэг надад өгсөн.

Миний хүү Кевин 2005 оны 7-р сарын 9-нд надад баптисм хүртээв. Хэдэн арван жилийн өмнө миний эхнэрт заасан номлогчдын нэг нь баптисмын ёслолд оролцов. Хоёр жилийн дараа би гэр бүлээ Калифорний Сан Диегогийн Ариун сүм рүү авч явж, бид тэнд энэ амьдралд болон үүрд мөнхөд лацдан холбуулсан билээ.

Сүүлчийн долоон жил миний амьдралын хамгийн аз жаргалтай үе байлаа. Эдүгээ би гэр бүлийнхээ патриарх болон сүнслэг байдлын удирдагчийн үүргээ биелүүлж, эхнэр, хүүхдүүд, есөн ач зээ нартайгаа сайн мэдээг хуваалцаж байна. Гэр бүлийн энэхүү нэгдмэл байдал хүн бүрийн сүнслэг байдлыг өсгөн нэмэгдүүлсэн юм. Нэг хүргэн маань Сүмд нэгдлээ. Манай ач, зээ нараас дөрөв нь номлолд үйлчилсэн буюу үйлчилж байна. Сүм дэх миний амьдрал чухамдаа гайхамшиг юм. Сүм миний амьдралд ийм агуу аз жаргал, өсөлт хөгжилтийг авчирна гэж би үнэндээ санаагүй.

Надад хоёр дахь боломж олдсонд би их баяртай байдаг. Бурханы ажлыг хийх байсан ч дэмий өнгөрөөсөн олон жилийг нөхөж чадсандаа би баяртай байдаг. ■

ИРЭЭДҮЙГ ИТГЭЛ НАЙДВАРААР УГТАХ НЬ

Далын
Ахлагч
Хосе А.Тейксерра



Их Эзэн, Түүний хаант улсыг болон гэр бүлээ нэгдүгээрт тавих нь өнөөгийн болон ирээдүйн сорилт бэрхшээлүүдийг даван туулахад шаардлагатай найдварыг бидэнд өгдөг.

Арнольдо Телес Грило ах намайг 20 гаруй настай байхад миний хамгийн дотны найз нарын маань нэг болсон билээ. Тэтгэвэрт гарсан инженер Грило ах 62-тойдоо тэр үед Португалийн Оейрас хэмээн нэрлэдэг байсан дүүргийн ерөнхийлөгчийн зөвлөлд миний зөвлөхүүдийн нэгээр дуудагдаж, бид хоёр хэдэн жил хамт үйлчилсэн юм.

Санваартны залуу удирдагч надад түүний мэргэн ухаан, туршлага, зөвлөгөө үнэлж баршгүй тусламж болдог байлаа. Тэр өөдрөг үзэлтэн бөгөөд ямар ч зүйлийг гэрэл гэгээтэй талаас нь хардаг, наргианч хүн юм. Түүний зан харьцаа эргэн тойрныхоо олон хүнд, ялангуяа надад агуу сүнслэг нөлөө үзүүлдэг байв. Учир нь тэр өөрт нь тохиолдсон маш хүнд сорилт бэрхшээлүүдийг даван туулсныг би мэддэг байлаа.

Грило ах сургуулиа төгсөж инженер болсныхоо дараа Португалийн Үндэсний Хөдөө Аж Ахуйн Агентлагт судлаачаар ажилд орж, хожим нь Африк дахь Португалийн колониудын нэгэнд хөвөн тариалах судалгааны төсөл удирдахаар явсан ажээ. Уг төсөл түүнийг тус орон дахь олон улсын томоохон банкинд ахлах мэргэжилтний



Баруун тал дахь зургийг Арнольдо Телес Грило ах 1956 онд авахуулжээ. Дээд талын зургийг дайны хөлөөс зугтахад нь тусалж, найздаа өгсөн машинтайгаа 1960 оны орчим авахуулсан ажээ. Тэр хөдөлмөрлөж олсон бүхнээ орхисон ч, баримталж ирсэн зарчмууддаа болон Есүс Христэд итгэх итгэлдээ чин үнэнч, гэр бүлдээ хайртай хэвээр үлджээ.



албан тушаалд дэвшин ажиллахад хүргэсэн ажээ. Тэр Африкт бараг 30 жил болохдоо сайхан гэр бүлтэй болж, аз жаргалтай амьдарч байтал зөрчил, сөргөлдөөн, дайны улмаас Португаль руу гэнэт буцахаас өөр аргагүй болсон гэнэ.

Хайртай оронд нь дайны учруулсан гай гамшгийг нүдээрээ харсны дараа Грило ах гэр бүлийн хамт ариун цагаан хөдөлмөрөөрөө олсон бүх зүйл—өмч хөрөнгө, хувийн эд зүйлсээ орхин нүүжээ.

Африкт өнгөрүүлсэн сүүлчийн хэдэн сард дайн дажинаар бий болсон төөрөгдөл, үймээн самууны уршгаар энх тайван, тогтвортой байдал алгуураар үгүй болсон ажээ. Грило ах Германаас худалдаж авсан үнэтэй машинаа найз нарынхаа нэгэнд өгч, түүнийг аварсан гэнэ. Машин нь түүний найзад ээжтэйгээ дайны хөлөөс зугтан гарахад тусалсан ажээ.

Хүнд хүчир хөдөлмөрийн үр дүнд Грило ах арвин их өмч хөрөнгөтэй болсон ч энэ нь түүний эн тэргүүнд анхаардаг зүйлийг өөрчлөөгүй юм. Тэр урьдын зарчмуудаа чанд баримтлан, гэр бүлээ хайрласан хэвээр байлаа.

Грило ах 52-тойдоо Португальд эргэж ирээд бүхнийг цоо шинээр эхлэхээс аргагүй болсон гэнэ. Эдгээр бүх сорилт бэрхшээл, гай зовлонгийн үед юу түүний амьдралд

өөрчлөлт гаргасан юм бол? Тэр яагаад одоо болон ирээдүйн талаар өөдрөг үзэлтэй байсан юм бол? Яагаад тэр тийм их итгэлтэй байсан юм бол?

Грило ах Португальд Сүм байгуулагдсан эхэн үед сүмд хөрвөж, улс орондоо хүчтэй нөлөө бүхий анхдагч болсон ажээ. Тэрээр хоёр талдаа 4,500 км зайтай Швейцарийн ариун сүмд гэр бүлээ нэлээд хэдэн удаа авч очсон нь чин үнэнч итгэл бишрэлийн илрэл юм. Грило ах түүний эхнэр хоёр үйлчлэлийнхээ жилүүдэд хүүхдүүдээ болон өөр олон хүнд баяр баясгалан бэлэглэжээ.

Грило ахын итгэл Есүс Христ дээр түүнчлэн эцэстээ Есүс Христ ирж хаанчлах болно гэдэг мэдлэг дээр төвлөрдөг байлаа. Энэ нь одоо болон ирээдүйд итгэх итгэл найдварыг түүнд өгсөн ажээ.

Шинэ Гэрээ агуу итгэл найдварын захиасаар төгсдөг.¹ Илчлэгч Иохан зэрэг бошиглогчид ирээдүйд тохиох зүйлсийг харж, хэрэв бид зөв шударга байж, эцсийг хүртэл тэвчвэл бидний хүлээн авч болох олон агуу адислалыг угтан харсан юм.

Иохан долоон тамгатай ном буюу долоон үеийг харж, Сатан хэрхэн зөв шударга хүмүүсийн эсрэг үргэлж тэмцдэгийг дүрсэлжээ (Илчлэлт 5:1–5; 6-г үз). Сатан хүлэгдэж, Христ хэрхэн ялгууснаар хаанчлахыг Иохан бас харсан ажээ (Илчлэлт 19:1–9; 20:1–11-ийг үз). Зөв шударга хүмүүс Эцсийн Шүүлийн дараа Бурхантай хамт амьдрах болно гэдгийг тэр мөн харжээ (Илчлэлт 20:12–15).

Өнөө үеийн агуу сорилтуудын нэг бол хүнд сорилт, уруу таталтуудыг даван туулахын тулд айдас, цөхрөлийг хэрхэн ялахыг мэдэх явдал мөн. Өдөр бүр гардаг гэмт хэрэг, байгалийн гамшгийн тухай сонины буюу вэб хуудсыг нээж харах, радио, зурагтын мэдээ, нэвтрүүлгийг үзэж сонсоход бидэнд хэдхэн хором хангалттай.

Их Эзэн нүгэл хилэнц алдаа дутагдлыг хэрхэн ялах тухай судрууд дахь амлалтыг ойлгож ирээдүйг итгэл найдвар, өөдрөг үзлээр угтахад бидэнд тусалж чадна. Бид өнөөгийн дэлхийд дайн дажин, байгалийн гамшиг, эдийн засгийн хямралын гэрч болж байна. Бид заримдаа эдгээр зүйлсийг

холоос ажигладаг төдийгүй бас бидэнд шууд нөлөөлдөг зүйлс ч байдаг.

Бид дэлхийн өмч хөрөнгөө алдсандаа харамсах буюу материаллаг эд зүйлс дээр анхаарлаа төвлөрүүлэх хэрэггүй. Эдгээр зүйлс амьдралын энгийн атлаа гайхан биширмээр зүйлсээс ирдэг баяр баясгаланг биднээс булааж болно.

Би Арнальдо Телес Грило ахын үлгэр жишээнд баярлан талархаж явдаг билээ. Тэр сүнсний зүйлсийг, “эцсийн өдрүүдэд [бидэнд] агуу чухал” (2 Нифай 25:8), болох зүйлсийг, түүний дотор гэр бүлийн харилцаа болон бусдад үзүүлэх үйлчлэлийг эрхэмлэдэг байлаа.

Нүгэл хилэнцийн хүч ялагдах болно гэдгийг бид мэддэг учраас ирээдүйг итгэл найдвараар угтах ёстой. Өнөөдөр бидэнд судрууд, амьд бошиглогчдын сургаал, санваарын эрх

мэдэл, ариун сүмүүд байгаа учраас бас Сүмийн гишүүд бие биеэ үргэлж дэмждэг учраас бид тулгарсан сорилт бэрхшээлүүдийг ялах болно гэсэн өөдрөг үзэл бодолтой байх хэрэгтэй. Бид бүхэн залбирлын ачаар “ялж гарах” (С ба Г 10:5) ёстой. Бид Их Эзэний цагаатгагч төгс золиослолын улмаас мөнх амьдралын итгэл найдвартай байх нь хамгийн чухал юм (Моронай 7:41-ийг үз).

Бидний эн тэргүүнд анхаарах зүйлс зөв байвал амьдрал маань баялаг агуулгатай, сайн сайхан байх болно. Их Эзэнийг болон Түүний хаант улсыг, гэр бүлээ нэгдүгээрт тавих нь өнөө үеийн болон ирээдүйн сорилт бэрхшээлүүдийг даван туулахад хэрэгтэй итгэл найдварыг бидэнд өгөх болно. ■

Эшлэл

1. Илчлэлт 19–22; мөн *New Testament Gospel Doctrine Teacher's Manual* (1997), 46-р хичээлийг үз.

Өнөөдөр бидэнд судрууд, амьд бошиглогчдын сургаал, санваарын эрх мэдэл, ариун сүмүүд байгаа учраас бас Сүмийн гишүүд бие биеэ үргэлж дэмждэг учраас, бид тулгарсан сорилт бэрхшээлүүдийг ялах болно гэсэн өөдрөг үзэл бодолтой байх хэрэгтэй.




ЭХ ЗОХИОЛ НЬ ЕВРЕЙ ХЭЛЭЭР ЮМ БАЙНА

Би хэдэн жилийн өмнө Хуучин Гэрээг уншсаны дараа үүний сургаалууд, ялангуяа Исаиагийн судруудыг илүү их сонирхдог болж, энэ номыг байнга судалдаг болсон. 2010 онд би нэг удаа онгоцонд Еврейн шашны удирдагчийн хажууд сууж явсан юм. Тэгээд Исаиагийн зарим хэсгийн тухай түүнээс асууж, яриа өрнүүлэв. Бидний яриа цааш өргөжиж, Хуучин Гэрээнд өгүүлдэг санваарын эрх мэдлийн тухай ярилцлаа.

Манай сүмийн гишүүд санваарын эрх мэдлээ хаанаас авдгийг Еврейн шашны удирдагч надаас асуулаа. Би энэ далимыг ашиглан Иосеф Смитийн Анхны Үзэгдэл, Аароны болон Мелкизедек санваарын сэргээлтийн тухай түүнд ярилаа. Бид хоёр “Есүс Христийн бас нэгэн гэрээ” болох Мормоны Номын орчуулгын талаар ярилцав.

Еврейн шашны удирдагч их сонирхож байгаа бололтой. Иосеф Анхны Үзэгдлийг харахдаа хэдэн

Манай сүмийн гишүүд санваарын эрх мэдлээ хаанаас авдгийг Еврейн шашны удирдагч надаас асуулаа. Иосеф Смитийн Анхны Үзэгдэл, Аароны болон Мелкизедек санваарын сэргээлтийн тухай би түүнд ярилаа.



настай байсныг тэр асуулаа. Иосеф Хуучин Гэрээний Самуелтай адил 14-тэй байсан гэж намайг хэлэхэд тэрээр олон бошиглогч залуу насандаа дуудагдсан гэж хариулаад Бурхан Иосеф Смитийг идэр насанд нь дуудсан нь хэвийн зүйл гэлээ.

Би судраа нээж, Гурав ба Найман гэрчийн гэрчлэлүүдийг бид хамт уншлаа. Эдгээр гэрчүүдээс нэлээд хэд нь Сүмээс гарсан ч, алтан ялтсуудыг харснаа хэн нь ч үгүйсгээгүйг би түүнд ярилаа.

“Тэд тэнгэр элч, ялтсуудыг харсан атлаа Сүмээс гарч яаж чаддаг байна аа?” гэж тэр асуув.

“Израилын хүүхдүүд Улаан Тэнгис хага ярагдахыг харсны дараа алтан тугал хийсэн шүү дээ” гэж би хариуллаа.

Тэр 1 Нифайг гаргаад уншиж эхэлснээ зогсож, “Эх зохиол нь еврей хэлээр юм байна” гэв.

Тэгээд тэр эх бичгийг еврей хэлнээс англи хэл рүү орчуулсан нь яагаад тодорхой байгааг тайлбарлав. Энэ номыг Израилын нэг овог бичсэнийг би түүнд хэлээд Иудейн саваа, Иосефын саваа хоёрын тухай өгүүлдэг Езекиел 37:15–20-ыг эш татав. Иудейн саваа нь Библи гэдэгт бид хоёр санал нэг байлаа. Харин Иосефын саваа бол Мормоны Ном гэдгийг би түүнд тайлбарлав.

Еврейн шашны удирдагч надтай гурван цаг ярилцсаны дараа Мормоны Номыг олж авах хүсэлтэй байгаагаа хэллээ. Би гэртээ ирээд, нүүр хуудсан дээр нь гэрчлэлээ бичсэн Мормоны Номыг түүнд илгээв. Хуучин Гэрээг судлахад хүч чармайлт гаргасан минь судруудын тухай Еврейн шашны удирдагч шинэ найзтайгаа ярилцаж, гэрчлэлээ хуваалцахад намайг бэлтгэсэнд би баярлаж явдаг билээ. ■

Дерк Палфриман, Юта, АНУ

ТА ЭХЛЭЭД ЗАЛБИРАХ ХЭРЭГТЭЙ

Б и гадасны ерөнхийлөгчтэйгөө хэл амаа ололцохгүйгээс болоод Сүмийг бараг л орхиход хүрч билээ. Тэр ямар нэг буруу зүйл хийсэн юм шиг санагдаад байлаа. Түүний үйлдэл юмыг яаж хийх ёстой талаарх миний бодолтой таардаггүй байснаас би сүмд явахаа больсон юм.

“Буурьтай залбирал, мацаг барилтгүйгээр чи шийдвэр гаргаж болмооргүй юм даа” гэж эхнэр маань надад хэлж билээ.

Түүний зөв байлаа. Хэсэг хугацаанд бодлоо төвлөрүүлэн залбиртал: “Бурханы үйлчлэгчийг Бурхан дууддаг” гэсэн үгс миний санаанд зурсхийн орж ирлээ.

Тэр шөнө би нэгэн зүүд зүүдлэв. Зүүдэнд өвөө намайг удирдагчтайгаа арцалдлаа хэмээн зэмлэж байх юм. Би тэр шөнө сэрээд дахин унтаж чадсангүй. Харин шөнөжингөө гүн бодолд дарагдсаны дараа яах хэрэгтэйгээ ойлгосон юм. Тэгээд гадасны ерөнхийлөгчтэйгөө уулзаж, уулчлал гуйв. Тэр намайг дуртайяа уучилж, бид хамтдаа залбирав.

Би тэр даруй сүмдээ эргэж очсон. Хоёр долоо хоногийн дараа манай ажил олгогч намайг Нигерийн нийслэл Абужад ажиллуулахаар шилжүүлэв. Гадасны ерөнхийлөгчтэйгөө эвлэрэх гэж хичээж байгаа үед намайг яагаад өөр газар шилжүүлсний учрыг олохгүй гайхаж байлаа.

Их Эзэн намайг үйлчлэхэд бэлтгэж байсныг би удалгүй ойлгосон. Абужад ирээд хоёр сар болсны дараа би салбарын ерөнхийлөгчөөр дуудагдав.

Тэнгэрлэг Эцэг намайг удирдагчаар дуудахаасаа өмнө Сүмийн удирдагчдыг дэмжихийн чухлыг



Хэсэг хугацаанд бодлоо төвлөрүүлэн залбиртал: “Бурханы үйлчлэгчийг Бурхан дууддаг” гэсэн үгс миний санаанд зурсхийн орж ирлээ.

надад заахыг хүссэнд би итгэлтэй байдаг. Энэ явдал миний гэрчлэлийг хүчтэй болгосон. Одоо би эн түүрүүнд удирдагчдынхаа зөвлөгөөг дуулгавартай дагахыг хичээдэг болсон. Учир нь тэд Бурханаас дуудагдсан билээ. Бурхан Өөрийнхөө дуудсан хүн бүрт дуудлагаа биелүүлэх чадварыг олгодог юм.¹

Бидний удирдагчид ердийн хүмүүс бөгөөд сүнслэг хэдий ч,

төгс биш юм. Бид Бурханд, Түүний сонгосон үйлчлэгчдэд итгэл найдвар тавихын тулд, хэрэв бид удирдагчидтайгаа санал нийлдэггүй бол тэднийг дэмжин, урам хайрлаж, тэдний болон өөрийнхөө төлөө залбирдаг байх хэрэгтэйг би ойлгосон. ■

Мартинс Энике, Нигери

ЭШЛЭЛ

1. Томас С.Монсон, “Duty Calls,” *Ensign*, 1996 оны 5-р сар, 44-ийг үз.



Та энэ цуглаан дээр гэрчлэлээ хуваалцах уу гэж би түүнээс асуулаа. Тэр ах тийм ээ, тэгнэ гэж хариулаад “Харин та?” гэж надаас асуув.

ТА ГЭРЧЛЭЛЭЭ ХУВААЛЦАХ УУ?

Саяхан би өөр мужид Сүмийн танихгүй гишүүдтэй хамт ариун ёслолын цуглаанд оролцлоо. Хажуудаа сууж байсан ахтай хэд гурван үг солимоор санагдаад, та энэ цуглаан дээр гэрчлэлээ хуваалцах уу гэж намайг түүнээс асуухад, тэр ах тийм ээ, тэгнэ гэж хариулаад “Харин та?” гэж надаас асуув.

“Үгүй, үгүй л болов уу” гэж би хариулаад “Харин Сүм үнэн, сайн мэдээ үнэн” гэлээ.

Удалгүй би энэ товчхон ярианыхаа тухай мартчихлаа. Гэрчлэлээ хуваалцах цаг эхлэхэд аль болох олон хүн гэрчлэлээ хэлэх

боломжтой байхын тулд товчхон ярина уу хэмээн бидэнд анхааруулав. Миний ярилцсан нөгөө ах босч гэрчлэлээ хуваалцаад, сайн мэдээ болон үүний авчирдаг аз жаргалын тухай хүссэн бүхнээ хуваалцахад цаг хүрэлцэхгүй байна гэлээ. Тэгээд тэр дөнгөж саяхан танилцсан надтай ярилцсан үгсээ индэр дээрээс хуваалцахдаа Сүм үнэн, сайн мэдээ үнэн хэмээн миний хэлсэн энгийн үгс хэрхэн бүх зүйлийг өөртөө багтаасныг хэллээ. Энэ бол хамгийн чухал зүйл.

Би энэ явдлын тухай эргэцүүлэн бодсоны эцэст бид гэрчлэлээ

олон арга замаар хуваалцаж болох бөгөөд маш богинохон хугацаанд бусдад сайн нөлөө үзүүлж болно гэдгийг ойлгосон юм. Бид хэн нэгэнтэй богинохон хугацаанд цөөхөн үг солилцох үед ч гэсэн сайн мэдээний тухай, өөрсдийнхөө тухай түүнд аятайхан сэтгэгдэл төрүүлж чадна.

Би тэр өдөр индэр дээр гарч гэрчлэлээ хуваалцаагүй ч миний товчхон гэрчлэл хүмүүст хүрсэн ба надтай ярилцсан ах, түүний гэрчлэлийг сонссон хүмүүс аль аль нь сүнсний нөлөөг мэдэрсэн юм. ■
ЛаРейна Хингсон, Индиана, АНУ

БИ ЕСҮСИЙН ӨВӨР ДЭЭР СУУХЫГ ХҮСДЭГ

Манай ач хүүг замын хажуу талаас цагдаа олоход тэр дөнгөж дөрөвтэй байлаа. Ач хүү минь таван бээр (8 км) орчим зайтай эмээгийнхээ гэр рүү явж байна гэж цагдаад хэлсэн ажээ.

Ач хүү минь гэрийнхээ аз жаргалгүй байдлаасаа зугтаж, над дээр хүрч ирэх гэж хоёр дахь удаагаа оролдсон нь энэ юм. Ач хүүгээ хоёр эмэгтэй дүүтэй нь өсгөн хүмүүжүүлэх үүрэг миний мөрөн дээр ирж болзошгүй болсныг би дараагийн хэдэн сард нь ойлголоо. Үүнийг би баяртай хүлээн аваагүй.

Нөхөр бид хоёр хүүхдүүдээ сайн мэдээний зарчмуудаар өсгөн хүмүүжүүлэхийн тулд чадах бүхнээ хийсэн ч эцэстээ тэд тэдгээр зарчмуудаас татгалзсан юм. Тавь гарсан үедээ би одоо өөрийгөө л бодъё, ингэх ч эрх надад байгаа гэж бодох болов. Нөхрөө тэтгэвэрт гарахаар хоёулаа номлолд үйлчлэх зорилго тавьсан нь надад урам зориг хайрласан юм. Сургуулийн өмнөх насны хүүхдүүдтэй хүнсний дэлгүүрээр явах, хоол ундыг нь хийж, хувцсыг нь угаалганд өгч, тэдэнтэй зууралдана гэж бодохоос хальширч, нулимс аяндаа урсах гээд байлаа.

Гэвч ямар нэг зүйл миний зүрх сэтгэлийг өөрчлөв. Ямар нэг шалгүй зүйл ач хүүг минь гомдоосон бололтой. Иймээс би түүнийг өвөр дээрээ авч, нулимсыг нь арчлаа. Би ач хүүгээ өвөр дээрээ аваад Есүс түүнд хэчнээн их хайртай тухай хоёул ярилцлаа. Миний дэргэд Аврагчийн зурагтай ханын хуанли байсан болохоор бид хоёр тэр гоё зураг руу ээлжлэн харж байлаа.

Аврагч хүрэн үстэй бяцхан охиныг өвөр дээрээ авч, чулуун

довжоон дээр сууж байгаа зургийг ач хүү минь бүр их сонирхож байлаа. Зураг дээр Аврагч, бяцхан охин хоёрын аль алиных нь царайд амар амгалангийн мэдрэмж гэрэлтэж байна. Ач хүү минь зургийг бүр ойроос ширтэн харж, охиныг заагаад түүнийг эмэгтэй дүүгийнхээ нэрээр дуудаж билээ.

“Кати яагаад Есүсийн өвөр дээр сууж байгаа юм бэ, эмээ?” гэж тэр асуув. “Би ч бас Түүний өвөр дээр суумаар байна ш дээ!”


“Чи одоо Есүсийн өвөр дээр сууж чадахгүй ээ, миний хүү, харин миний өвөр дээр сууж болно” гэж би хэллээ. “Есүс бяцхан хүүхдүүдийг

хайрлаж, асран хүмүүжүүлэх эмээ нарыг тэдэнд өгсөн юм.”

Гурван хөөрхөн ачийг минь Аврагч яаж хайрлах байсны адил тийм хайр зүрх сэтгэлийг минь гэнэт эзэмдлээ. Би тэдэнд хэрэгтэй шүү дээ. Одоо миний гурван ач надад ачаа дарамт биш харин тэднийг адисалж, Их Эзэнд үйлчлэх гайхамшигтай боломж болон харагдаж байна.

Тэр орой Их Эзэн надад үзүүлсэн нигүүлслийн төлөө би үүрд талархаж явах болно. Энэ нь миний амьдралыг өөрчилж, гэр бүлийг минь хүчирхэгжүүлж, адисалсаар байгаа билээ. ■

Нэрийг нууцлав



Би гомдсон ач хүүгээ өргөөд Есүс түүнийг хэчнээн их хайрладаг тухай яриу.

САЙН ТӨЛӨВЛӨГӨӨНҮҮД АМЖИЛТТҮЙ БОЛОХ ҮЕД

*Ирээдүйгээ төлөвлөх нь ялангуяа залуу насанд хүрэгчдэд нэн чухал юм.
Гэтэл хамгийн сайн боловсруулсан төлөвлөгөө биелэхгүй бол яах вэ?*

Стефани Ж.Бернс

Солонгосын Жунг Сунг Юн багш болох мэргэжлийн шалгалтанд уначихжээ. АНУ-ын Ютагийн Тина албан тушаал дэвшиж, цалингаа ахиулан ажиллана гэж бодож байсан ч ажилгүй болжээ. АНУ-ын Огайогийн Тодд Шленскер гэрлэх талаараа сүнсний баталгаа хүлээн авсан ч сүй тавилт нь цуцлагдсан гэнэ. Италийн Алессия Маззоларигийн (нэрийг өөрчилсөн) өө сэвгүй, төгс юм шиг санагдаж байсан харилцаа нь тасарчээ.

Хэн ч “хоёр дахь төлөвлөгөөнд” найдвар тавих дургүй байдаг. Бидний төлөвлөгөө биелэхгүй байлаа ч гэсэн Тэнгэрлэг Эцэг бидний ганцааранг нь орхихгүй. Амьдралыг өөд татах өдий төдий арга зам байдаг. Бидний төлөвлөгөөг өөрчилсөн сорилт бэрхшээл тодорхой хугацааны дараа нэмэлт ойлголт, туршлагыг бидэнд өгч, илүү сайн зүйл рүү хөтөлж болно (С ба Г 122:7-г үз).

Анкетыг биш, зан төлөвөө сайжруул

Сунг Юн багш болох насан туршийнхаа мөрөөдлийг биелүүлэхийн

төлөө шаргуу хөдөлмөрлөжээ. “Би юм бүхэнд чадвараа дээд зэргээр дайчлан ажиллахыг хичээдэг учраас хүсэл мөрөөдөл, залбирдаг зүйл, зорилгодоо хүрч чаддаг байлаа” хэмээн тэр ярилаа. Гэвч багшийн мэргэжлийн шалгалтаа өгч чадаагүй. “Шалгалтанд унасан тэр өдөр бүх мөрөөдөл минь ингээд өнгөрдөг байж ээ гэж бодогдсон шүү” гэж тэр хэллээ.

Өөр компани түүний ажиллаж байсан компанийг орлох үед тэр тийм ч их санаа зовохоо больжээ. Шинэ байгууллага нь түүнд урт хугацаанд ажиллах албан тушаал амласан болохоор тэр шинэ ажилдаа найдвар тавьж, ажилдаа ойртон шилжиж ирээд, сэтгэл хангалуун ажиллаж байжээ. Хэдхэн сарын дараа компани нь түүнийг халахад тэр “санаагаар унаж, уймран, сэтгэл түгшүүрлэх болжээ.”

Сунг Юн, Тина хоёр анкет, хувийн хэрэгтээ бүх зүйлийг өө сөвгүй байлгахгаас илүүгээр зан авираа сайжруулахад анхаарлаа төвлөрүүлж чадсан ажээ. Тэд сайн мэдээг судалж, залбирснаар тайтгарлыг олжээ.

“Төлөөлөгч Паул бол тэвчээртэй байж, сорилт бэрхшээлийг даван туулахад надад тусалсан гайхамшигт найз минь юм. Тэрээр аливаа зүйлд үргэлж сайн санаагаар хандаж, өөрийн хүссэн цагт найдвар тавих биш харин Бурхан түүгээр хийлгэх гэсэн зүйлийг хүсэл эрмэлзэлтэйгээр хүлээдэг байлаа.

Би Түүний үлгэр жишээнээс нэг зүйлийг сурсан юм. Хүлээн гэдэг нь зөвхөн хүссэн зүйлээ олж авахын тулд бидний хийх ёстой зүйл биш харин хийж байгаа өөрчлөлтүүдээрээ дамжуулж Тэнгэрлэг Эцэгийн хүссэн шиг хүн болох үйл явц юм” гэж Сунг Юн хэллээ.

Өөрт нь хамгийн их хэрэгтэй байсан өөрчлөлт бол мөнхийн хэтийн төлөвийн талаарх үзэл бодлоо өөрчлөх явдал байсныг Тина ойлгожээ. “Би өөрийн үнэ цэнийг дэлхийн үнэт зүйлсээр хэмждэг байснаа ойлгоод ихэд гайхсан. Эрхэлдэг ажил, албан тушаал л наймайг үнэ цэнэтэй болгосон юм шиг ойлгодог байж билээ. Гэтэл үүнийг надаас буцаагаад авчихлаа. Одоо би Тэнгэрлэг Эцэгийнхээ охин бөгөөд Бурхантай адил болох чадавх



надад бий гэдэг мөнхийн үнэнүүдээр өөрийн үнэ цэнийг хэмждэг болсон. Эдгээр үнэнүүдийг надаас хэн ч, хэзээ ч булаан авч чадахгүй.”

Зан төлөвөө төгөлдөржүүлэх нь үргэлж аятайхан байдаггүй ч хүнийг өсгөн хөгжүүлдэг учраас үр жимс нь амттай гэдгийг Тина, Сунг Юн хоёр хүлээн зөвшөөрсөн юм. “Багш болох мэргэжлийн шалгалтанд унасны дараагийн жил миний хувьд сэтгэл санаагаар хамгийн их унасан, гутарч цөхөрсөн жил байсан төдийгүй бас хамгийн их үр өгөөжтэй жил байлаа. Би хүмүүст тохиолддог бэрхшээлийг ойгодог болж, зүрх сэтгэлийн чин хүслээр тэдэнд туслах хүсэлтэй болсон” хэмээн Сунг Юн ярилаа.

Мормоны Номон дахь Аммон болон түүний ах нарын үлгэр жишээ Их Эзэн хэрхэн Тинагын итгэлийг бэхжүүлж, чадавхаа бүрэн ашиглахад нь түүнд тусалж байсныг харуулжээ. “Асуудлыг шийдэхэд илд зэвсэг ашиглахын оронд өөрсдийн ах дүүс леменчүүдийг аврах нь нифайчуудад зориулсан Их Эзэний төлөвлөгөө байсан юм” гэж тэр хэлэв. “Маш их итгэл шаардах ажлыг Мозаягийн хөвгүүдэд даалгахдаа, хэрэв тэд зовлон зүдгүүрээ тэвчээр хатуужлаар даван туулбал, амжилт олно гэдгийг тэдэнд бас амласан билээ (Алма 26:27-г үз). Тэвчээр бол надад тулгардаг хамгийн хүнд сорилтуудын нэг юм. Учир нь би өөрийнхөө төлөвлөгөөг л хэрэгжүүлэхийг хүсдэг. Гэтэл Тэнгэрлэг Эцэгийн төлөвлөгөө болон түүний тогтоосон цаг бидний хувьд бүхнээс чухал болохыг би ойлгосон.”

Юу ч тохиолдсон гэсэн бүх зарлигийг дагах нь

Тоддыг номлолоосоо буцаж ирэхэд гэрэлт ирээдүй түүнийг угтжээ. Сургуульд байхдаа нэгэн гайхалтай залуу бүсгүйтэй тэр танилцсан

гэнэ. Хэдэн сар болзон уулзаж, сүнсний баталгаа авсны дараа Тодд гэрлэх саналаа хэлэхэд тэр бүсгүй зөвшөөрчээ. Тэд зуны сүүлчээр хуримаа хийхээр төлөвлөж, хоёул хуримандаа бэлтгэхээр хичээлийн жилийг дуусгаад гэртээ эргэж ирсэн аж.

“Сургуульдаа баяртай гэж хэлээд ирснээс хойш гурван долоо хоногийн дараа тэр сүй тавилгаа цуцалсан” гэж Тодд ярилаа. “Зүрх *шимирэм* гэдэг үг миний сэтгэл санааны үй гашууг дүрслэхэд хангалтгүй байлаа. Оюун ухаанд минь хариултгүй үй олон асуулт эргэлдэнэ. Нөхцөл байдал тун хүнд байлаа. Би Их Эзэний өргөөнд баталгааг хүлээн авсан атал бидний харилцаа тасарчихаад байдаг. Гэрчлэл минь хэзээ ч ингэж соригдож байсангүй.

“Харамсалтай нь, тэрхүү гунигт явдлаас хойш олон жил өнгөрсөн ч сэтгэл зүрхний шаналал арилсангүй. Би дахин ийм баталгаанд итгэж чадах эсэхээ мэдэхгүй байлаа. Би Их Эзэнд үргэлж итгэж, зарлигуудыг сахихын тулд чадах бүхнээ хийхийг хичээдэг байлаа. Гэтэл энэ бүхэн юу ч биш юм шиг санагдах болов” хэмээн тэр яриу.

Алессия ч гэсэн залуу эрэгтэйтэй харилцах харилцаа нь ямар байх ёстой талаар боддог болжээ. “Бидний харилцаа маш сайхан байсан, хайр сэтгэлтэй хосуудад тохиолддог ердийн хүндрэл бэрхшээл байсан ч, бидний харилцаа хэзээ ч тасрахгүй гэж бодож байлаа” хэмээн Алессия өгүүлэв.

Найз залуу нь номлолд явсны дараа түүнээс хол байх нь Алессияд хэцүү байсан ч, бодож байснаас нь өөр нэг шалтгаан бас байсан гэнэ. “Түүнийг номлолд явсан хойгуур би өөрийгөө илүү сайн мэддэг болсон. Амьдралд минь олон зүйл зөв биш байгааг, өөрийгөө даруусгаж,



бодит байдлыг зөвөөр үнэлэхийн оронд зарим нэгэн мунхаг бодол өвөрлөж явснаа би мэдсэн.” “Би чухамдаа үлгэрт гардаг шиг л хийсвэр санаа бодлоор амьдарч байжээ. Хүнд хайр сэтгэлтэй л болчихвол бүх зүйл зөвөөр эргэх юм шиг санагддаг байсан нь хамгийн чухал зарим зүйлийг олж харж чадахгүйд хүргэдэг байлаа” хэмээн тэрээр ярьж байна.

Алессия найз залуугаа номлолоос ирэхэд нь баяртай угтаж, харилцаагаа үргэлжлүүлнэ гэж бодож байсан гэнэ. Гэтэл түүнийг номлолоос эргэж ирсний дараа тэр хоёр ердөө хэдхэн удаа болзож, дараа нь салсан гэнэ. “Энэ явдал миний хувьд хамгийн сэтгэл эмзэглэм хором байлаа” хэмээн Алессия хэлэв.

Амьдрал дахь хамгийн чухал харилцаа нь өөрчлөгдсөн ч, Их Эзэнд үнэнч, дуулгавартай байхаа больж чадахгүйгээ Тодд, Алессия

хоёр өөрсдийн туршлагаас мэдсэн ажээ. Юмс өөрчлөгдөж, тодорхой бус байдал бий болсон ч Их Эзэн бүх зүйлд тэдний өмөг түшиг болдог байлаа.

“Би гэрлэх талаар сүнсний баталгаа хүлээж авсан атал энэ нь яагаад бүтэлгүйтсэнийг огт ойлгоогүй” гэж Тодд ярилаа. Гэвч энэ нь чухал биш байлаа. Хамгийн *чухал* нь би Христэд итгэсэн хэвээр байсан бөгөөд Их Эзэн надад зориулж нөөцөлсөн бүх зүйлд итгэдэг байлаа.”

Их Эзэнд бие сэтгэлээ бүрэн зориулснаар өөрт нь хэрэгтэй хүч чадал ирэх болно гэдгийг Алессия мэддэг байв. “Ямар хүн болохоо шийдэх цаг ирснийг, цаашдаа өөх ч биш, булчирхай ч биш байдалаар амьдрах уу эсвэл Христийн жинхэнэ шавь байх зам дээр гарах эсэхээ шийдэх хэрэгтэйгээ би ойлгосон” хэмээн тэр ярилаа. Зөвхөн зүрх сэтгэлийнхээ гүнд төдийгүй



**АМТАТ ҮР ЖИМС
ИРЭЭДҮЙД ИРНЭ**

“Бид өнгөрсөн зүйлсээрээ амьдрах гэж биш харин сайн сайхан зүйлсээс нь суралцах гэж өнгөрсөн үеийг эргэж хардаг. Бид сурах хэрэгтэй юмаа сурч, үр дүнг нь биеэрээ үзсэн үед урагш харан, итгэл нь ямагт ирээдүй өөд чиглэдгийг санадаг билээ.”

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Жеффри Р.Холланд, “Амтат үр жимс ирээдүйд ирнэ” *Лиакона*, 2010 оны 1-р сар, 18.

Энэ сэдвээр нэмэлт мэдээллийг Боид К.Пакер, “The Least of These,” *Лиакона*, 2004 оны 11-р сар, 86–88; Роберт Д. Хейлс, “Waiting upon the Lord: Thy Will Be Done,” *Лиакона*, 2011 оны 11-р сар, 71–74; Анн М.Дибб, “Be of a Good Courage,” *Лиакона*, 2010 оны 5-р сар, 114–116-гаас үзнэ үү.

ажил үйлсээрээ чин шударга байж, Түүнийг гүн гүнзгий мэдэж, чин сэтгэлээсээ хайрлан, бүх зарлигуудыг нь биелүүлснээр илүү сайн хүн болохыг хүсдэг байлаа.”

Ирээдүйд болон Христэд итгэх итгэл найдварыг хөгжүүлэх нь

Санаанд оромгүй сорилт бэрхшээлтэй тулгарсан залуу насанд хүрэгч энэ дөрвөн хүн цаг үеэ ухааран амьдрахын төлөө тэмцэж, ирээдүйгээ дахин төлөвлөхөөр чармайж байна. Харин Их Эзэнд итгэх тэдний итгэл улам өсчээ.

Шалгалтанд унасны дараа юмсыг шинээр хийх гэж хичээх нь хэцүү байсныг Сунг Юн санадаг ажээ. Гэвч дараа нь шийдвэрлэгч ач холбогдолтой нэг зүйлийг мэдэжээ: “Жинхэнэ бүтэлгүйтэл бол өнгөрсөн үеэрээ амьдарч, өөрчлөлт гаргахын төлөө үл хичээх явдал мөн гэдгийг би ойлгосон. Би зовлонгоо сэтгэлдээ тээж явснаас энэхүү хүнд үеийг суралцах боломж болгон хувиргахаар шийдсэн юм. Амьдралыг ойлгох миний чадвар ерөнхийдөө өргөжин, гүнзгийрч, нэг зүйлийн төгсгөл үргэлж өөр нэг зүйлийн эхлэл байдгийг ойлгосон билээ.” Тэр шалгалтаа дахин өгч, амжилттай дүн аваад одоо “сурагчидтайгаа өдөр бүрийг хамт өнгөрүүлдэг аз жаргалтай багш болоод байгаа ажээ”.

Тодорхой бус ирээдүйтэй учрах нь Тинад хэцүү байсан ч өөрийг нь хүлээж буй зүйлд тэр итгэхийг сонгожээ. “Би урлаг, технологийн чиглэлээр сургуульд дахин орж суралцахыг хүссэн ч үүнд шаардлагатай ур чадварыг эзэмшээгүй байлаа. Би Тэнгэрлэг Эцэгийнхээ мэргэн ухааны ачаар илүү сайн нэгэн аяллыг эхлүүлэхэд бэлэн байлаа.”

Тодд зургаан жилийн турш болзохоо үргэлжлүүлж, Их Эзэнд

итгэх итгэлээ хөгжүүлэхийн төлөө шаргуу ажиллажээ. Хэдийгээр тэр биширмээр сайхан эмэгтэйчүүдтэй тааралдаж байсан ч ирээдүйн найдварыг нь бусниулсан өнгөрсөн үеийн эргэлзээтэйгээ тэмцэлдсээр байлаа. “Эргэлзээндээ ялагдахгүй байх сэтгэлийн хаттай болохын төлөө зургаан жил тэмцсэн нь амаргүй байлаа” гэж тэр хэллээ. “Гэвч би өмнө нь Их Эзэнд уурлан бухимддаг байсан ч Түүнд болон Түүний өдөөлтүүдэд чин үнэнчээр итгэдэг байхад бие сэтгэл бүхнээ зориулахыг хичээдэг болсон.” Шинэ харилцаа нь эцэстээ ариун сүмийн гэрлэлт рүү хөтөлжээ.

“Сүнсний өдөөлтүүдэд итгэдэг болохын төлөө өөртэйгөө удаан тэмцэлдсэн намайг Их Эзэн яагаад ийм сайхан эхнэрээр адисалсан юм бол гэж би олонтоо гайхдаг байлаа” хэмээн Тодд ярилаа. “Их Эзэн биднийг Өөрийн тогтоосон цагт адислахаар үргэлж хүлээж байдгийг би гэрчилж байна.”

Алессия Их Эзэнд бие сэтгэл бүхнээ дахин зориулдаг болж, бат бөх гэрчлэлтэй болсон ажээ. “Аваралын төлөвлөгөө миний хувьд бодит зүйл бөгөөд гэрээнүүд надад илүү их хариуцлага хүлээлгэж, ач холбогдол нь өсөн нэмэгдсэн юм. Христийн Цагаатгал миний уншсан ямар нэг онол, хийсвэр зүйл биш. Зүрх сэтгэлийн өөрчлөлт дотоод сэтгэлд гардаг. Иймээс би хүчтэй гэрчлэлтэй болсон билээ.” Өнөөдөр тэр шинэ хүн болсноо мэдэрдэг ажээ.

Амьдралын аянд огцом эргэлт гарч болох ч эцсийн хүрэх газар мөнх амьдрал бол Тэнгэрлэг Эцэгээс хүүхдүүдэдээ зориулсан Төлөвлөгөө юм (Моисе 1:39-ийг үз). Зарим нь бүр “хоёр дахь төлөвлөгөө” бол “Нэг дэх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх энгийн арга зам гэж бодож болох юм. ■



Арванхоёр
Төлөөлөгчийн Чуулгын
Ахлагч
Даллин Х.Өүкс

САНВААРЫН АДИСЛАЛУУДЫН

ач холбогдол

*Санваарын адислалаар
сүнсний зүйлсэд хамаарах
хүчийг олгодог.*

Санваарын адислал өгөхөд Их Эзэний үйлчлэгч Ариун Сүнсээр нөлөөлөгдөн, санваарын хүчийг ашиглаж, адислал авч байгаа хүний ашиг тусын төлөө тэнгэрийн хүчийг дууддаг. Санваарын адислалуудыг Сүмийн бүх сүнслэг адислалын түлхүүрүүдийг атгадаг Мелкизедек санваартнууд өгдөг (С ба Г 107:18, 67-г үз).

Санваарын адислалуудын жишээ

Олон төрлийн санваарын адислалууд байдаг. Хэрэгтэй байгаа бүх хүмүүст санваарын адислалыг өгч болох ч зөвхөн тэдний хүсэлтээр өгдгийг санах хэрэгтэй. Энэ талаар янз бүрийн жишээг дурдъя.

Өвчтэй хүмүүсийг эдгээх адислал өгөхөөс өмнө судруудад заасны дагуу тос түрхэх ёслолыг гүйцэтгэдэг (Иаков 5:14–15; Марк 6:13; С ба Г 24:13–14; 42:43–48; 66:9-ийг үз). Патриархын адислалыг томилогдсон патриарх өгдөг.

Чухал шийдвэр гаргахад удирдамж авахыг хүсч байгаа хүн санваарын адислал авч болно. Хувийн сорилт бэрхшээлийг даван туулахад сүнсний нэмэлт хүч хэрэгтэй байгаа

хүмүүс адислал авч болно. Сургууль болон цэрэгт явах, удаан хугацаагаар хол газар ажил, аяллаар явах зэрэгт хүүхдүүд эцгээсээ адислал авахыг хүсдэг.

Энд дурдсан адислалуудыг заримдаа тайтгарлын буюу зөвлөгөө өгөх адислал гэж нэрлэдэг. Ийм адислалуудыг эцэг буюу нөхөр нь эсвэл тухайн гэр бүлд байгаа ахлагч нар ихэвчлэн өгдөг. Тэдний өгсөн адислалуудыг гэр бүлийн цэдэгт адислал авсан хувийн сүнслэг байдлын удирдамж болгон тэмдэглэж болно.

Санваарын адислалуудыг бас санваарт томилох буюу эрэгтэй, эмэгтэйчүүдийг Сүмийн дуудлага авахад нь өгөх ёстой. Санваарын адислалын энэ хоёр төрлийг байнга өгдөг.

Биднээс олон нь шинээр ажилд орохдоо эсвэл шинэ албан тушаалд томилогдохдоо санваарын адислал авахыг хүсдэг. Би ийм адислалыг олон жилийн өмнө авсан. Адислал авсан даруйд тайтгарлыг мэдэрсэн бөгөөд энэ адислал надад олон жилийн туршид удирдамж болсон билээ.

Санваарын адислалуудын ач холбогдол

Санваарын адислал ямар ач холбогдолтой вэ? Залуу эр дэлхийд аз жаргалыг олохоор гэрээсээ хол газар явахаар бэлтгэж байна гэж бодъё. Эцэг нь түүнд луужин өгвөл тэрээр дэлхийн энэ хэрэгслийг замаа олоход ашиглаж болно. Эцэг нь түүнд мөнгө өгвөл тэр үүнийг дэлхийн зүйлсийг ялах хүчтэй байхын тулд ашиглана. Харин санваарын адислал өгвөл энэ нь сүнсний зүйлст ашиглах хүч болно. Энэхүү адислалыг гараар барих буюу жинлэх боломжгүй ч мөнх амьдралд хүрэх зам дээрх саад тогторыг даван туулахад бидэнд тусалдгаараа агуу ач холбогдолтой.

Мелкизедек санваартан санваарын адислал өгөхдөө Их Эзэнийг төлөөлөн үг хэлдэг нь түүний хувьд ариун үүрэг хариуцлага юм. Их Эзэн өнөө үеийн нэг илчлэлтэд бидэнд хандан “Миний үг . . . миний өөрийн дуу хоолой байна уу, эсвэл миний үйлчлэгчдийн дуу хоолой байна уу, энэ нь яг адил, бүгд биелэгдэх болно” (С ба Г 1:38) хэмээн хэлсэн билээ. Их Эзэний




үйлчлэгчид Ариун сүнсээр нөлөөлөгдөн ярьсан үед түүний үгс “Их Эзэний таалал, . . . Их Эзэний оюун, . . . Их Эзэний, . . . [мөн] Их Эзэний дуу хоолой” (С ба Г 68:4) байдаг.

Гэвч адислалын үгс нь Ариун Сүнсээр өдөөгдөөгүй, зөвхөн адислал өгөгчийн хүсэл бодлыг илэрхийлж байвал уг адислал Их Эзэний хүслийг төлөөлж чадахгүй.

Зохистой Мелкизедек санваартнууд үр удамдаа адислал өгч болно. Судруудад ийм олон адислалыг, түүний дотор Адамын (С ба Г 107:53–57-г үз), Исаакийн (Эхлэл 27:28–29, 39–40; 28:3–4; Еврей 11:20), Иаковын (Эхлэл 48:9–22; 49; Еврей 11:21-ийг үз) болон Лихайн адислалыг (2 Нифай 1:28–32; 4-ийг үз) цэдэглэсэн байдаг.

Өнөө үеийн илчлэлтэд Сүмийн гишүүн эцэг эхчүүдэд хүүхдүүдээ “сүмийн өмнө” авчирдаг байхыг мөн ахлагч нар “Есүс Христийн нэрээр тэдэн дээр гар тавин, мөн түүний нэрээр тэднийг адислах ёстойг” (С ба Г 20:70) зарлигласан юм. Иймээс эцэг эхчүүд бага насны хүүхдээ ариун ёслол дээр авчрахад аль нэг ахлагч, ихэвчлэн эцэг нь



түүнд нэр өгч, адисалдаг билээ.

Санваарын адислал нь энд өгүүлсэн, адислал авагчийн толгой дээр гар тавих адислалуудаар хязгаарлагддаггүй. Адислалыг зарим үед олны өмнө хэлдэг. Бошиглогч Мосе нас барахынхаа өмнө Израилын бүх хүүхдүүдийг адисалсан билээ (Дэд Хууль 33:1-ийг үз). Бошиглогч Иосеф Смит Көртландын Ариун сүм дээр ажиллаж байсан “эгч нарыг адисалсан юм.” Тэр бас “цугларагсдыг” адисалжээ.¹

Санваарын адислалаар бас газрыг адисалдаг. Сайн мэдээг номлолын төлөө улс үндэстнүүдийг мөн адисалдаг. Ариун сүм болон цуглааны байруудыг Их Эзэнд зориулан санваарын адислалаар онцгойлон адисалдаг. Бусад барилгуудыг Их Эзэнд үйлчлэхэд ашиглаж байгаа бол онцгойлон адисалж болно. “Сүмийн гишүүд гэр орноо Ариун Сүнс байнга орших ариун газар болгон адислуулж болно.”² Номлогчид болон бусад санваартнууд өөрсдийг нь хүлээн авсан гэр оронд санваарын адислалаа үлдээж болно (Алма 10:7–11; С ба Г 75:19-ийг үз). Залуу эрэгтэйчүүд ээ, богинохон хугацааны дараа ийм адислал өгөхийг та нараас хүсч болно. Та нар үүнд сүнслэгээр бэлтгэж байгаа гэдэгт би итгэлтэй байна.

Санваарын адислалын зарим туршлага

Санваарын адислалын бусад зарим жишээг дурдъя.

Санваарын адислал нь мөнх амьдралд хүрэх зам дээрх саад тотгорыг даван туулахад бидэнд тусалдгаараа агуу ач холбогдолтой юм.

Зуу орчим жилийн өмнө Сара Янг Ванс эх баригчийн мэргэжилтэй болжээ. Түүнийг Аризоны эмэгтэйчүүдэд үйлчилж эхлэхийн өмнө санваартны нэг удирдагч, “үргэлж зөвийг үйлдэж, эхчүүдийн сайн сайхны төлөө чадах бүхнээ хамгийн сайнаар хийж бай” хэмээн адисалсан гэнэ. Сара 45 гаруй жилийн хугацаанд эх болон хүүхдийн нэг ч эндэгдэлгүйгээр 1500 орчим хүүхдийг эх барьж авчээ. “Хүнд асуудалтай тулгарсан үед ямар нэг зүйл надад сүнслэгээр нөлөөлж, ямар ч үед би юу зөв болохыг мэддэг байсан” гэж тэр ярилаа.³

1864 онд Жозеф А.Янг Дорнод нутагт Сүмийн бизнес эрхлэх тусгай номлолд дуудагджээ. Түүний аав Ерөнхийлөгч Бригам Янг түүнийг явж, эсэн мэнд эргэж ирэхийн төлөө адисалсан аж. Түүнийг гэртээ буцаж ирэх үеэр сууж явсан галт тэрэг нь осолд орсон ажээ. “Галт тэрэг миний сууж явсан суудлаас нэг суудлын цаагуур цуурч юу ч үгүй болтлоо эвдэрсэн ч, би ганц

шалбархай ч үгүй үлдсэн юм” гэж тэр ярьжээ.⁴

Санваарын адислалуудын тухай яривал надад өдий төдий дурсамж байна: Манай охид, хөвгүүд амьдралдаа тохиолдсон ярвигтай асуудлуудад тусламж авахаар надаас санваарын адислал хүсдэг байсныг би санаж байна. Миний өгсөн сүнслэг адислал болон амлалтууд биелэгдэн, тэдний итгэлийг бэхжүүлдэг байсныг санаад би баярладаг. Мэргэжлийн шалгалт өгөх болсон үед сэтгэл түгшсэн нэг хүү минь намайг нь хол байсан учраас хамгийн ойрхон байсан гэр бүлийнхээ санваартан, эгчийнхээ нөхрөөс санваарын адислал хүссэнийг би хүүгийнхээ итгэлийн жишээ гэж үзэн бахархдаг. Учраа олохгүй явсан Сүмийн нэгэн залуу хөрвөгч мөхөл рүү хөтөлж буй амьдралаа өөрчлөхийн төлөө санваарын адислал авахыг хүссэнийг би санадаг. Би түүнд санваарын адислал өгөх үед өөрийнхөө хэлсэн үгсийг сонсоод ихэд гайхаж билээ.

Сүнсний хүч чадал хэрэгтэй болсон үедээ санваарын адислал хүсэхэд бүү эргэлз. ■

1987 оны дөрөвдүгээр сарын ерөнхий чуулган дээр хэлсэн үгнээс.

Эшлэл

1. Иосеф Смит, *History of the Church*, 2:399.
2. *Гарын авлага 2: Сүмийг удирдах нь* (2010), 20.11.
3. Леонард Ж.Аррингтон, Сюзан А.Мадсен, *Sunbonnet Sisters: True Stories of Mormon Women and Frontier Life* (1984), 105-ыг үз.
4. Жозеф А.Янг, *Letters of Brigham Young to His Sons*, эмхтгэсэн Дин К.Жессий, (1974), 4.

ГЭРЧЛЭЛ ҮҮНИЙГ ХУВААЛЦ

“Тиймийн тул, дэлхийд туяарч болохын
тулд гэрлээ өргөгтүн”

(3 Нифай 18:24).



ЗАЛБИРЛЫН ХҮЧ

Паул Ванденберг

Сүмийн сэтгүүлүүд

Зүүн талаас: Хозелито,

Жоаханна, Роза,

Кен нар Филиппиний

Себу Хотын Ариун

сүмийн өмнө.

*Филиппиний Себу арлын өсвөр
үеийн хүүхдүүд залбирлынхаа
хариуг хүлээж авсан ухай
өгүүлж байна.*



Дэлхий даяарх олон арван мянган арлаас 7,107 нь Өмнөд Ази дахь арлын улс Филиппинд байдаг ажээ. Тэрхүү 7,107 арал зөвхөн нам түрлэгийн үед л байдаг гэсэн онигоо Филиппинд өргөн дэлгэрчээ. Далайн өндөр түрлэгийн үед арлуудын тоо 7,100 болж, зарим арал далайн түвшингээс доош усан дор ордог гэнэ. Филиппиний залуу эрэгтэй, эмэгтэйчүүд сайн мэдээгээр амьдрахын тулд хэрхэн чадах бүхнээ хийдэг вэ? Тэд Тэнгэрлэг Эцэгт хандан залбирдаг.

Ганцаардаж байгаа юм шиг санагдах үе амьдралд олон тохиолддог. Гэвч бид Тэнгэрлэг Эцэг бидэнд туслахад ямагт бэлэн байдгийг, Тэрбээр бидний залбирлыг сонсож, хариулахад үргэлж бэлэн байдгийг санах юм бол энэхүү мэдлэгийн авчирдаг итгэл найдвар дээр тулгуурлаж болно.

Залбирал итгэлийг бий болгодог

Хозелито Б. 12-той байхдаа түүх ярих тэмцээнд оролцохоор томилогдсон тухайгаа ийн ярьж байна. Багш нь түүнээс 10 хуудас текстийг цээжилж, хэдэн зуун багш сурагчдын өмнө ярихыг хүссэн гэнэ. Энэ нь тайзан дээр гарахаас айдаг Хозелитод төдийгүй өөр хэнд ч гэсэн айн сүрдэж, халширмаар даалгавар байлаа.

“Тиймээс би хамгийн түрүүнд удирдамж хүсч залбирсан” гэж Хозелито хэллээ. “Хэрэв би текстийн аль нэг хэсгийг мартвал цээжээр уншиж байгаа түүхийн шинэ мөрүүдийг надад сануулахыг би залбирлынхаа үед хүссэн. Залбирч дууссаны дараа Хуучин Гэрээн дэх дуртай нэг судраа саналаа. Сургаалт Үгс 3:6-д, ‘Өөрийн бүх замаараа түүнийг таньж мэд. Тэр чиний замыг шулуун болгоно’ гэсэн байдаг.”

Хозелито цухалдангүй байлаа. Гэвч текстийг цээжлэхээр бүтэн долоо хоног шаргуу ажилаажээ. Бас өдөр бүр олон удаа залбирч байв. Тэгсээр тэмцээн явагдах өдөр боллоо.

Тэмцээний нээлтийн мэндчилгээний үеэр Хозелито мөн л сандарч байлаа. “Гэвч түүх ярих үедээ би дажгүй байсан шүү. Намайг чадах бүхнээ хийсэн үед Бурхан надад туслах болно гэдгийг би мэдэж байсан. Маш



олон сурагч байсан болохоор би сандарч, айж байсан ч Бурхан миний залбиралд хариулсан юм” гэж тэр ярих.

Хозелито түүхийг цээжээр ярьсан төдийгүй, бас уран уншиж, тэмцээнд нэгдүгээр байр эзэлжээ. “Дэргэд чинь тайтгаруулах хүн байхгүй үед залбирал тусалдаг. Бурхан чамд туслахаар үргэлж бэлэн байдаг” гэж Хозелито хэлэв.

Залбирал хүч чадал өгдөг

Идэвхтэй Хожмын Үеийн Гэгээнтэн гэр бүлд өсч байгаа Кен Ж. өндөр жишгүүдээ баримтлахад хэзээ ч ийм их бэрхшээлтэй тулгарч байсангүй. Кенийг ахлах сургуульд ороход асуудал улам төвөгтэй

болж, тэр зарим үед ялангуяа сургууль дээр гэр бүлийнхээ сайн нөлөөнөөс тусгаарлагддаг байлаа.

“Миний ахлах сургуулийн найз нар Сүмийн гишүүд биш байсан ч бүгд надтай үнэхээр ойр дотно байсан. Бидний үерхэл бат бөх байлаа. Нэг л асуудал байсан нь найз нар маань манай Сүмийн жишгүүдэд үл нийцэх юмсыг хийдэг байлаа” хэмээн Кен ярилаа.

Гэртээ бол зөвийг сонгоход Кенд ямар ч асуудал байдаггүй байлаа. Харин сургууль дээрээ ирсэн үед гэр бүл нь түүнд нөлөөлөх боломжгүй болохоор тэр буруу сонголт хийдэг ажээ. “Би Сүмийн жишгүүдтэй үл нийцэх зүйл хийсэн үедээ семинарт ирж суухад хичээл дээр жишээ болгон ярилцаж байгаа хүн нь би юм шиг үргэлж санагддаг байлаа.”

Кен өөрчлөлт гаргахыг хүссэн боловч ганцаараа ийнхүү өөрчлөлт гаргаж чадахгүй юм шиг санагдсан гэнэ. “Иймд би Бурханд хандан залбирч, найз нар маань буруу зүйл хийсэн үед уруу татагдахгүй харин үгүй гэж хэлэх хүч чадал, зоригийг надад өгөөч хэмээн гуйхаар шийдсэн” хэмээн тэр ярих. “Тэгээд би Бурхан миний залбиралд хариулсныг мэдэрсэн шүү. Найз нар маань надаас ямар нэг буруу зүйл хийхийг хүсэх үед эсвэл уруу татах үед үгүй гэж хэлэхэд илүү амар болсон. Би юу зөв, юу буруу болохыг аль хэдийн мэддэг байсан. Тэгээд буруу зүйлийг хийхгүйн төлөө залбирснаар зөв зүйлийг хийх хүч болоод бэлэгтэй болсноо мэдэрсэн.”

Энэхүү туршлагаас түүний сурч мэдсэн хамгийн чухал зүйл нь “залбирал бол даруу байдлын чинь тэмдэг, учир



НАДАД УРАМ ХАЙРЛАДАГ ХАРИЛЦАА

“Тэнгэр дэх Эцэгтэйгээ залбирлаар дамжуулан харилцаагүй нэг ч өдөр надад үгүй билээ. Би Тэнгэрлэг Эцэгтэйгээ харилцаагүй бол төөрөлдөх байсан учраас энэхүү харилцаагаа эрхэмлэн дээдэлж хайрладаг билээ. Хэрэв та нар Тэнгэр дэх Эцэгтэйгээ ийм харилцаа тогтоогоогүй бол би та нарыг өмнөө зорилго тавин, ажиллаж эхлэхийг хүсч байна. Ингэснээр та нар амьдралдаа Түүний сүнслэг нөлөө болон удирдамжийг хүлээн авах болно.”

Ерөнхийлөгч Томас С.Монсон “Ариун газруудад зогсогтун” Лиахона, 2011 оны 11-р сар, 84.

нь чи өөрийгөө сул дорой болохыг мөн хүч чадалтай болоход чинь зөвхөн Бурхан л тусалж чадна гэдгийг хүлээн зөвшөөрсөн” гэдгийг ойлгосон явдал мөн хэмээн Кен ярив (Сургаал ба Гэрээ 112:10-ыг үз).

Залбирал адислалуудыг авчирдаг

Заримдаа бидэнд тайтгарал, хүч чадлаас илүү их зүйл хэрэгтэй болдог. Зарим үед илүү их бодитой адислалууд бидэнд хэрэгтэй байдаг. Тания Д. ийм үеийг санаж байна. Гэр бүл нь санхүүгийн онцгой хүнд үетэй тулгарчээ. “Бямба гарагийн орой байлаа. Бидэнд ирэх долоо хоногийн хэрэгцээнд ердөө 40 песо [1 ам.доллар орчим] үлдсэн байлаа. Идэх юм, тэр ч бүү хэл пийшингээ галлах нүүрс ч байсангүй. Манайд хэрэгтэй байсан бүх зүйлсийн жагсаалтыг ээж надад өгснийг харвал энэ бүхнийг худалдаж авахад 250 песо хэрэгтэй байлаа. Хамгийн түрүүнд худалдаж авах хэрэгтэй зүйл нүүрс байлаа. Учир нь нүүрсгүйгээр яаж хоол хийх билээ” гэж Тания ярив. Хэрэгтэй юм болгоныг худалдаж авахад мөнгө хүрэхгүйг Тания ойлгож байлаа. Тэгтэл маргааш нь сүм рүү явах автобусны мөнгө ч байхгүйг тэр мэджээ. “Сүм рүү явах автобусны мөнгө хүрэхгүй нь гэдгийг би ээжид хэллээ. Ээж үнэхээр итгэлтэй хүн. Тиймээс ‘Бурхан хангана даа’ гэж тайван хэлж билээ.

Бидэнд хэрэгтэй бүх зүйлийг худалдаж авах мөнгө байгаагүй учраас би дэлгүүр лүү явах замдаа уйлсан. Би яахаа мэдэхгүй байлаа” гэж Тания хэлэв. Тэр 20 песогийн дэвсгэртүүдээс нэгийг авч халаасандаа хийгээд өөрийн хийж чадах цорын ганц зүйлийг хийж залбирчээ. “Бид хэрэгцээгээ хангах арга замыг олохын төлөө Тэнгэрлэг Эцэгт хандан залбирсан.”

Гэтэл түүнийг анхны дэлгүүрт ортол нүүрсний үнэ 5 песогоос 20 песо болж өссөн байлаа. “Нүүрс авахаа больдог юм бил үү гэж бодтол Ариун Сүнс надад юутай ч гэсэн нүүрсийг ав хэмээн шивнэхийг мэдрээд



Таниягийн түүхийг видеогоор үзэж болно

Таниягийн түүхийг видеогоор үзэхийн тулд (англи, португаль, испани хэлээр) youth.lds.org хаягаар орж, 2012 оны Залуучуудын сэдвээс “Pure and Simple Faith” видеог үз.

би нүүрсийг худалдаж авлаа. Одоо надад ердөө 20 песо үлджээ, гэтэл дүүдээ живх, ундны ус гээд худалдаж авах зүйл зөндөө байдаг. Тэгээд хоол хүнс худалдаж авахаар дараагийн дэлгүүрт очтол бараа нь дэндүү өндөр үнэтэй байв. Би 20 песо хийсэн халаасандаа гараа хийж үзтэл 20 песогийн дэвсгэрт тав байлаа. Дэлгүүрийн эзний өмнө очоод би уйлж гарлаа.

“Тэгээд хэрэгтэй бүх зүйлээ худалдаж аваад цаана нь маргааш сүм рүү явах автобусны мөнгө ч үлдсэн байлаа. Би гэртээ ирээд өрөөндөө орж, бидэнд өгсөн адислалынх нь төлөө Бурханд баярласнаа илэрхийлэн залбирлаа. Бурхан үнэхээр амьд бөгөөд ялангуяа Тэр бидэнд чухал хэрэгтэй болсон үед бид чин сэтгэлээсээ залбирвал Бурхан бидний залбиралд хариулдгийг би мэднэ. Тэр үнэхээр бидний залбиралд хариулах болно” хэмээн Тания ярив.

Залбирал биднийг Тэнгэрлэг Эцэгт ойртуулдаг

Тэнгэрлэг Эцэг бидний залбирлыг сонсож, хариулдаг гэдэгт бид итгэлтэй байхын хамт залбирлын хариулт үргэлж тэр доороо бас бидний хүсэн хүлээсэн байдлаар ирдэггүйг санах хэрэгтэй. Бидний залбирлын хариу Бурханы хүсэл болон Түүний тогтоосон цагт ирдэг.

Бид олуулаа эсвэл ганцаархнаа байсан ч, сайн цаг, саар цаг алинд ч, далайн түрлэг өндөр байхад ч, нам байхад ч, Бурхан бидэнд туслахад ямагт бэлэн байдгийг Филиппиний Себу арлын эдгээр өсвөр үеийнхэн мэддэг ажээ. Хэрэв бид чин сэтгэлийн залбирлаар Түүнд хандвал Тэр биднийг адислахад үргэлж бэлэн байдаг. ■

АМЛАЛТ БА ЗАЛБИРАЛ

Пабло Майрелис Беттс

Бүр Сүмийн гишүүн болохоос нь өмнө хүмүүст мөнхийн агуу өөрчлөлтийг Мормоны Ном бий болгодог нь миний хувьд маш гайхалтай зүйл юм. Би Мексикийн Куернаваса Номлолд номлогч байхдаа энэхүү агуу өөрчлөлтийг тэр даруй олж харсан.

Намайг номлолд ирээд зургаан сар болж байхад салбарын нэг гишүүн хамтрагч бид хоёрт 20 настай эмэгтэйг гэр бүлтэй нь хамт зааж өглөө. Хожмын Үеийн Гэ-гээнтнүүд юунд итгэдгийг тэр залуу эмэгтэй ойлгодоггүй байв. Тиймээс тэр биднээс олон асуулт асуудаг байлаа. Мормоны Ном сэтгэл зүрхний асуултуудад хариулдгийг бид мэддэг учраас түүнд энэ номыг өгч, хэрэв тэр Мормоны Ном үнэнийг мэдэхийг хүсвэл чин сэтгэлээсээ залбирч болох тухай амлаалт үүнд байдгийг хуваалцлаа.

Түүнийг гурван долоо хоног сүмд явахад нь бид түүнтэй уулзаар байлаа. Тэр аль хэдийн маш чухал алхам хийж, Мормоны Номын тухай залбирчихсан байсныг бид мэдээгүй байжээ. Нэг хичээлийн үеэр тэр энэ туршлагынхаа тухай бидэнд ярьсан юм. Тэр эмэгтэй бидний заасан хичээлүүдийн талаар олон зүйлийг тунгаан бодоод, залбирахыг хүссэн гэнэ. Тэгээд өвдөг сөгдөн Мормоны Ном үнэн үү гэдгийг Бурханаас асуужээ.

Залбирсныхаа дараа амар амгаланг мэдэрсэн нь Мормоны Номоос улам их зүйл уншихад нь түүнд урам өгсөн ажээ. Уншиж байх үедээ Сүнс түүнийг нөмрөн авах шиг болсныг мэдэрсэн гэнэ.

Тэр эмэгтэй өөртөө тохиолдсон явдлын тухай, “Өмнө нь хэзээ ч мэдэрч байгаагүй тийм онцгой мэдэрэмжийг би мэдэрч билээ. Миний амьдралд байсан, өөр юу ч бөглөж чадаагүй дотоод сэтгэлийн хоосон зайг ямар нэг зүйл дүүргэсэн. Тэгээд маш их баяр баяслыг мэдэрч, тэссэнгүй үйлж гарлаа. Мэдэрсэн зүйлдээ итгэж чадахгүй байсан ч Тэнгэрлэг Эцэг минь надад хариулсныг, Тэр намайг мэддэгийг, Тэр надад хайртай учраас залбирлыг минь сонсож, хариулсныг би мэдсэн” хэмээн ярьсан юм.

Түүнийг өөртөө тохиолдсон явдлын тухай ярихад би зүрх сэтгэлдээ маш их баяр баяслыг мэдэрч билээ. Тэрхүү үйл явдлын үед би ариун газар дээр байснаа мэдэж байлаа. Түүний үг үнэн гэдгийг Ариун Сүнс надад баталсан. Тэнгэрлэг Эцэг биднийг агуу хайраар хайрладгийг, Тэрбээр Өөрийнхөө тухай болон Өөрийн үнэнүүдийг мэдэх зэмсэг болгон Мормоны Номыг бидэнд өгснийг түүний гэрчлэл надад сануулсан юм. Бид Мормоны Номон дахь зарчмуудыг дуулгавартай дагавал бидний



*Мормоны Ном
үнэн гэдгийг
мэдэхийг хүс-
сэн хэнд ч
гэсэн туслах
хүч энэ но-
монд бий.*

амьдрал өөрчлөгдөх болно.

Бидний тэр хичээл хэрхэн дууссаныг би өнөөг хүртэл мартдаггүй. “Би Мормоны Ном үнэнийг мэдсэн болохоор одоо яах вэ?” гэж тэр эгч биднээс асуухад

“Баптисм хүртэх хэрэгтэй” гэж бид хариулж билээ.

“Тэгвэл би баптисм хүртнэ ээ” гэж тэр даруухнаар хариулсан нь түүний бат бөх, энгийн гэрчлэлийн илрэл байлаа.

Мормоны Ном аз жаргал, амар амгаланг олоход бидэнд туслах хүчтэй юм. Бид энэ номыг уншсанаар сайхь эгч Аврагчийн үлгэр жишээг даган баптисмын ус руу орох шийдвэр гаргасан шиг Есүс Христийн сайн мэдээгээр амьдрах шийдвэр төгс байдлыг өөртөө хөгжүүлэх болно. ■

ШУДАРГА ГЭРЧЛЭЛ ГЭЖ ЮУ ВЭ?

*Таны гэрчлэл
өөрийн чинь
боддогоос илүү
хүчтэй байж
болно.*

Элиз Александрия Холмз

Өөрийгөө гэрчлэлийн цуглаан дээр сууж байна гэж бод. Гишүүд босч гэрчлэлээ хуваалцахыг харсан үедээ та өөрөө ч бас гэрчлэлээ хуваалцсан гэж бодно. Харин юу гэж хэлэх билээ? Индэр дээр гартал уйлж эхэлбэл яах билээ? Бас *уйлахгүй* бол яах вэ? Та гэрчлэлтэй атлаа эргэлзэж магадгүй. Эсвэл гэрчлэл чинь ямар төвшинд байгааг мэдэхгүй байж болно. Гэрчлэл гэж юу болох хийгээд юу гэрчлэл биш болохыг мэдэхэд тань туслах зарим удирдамжийг доор өгүүлэв.

Гэрчлэл бол үнэн зүйлд итгэх итгэл үнэмшил хийгээд мэдлэг юм.

“Шударга гэрчлэл” (Алма 4:19) цэвэр итгэлээс эхэлдэг. Таны гэрчлэл бол таны итгэдэг буюу үнэн гэдгийг нь мэддэг ямар нэг зүйлийн сүнслэг гэрч мөн (С ба Г 80:4-ийг үз). Таныг гэрчлэлээ хуваалцах үед *мэднэ, итгэдэг* мөн *гэрчилж байна гэсэн үгс таны гэрчлэлийн хамгийн шударга бөгөөд хүчтэй хэсэг байх болно*. Хэрэв та “Мормоны Ном үнэнийг би мэднэ” хэмээн чин сэтгэлээсээ хэлдэг бол амьдралыг өөрчлөх болон бусдад нөлөөлөхийн тулд Сүнсийг урих хүч танд байна гэсэн үг.



Тэргүүн Зөвлөлийн
Хоёрдугаар зөвлөх,
Ерөнхийлөгч Диетер
Ф.Угдорф, “Waiting on
the Road to Damascus,”
Лиахона, 2011 оны
5-р сар, 70.

ИЛҮҮ ӨРГӨН ЦАР ХҮРЭЭТЭЙ ОЙЛГОЛТ

“Христийн тухай мэдэхийг шаргуу эрэлхийлэгчид эцэстээ Түүнийг мэдэх болно. Их Эзэний бурханлаг дүр зураг бага багаар, таавар лугаа адил нэг удаад нэг хэсэг нь нээгдсээр тэдэнд Түүний дүр зураг бий болно. Хэсэг тус бүрийг ялган таних нь амаргүй бөгөөд энэ нь бүхэл хэсэгт хэрхэн холбогдох нь тодорхой харагддаггүй. Хэсэг бүр бидэнд зургийг илүү сайн олж харахад тусална. Эцэстээ хангалттай олон бүрэлдэхүүн хэсэг нэгдэн нийлсэн үед бид зургийн гоё сайхныг мэддэг. Тэр үед бид туршлагаа эргэж хараад, Аврагч үнэхээр бидэнтэй хамт байхаар ирсэн тухай нэг дор биш харин алгуураар, анир чимээгүй, бараг ажиглагдамгүйгээр мэддэг билээ.”

**ШУДАРГА ГЭРЧЛЭЛИЙН
ТУХАЙ ЗАЛУУЧУУД
ЮУ ГЭЖ ХЭЛСНИЙГ
СОНИРХОЁ.**

“Зарим үед хамгийн агуу гэрчлэл хүүхдийн гэрчлэлтэй маш адилхан байдаг. Есүс Христ болон Тэнгэрлэг Эцэг амьд бөгөөд Тэд бидэнд хайртай гэдгийг гэрчлэх нь хамгийн агуу гэрчлэл мөн.” —Матиас К., Аргентин

“Шударга гэрчлэлтэй байх нь чухал гэдэгт би итгэдэг. Учир нь бид бусдыг сайн мэдээнд авчрахад энэхүү гэрчлэлээ ашиглаж чадна.” —Квейд Х., Австрали

“Гэрчлэл бол таны хамгийн найдвартай түшиг тулгуур. Хэрэв та бат бөх гэрчлэлтэй бол эргэн тойронд чинь юу ч болж байлаа гэсэн тулгарсан асуудал бэрхшээлийг төвөггүй даван туулж чадна.”

—Зейн В., Калифорни, АНУ

“Хэрэв хүн ямар нэг зүйлд үнэхээр итгэдэг бөгөөд гэрчлэлээ хуваалцах үед түүний үг бусдад нөлөөлж бас тэдний гэрчлэлийг хүчирхэгжүүлж байвал энэ нь үнэн гэрчлэл мөн гэж би боддог.”

—Замагомейн М., Өмнөд Африк

Зөвхөн танд зориулж хийсэн дотроо эвлүүддэг зурагтай том хайрцаг байна гэж төсөөлөн бод.

Та хайрцагны ханан дээрх зургийг ашиглан эвлүүлэхийг хичээнэ. Зургийн хоёр хэсэг нийлэхэд та тэднийг хоорондоо уялдаатай гэдгийг мэдэх болно. Гэрчлэл ийм байдлаар өсч хөгждөг. Сүнслэг туршлагатай болохын хэрээр гэрчлэлийн тань өөр өөр хэсгүүд нийлэн нэгдмэл болж, сайн мэдээний тодорхой үнэнүүдэд итгэх буюу тэдгээрийг мэддэг болно.

Сүмийн тухай бүх зүйл үнэн гэдгийг та одоохондоо мэдэхгүй ч гэсэн хэрэв тэдгээрийг мэдэх чин зүрхний хүсэл өөрт чинь байвал Тэнгэрлэг Эцэг таныг адисалж, эдгээр зүйлийг мэдэхэд тань туслах болно.

Гэрчлэл хувийн шинжтэй

Зургийг эвлүүлэх үед гэр бүл, найз нөхөд чинь хэсгүүдийг нийлүүлж зураг болгоход танд тусалж болно. Гэвч хэсгүүдийг эвлүүлж зураг болгоод үүнийгээ хамгаалах нь таны үүрэг юм. Зарим үед та эцэг эх, найз нөхдийнхөө итгэлд

тулгуурлаж болно. Гэвч та илүү их сүнслэг туршлагатай болохын хэрээр өөрийнхөө туршлагад улам их итгэлтэй болно.

Хүн сайн мэдээнд өсч хөгжихийн хэрээр гэрчлэлээ хөгжүүлэх нь чухал юм. Зургийг эвлүүлэх өөр өөр арга хүмүүст байдаг бөгөөд нэг нь хоёр хэсгийг ирмэгээр нь нийлүүлэхэд нөгөө нь өнгө өнгөөр нь тохируулах гэж оролддог шиг бид бүгд өөрийнхөө өвөрмөц итгэл, туршлагаар дамжуулан хувийн гэрчлэлээ төлөвшүүлдэг билээ.



ГЭРЧЛЭЛ

Хэрэв та ямар нэг зүйлийн талаар эргэлзвэл удирдамж авч, үнэнийг мэдэхийн төлөө чин сэтгэлээсээ залбир. Залбирлын хариу бидний хүсэн хүлээсэн байдлаар ихэвчлэн ирдэггүй ч нүд, чихээ тавин хариуг анхааралтай хүлээ.

Гэрчлэл байнга өсч байдаг

Ямар ч зүйл хийлгүйгээр эвлүүлсэн зургийг хайрцгаас гаргаж ирэх боломжгүйтэй адил та гэрчлэл нэг дор ирдэг гэж эндүүрч болохгүй. Та сайн мэдээний үнэнүүдийг бага багаар, хэсэг хэсгээр суралцаж чадна.

Бат бөх гэрчлэлийг өөртөө төлөвшүүлэх нь байнгын хүч чармайлтыг шаардана. Сайн мэдээний мэдлэгээ өсгөн нэмэгдүүлэхээр ажиллавал Ариун Сүнс таны хүч чармайлтыг адисалж, гэрчлэл тань байнга өсөн нэмэгдэх болно. ■

Би ийм гэрчлэлтэй бил үү...?

Би гэрчлэлээ хэлэхдээ ямар нэг түүх буюу туршлагыг хуваалцах ёстой юу?

Хүмүүс гэрчлэлээ хэлэхдээ түүх юм уу хувийн туршлагаа олонтоо хуваалцдаг бөгөөд энэ нь гэрчлэл хэрхэн өсөн нэмэгддэгийг харуулах хамгийн сайн арга болж чадна. Гэвч түүх бол гэрчлэл биш. Товчхон бөгөөд тохиромжтой түүх аль нэг сургаалыг дүрслэн өгүүлэхэд тусалж болно, гэхдээ уг түүх гэрчлэлийг тань хэрхэн өсгөсөн мөн уг туршлагаас та ямар сайн мэдээний үнэнүүдийг суралцсанаа хуваалцаарай. Гэрчлэл гэдэг бол таны очиж үзсэн газрууд эсвэл хийж бүтээсэн зүйл, амжилт ололтын тань тухай мэдлэг биш, харин сайн мэдээний тухай таны мэдлэг юм.



Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Давид А.Беднар заасан нь: "Гэрчлэл бол Ариун Сүнсний гэрчээр оюун ухаан, зүрх сэтгэлдээ үнэн гэж мэддэг зүйл мөн (С ба Г 8:2-ыг үз). Бид сануулах, уриалах эсвэл зүгээр л сонирхолтой туршлагаа хуваалцах төдийгүй үнэнийг сэтгэл зүрхэндээ шингээн дээдэлбэл үгийнхээ үнэнийг батлах Ариун Сүнсийг урьж чадна."¹

Нөгөөтэйгүүр, хуваалцах туршлагынхаа талаар сайтар тунгаа. Нүгэл, наманчлал болон сүнсний ариун нандин туршлагатай холбоотой түүхүүд өөрийн чинь болоод өрөөл бусдын хувьд нэн хувийн шинжтэй байдаг. Хэрэв та сүнслэгээр өдөөгдөөгүй бол ийм түүхүүдийг олны өмнө хуваалцах ёсгүй. Сүнслэгээр өдөөгдсөн тохиолдолд ч гэсэн, болсон явдлыг нарийн тодорхой тоочилгүй ерөнхийд нь ярьж, уг туршлагаас сурсан зүйл дээрээ анхаарал төвлөрүүл.

Би гэрчлэлээ хуваалцахдаа хайр, талархлаа илэрхийлэх ёстой юу?

Та гэрчлэлээ хуваалцах үед хайр, талархлаа илэрхийлэх нь тохиромжгүй биш ч гэсэн ийнхүү талархал илэрхийлэх нь гэрчлэл биш юм. Гэрчлэл нь сайн мэдээний тухай таны сурч мэдсэн сүнслэг зүйлс дээр төвлөрдөг. Хайр, талархлаа илэрхийлэх нь гэрчлэлийг орлох ёсгүй.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч М.Рассел Баллард ийн хэлжээ, "Манай олон гишүүний гэрчлэлд 'Би талархалтай байдаг', 'Би хайрладаг' гэсэн үгс байнга сонсогддог [би] санаа зовдог. Маш цөөхөн гишүүд 'Би мэднэ' хэмээн даруухнаар чин сэтгэлээсээ хэлдэг."²

Үнэн гэрчлэлтэйгээ харуулахын тулд би уйлах буюу сэтгэл хөдлөлөө харуулах ёстой юу?

Олон хүн гэрчлэлээ хуваалцах буюу Сүнсний хүчтэй мэдэрсэн үедээ уйлж сэтгэлийн хөдөлгөөнөө харуулдаг ч хүн болгон Сүнснийг мэдэрсэн үедээ ийм хариу үйлдэл үзүүлдэггүй. Та гэрчлэлээ хуваалцах үедээ бусдыг дуурайж сэтгэлийн хөдөлгөөнөө илэрхийлэх ёсгүй.

Ерөнхийлөгч Ховард В.Хантер (1907–1995) хэлсэн нь: "Хүчтэй сэтгэл хөдлөл буюу нулимс аяндаа урсах нь Сүнс тэр хүнд байгаагийн тэмдэг гэж үзэх хандлага бий болсонд миний санаа зовнидог. Их Эзэний Сүнс сэтгэл догдлуулж, нулимс мэлмэрүүлэхэд хүргэж болох ч сэтгэл хөдлөлийн энэхүү гадаад илэрхийллийг тухайн хүнд Сүнс байгаа нь тэр гэж эндүүрэх ёсгүй."³

Хэрэв би өөртөө гэрчлэл бий гэдэгт итгэлгүй байвал гэрчлэлээ хуваалцах гэж хичээх ёстой юу?

Таны гэрчлэл хангалттай хүчтэй эсвэл бусадтай хуваалцахаар хангалттай үнэ цэнэтэй биш мэт санагдаж болох ч та гэрчлэлээ хуваалцаж байхдаа танд ямар их гэрчлэл байгааг олж мэдэх болно. Гэрчлэлээ хуваалцахаас бүү ай. Хэдийчинээ их гэрчлэлээ хуваалцах тусам гэрчлэл чинь төдийчинээ өсөн нэмэгддэгийг та мэдэх болно.

Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ерөнхийлөгч Бойд К.Пакер хэлсэн нь:

"Гэрчлэлтэй болох хүртлээ гэрчлэлээ хуваалцаж би яаж чадах юм бэ?' Бурхан амьд, Есүс бол Христ, сайн мэдээ үнэн гэдгийг би яаж гэрчилж чадах юм бэ? Надад ийм гэрчлэл байхгүй байхад, эдгээр зүйлсийг гэрчлэх нь шударга бус хэрэг биш үү?' хэмээн номлогч асуух нь байдаг л зүйл юм.

Би танд нэг зарчмыг заая: гэрчлэлийг хуваалцах үед гэрчлэл байгаа нь мэдэгддэг. Сүнсний мэдлэгийн төлөөх эрэл хайгуулд чинь хаа нэгтээ, философичдын нэрлэдгээр 'итгэлийн нахиа' байж л байгаа. Энэ бол та гэрлийн ирмэг дээр хүрч очоод ганц хоёрхон алхмын цаадах зам тань гэрэлтэй гэдэгт бат итгэн, харанхуй руу алхан орох агшин юм."⁴

Эшлэл

1. Давид А.Беднар, "More Diligent and Concerned at Home," *Лиакхона*, 2009 оны 11-р сар, 19.
2. М.Рассел Баллард, "Pure Testimony," *Лиакхона*, 2004 оны 11-р сар, 41.
3. Ховард В.Хантер, *Миний сайн мэдээг номло: Номлолын ажлын удирдамж* (2004), 99.
4. Бойд К.Пакер, "The Quest for Spiritual Knowledge," *Лиакхона*, 2007 оны 1-р сар, 18.



Бусдад сүрхий болж ХАРАГДАХ ГЭЖ

Намайг зан авираа
өөрчлөхөөр ший-
дэх хүртэл миний
амьдрал тэр чи-
гээрээ хуурмаг дүр
исгэлт байлаа.

Британни Томпсон

Өсвөр насны хүүхэд миний хувьд сургууль гэдэг жүжиг тоглохтой адил санагддаг байв. Сайн, ухаалаг, төгс мэт харагдахыг хичээдэг киноны муу дүрийн баатруудыг та нар санаж байгаа биз дээ? Би тэдэнтэй адил болохсон гэж мөрөөддөг байлаа. Би хамгийн мундаг муу дүрийн баатруудтай адил жүжиглэхийг хичээдэг байв. Бас сургууль дээр найз нартаа мундаг хүн болж харагдахын тулд өөрийнхөө жишгийг доогуур мэт харагдуулахыг хичээдэг байлаа. Зохисгүй үг хэллэг хэрэглэн, хүмүүсийг шоолохдоо би чанга инээх дуртай байлаа.

Үзэгчдийг хөгжөөдөг нэгэн байхыг би хүсдэг байв. Тиймээс би хэрхэн бялдуучилахыг олж мэдсэн юм. Би биологийн хичээл дээр дандаа хошин үг хэлж марзганан, гар бөмбөгийн багаа үдэшлэг зохион байгуулаач гэж ятган, гэнэн томоогүй залуу эмэгтэйн нэр хүндээ унагадаг байлаа. “Найз нар маань намайг сайн зүйл хийдэг номын охин гэж бодохгүй байгаасай!” хэмээн бодно.

Би хүмүүсийн боддог шиг тийм ноцтой нүгэл үнэхээр үйлдээгүй болохоор эелдэг бус зан авирыг гаргах нь зүгээр гэж өөртөө итгүүлэхийг хичээдэг байв. Үнэхээр миний

буруу байсан! Миний амьдралын үнэн төрх, би өөрөө ч хараад гэвчихээргүй төвшинд хүрсэн юм. Би сургууль дээрээ нэрд гарах тусам өөрийн тоглодог хуурмаг дүрдээ улам дургүй болж байлаа.

Нэг өдөр миний хоёр найз, итгэл бишрэлийнхээ төлөө бат зогсохоос ичдэггүй, эелдэг сайхан зантай тамирчин Женниферийн тухай ярилцаж байлаа. Миний найз нарын нэг, долдугаар ангийнхандаа хамгийн сайхан, нэрд гарсан, ухаалаг охин ингэж ярьсан юм: “Женнифер бусдаас үнэхээр өөр шүү. Би сүмдээ итгэх итгэлийнхээ хувьд түүн шиг зоригтой байхыг хүсдэг. Тэр бол долдугаар ангийнхнаас итгэлээрээ амьдардаг цорын ганц сурагч гэдгийг би мэднэ.” Би бүр гайхаж хоцров.

“Тэр миний талаар ганц ч үг хэлээгүй атлаа Женниферийн талаар яаж ингэж ярьж чаддаг байна аа?” хэмээн би ихэд гайхаж билээ. “Ямартай ч, манай сүм өндөр жишгүүдтэй шүү дээ!” Найз минь намайг ядахдаа сайн үлгэр жишээч охин гэсэнгүйд би дэлбэртлээ уурлаж билээ. Тэгтэл би өөрийн амьдралыг гол үйл явдал болгон

үзүүлэхээр кино театрын урд талын эгнээнд сууж байгаагаар өөрийгөө гэнэт төсөөлөн бодлоо.

Найз нартаа үзүүлдэг байсан муу үлгэр жишээгээ тунгаан бодлоо. Ямар ч хүүхэд намайг хараад “Би түүн шиг зоригтой, онцгой байхыг хүсэж байна” гэж хэлэхгүй шүү дээ. Ямар хүн болсноо хараад үнэхээр дургүй минь хүрч билээ.

Зан авираа өөрчилж, сайн нэртэй болох нь миний хувьд урт удаан үйл явц байлаа. Бусдыг хөгжөөх гэж зохисгүй үгсийг ам мэдэн бурахын оронд амаа хамхиж явахыг би одоо ч гэсэн хичээж байгаа. Гэвч хэн нэгнийг гомдоохгүйгээр найз нараа инээлгэж болно гэдгийг би ойлгосон. Бас бүдүүлэг шог яриа сонссон үедээ шоолж инээхгүйгээр өрөөг орхин гарч явах хэрэгтэйг мэддэг болсон. Олон найзтай байхын тулд “муу хүн” байх албагүй. Итгэдэг зүйлийнхээ талаараа амар амгаланг мэдрэх нь өөрийгөө хэн бэ гэдгийг нууж явахаас хавьгүй дээр учраас би зан авираа өөрчилж чадсан юм. ■



НИНЖИН СЭТГЭЛИЙН ШИВНЭЭ

“Дайснаа хайрла, та нарыг үзэн яддаг хүмүүст сайныг үйлд” (Лук 6:27).

Дебора Мооре

Бодит түүхээс сэдэвлэв.

Карсон өнөөдөр ирсэн” гэж ээж нь Хүүхдийн Хэсгийн ерөөний үүдэнд зогсож байгаа хөвгүүн рүү заахад

Жеймс амандаа үглэн гонгинов. Карсон жинс, хуучин цамц өмссөн байлаа. Аав ээж хоёр нь ийм хувцастай сүм рүү явахыг бас Карсоны хийдэг бусад олон зүйлийг хийхийг түүнд огт зөвшөөрдөггүйг Жеймс мэдэж байлаа.

Өнгөрсөн долоо хоногт Карсон сургууль дээр багштайгаа муухай харьцсан учраас хичээлээсээ хөөгджээ. Тэр Жеймсийн хувцсаа өмссөн байдлыг үргэлж гоочилж, сургууль дээрх хамгийн намхан хөвгүүн гэж түүнийг шоолж эвгүй байдалд оруулдаг байлаа.

“Тэр Вин эгч рүү хашгичиж, өөдөөс нь хэрэлдвэл яана аа?” гэж Жеймс асуулаа.

“Зүгээр ээ. Бүх зүйл сайхан болно гэдэгт би итгэлтэй байна” гэж ээж нь хэллээ. “Карсон сүмд ирж байгаагүй болохоор сандарч байгаа байх.”

Хичээл эхлэхэд Вин эгч хэн хэн судраа авчирсан бэ? гэж асуув. Жеймс болон ангийн бусад хүүхдүүд бүгдээрээ гараа өргөхөд Карсон толгой сэгсрэв. Тэр ичсэн байдалтай харагдсанд Жеймс гайхлаа. Карсон гэрийн даалгавраа хийгээгүй үедээ тоглоом

штоглоом хийдэг байв. Жеймс энэ тухай бодох тусам шинэ сүмд анх удаа ирэх нь ямар байдаг бол хэмээн улам их бодох болжээ.

Вин эгч Карсонд өөрийнхөө судрыг өглөө. Карсоны унших ээлж болоход Жеймс санаа нь зовж эхлэв. Карсон судрыг шалан дээр шидчихээд уншихгүй гэвэл яана аа?

Гэтэл Карсон тэгсэнгүй. Тэр хуудсан дээрх үгсийг ширтэн харснаа хөмсгөө зангидан муухай харав. Хэсэг хугацааны дараа Жеймс Карсонг сайн уншиж чадахгүй байгааг ойлгожээ. Жеймс урьд нь түүнийг ингэж муу уншдаг гэдгийг сургууль дээрээ огт анзаарч байсангүй.

Жеймс юу хийнэ гэж та нар бодож байна вэ? Жеймс Карсоныг шоолох уу? Эсвэл түүнийг тоохгүй орхих уу? Хэрэв чи Жеймсийн оронд байсан бол юу хийх вэ? Юу болсныг мэдэхийн тулд хуудсыг эргүүл.



Жеймс Карсонд хүрээд “Үнэнээр” гэж шивнэлээ.

Карсон гайхан харснаа “Үнэнээр” гэж хэлээд шүлгийг цааш нь уншлаа. Эхний үгийг унших гэж зүдэрч байхад нь Жеймс түүнд тусалсан ажээ. Карсон уншиж дуусаад Жеймсийн өөдөөс харж толгойгоо бага зэрэг дохив.

Карсон сургууль дээрээ очоод өөрчлөгдөнө гэдэгт Жеймс

итгэхгүй байлаа. Хөгжилтэй нь тэрээр нэг их санаа зовсонгүй. Өөрийг нь үргэлж зовоодог байсан хөвгүүнд тусалсан нь түүнд аятайхан санагдсан ажээ. Тийм мэдрэмж амархан алга болдоггүй. ■



Нэг өдөр наймаг найзуудтайгаа тоглоомын талбайд тоглож байтал нэг охин ирж бидэнтэй нийллээ. Тэр бусад

хүүхдүүдийг дээрэлхэж, эелдэг бус харьцдаг байлаа. Тэр охин тоглоомын дүрмийг зөрчиж эхлэхэд би “Чи өөрийнхөөрөө тогло, харин бид дүрмээ баримталж тоглоё” гэлээ. Тэр сэтгэлээр унасан мэт харагдсан бөгөөд цаашаа явав. Хожим нь би тэр охинд хэлсэн үгээ эргэцүүлэн бодоод, түүнийг гомдоосноо ойлгосон юм. Дараа нь би түүнтэй тааралдаад уучлалт гуйж, “Би чамайг бидэнтэй тоглож болохгүй гэж хэлээгүй шүү дээ” гэхэд нөгөөх охин зүгээр ээ гэв. Тэр охин бид хоёр найзууд биш ч гэсэн би түүнд найрсаг хандсанаараа Есүс надаас хийхийг хүсдэг зүйлийг хийсэн гэж боддог.

Раижен К., нас 9, Юта, АНУ


БИ ТЭР ОХИНД ИНГЭЖ ХЭЛЭХ ЁСТОЙ БАЙСАН ЮМ





Арванхоёр
Төлөөлөгчийн
Чуулгын
Ахлагч А.Том
Перри энэ
асуултын
талаар бод-
лоо хуваал-
цаж байна.

Эхэн үеийн анхдагчид олон жилийн тэртээ аж төрж байжээ. Би тэднээс юу сурч болох вэ?



Анхдагчид Солт Лейкийн Хөндийд хүрч ирсний ойг 7 сарын 24-нд тэмдэглэдэг.

Тэд зэлүүд нутгийг зорин алсын аянд гарахын тулд бүх зүйлийг-гэр орон, ажил төрөл, фермээ, тэр ч бүү хэл гэр бүлийн хайртай гишүүдээ ардаа орхисон юм.

Анхдагчид хээр талыг

туулахдаа бүжиглэж, дуулж байжээ. Тэд аян замдаа түмэн зовлон бэрхшээлтэй тулгарсан ч санаа сэтгэл өөдрөг байсан.

Эхэн үеийн анхдагчид Бурханд болон удирдагчдадаа итгэх бат бөх итгэлээр жигүүрлэн уулсын зэлүүд хөндийнүүдэд өв тэгш хамт олныг бий болгохын төлөө

хөдөлмөрлөхөөр явсан юм.

Эдгээр яруу алдарт анхдагчид итгэл бишрэл, эрэлхэг зориг, мэргэн ухааны хэчнээн агуу өвийг бидэнд үлдээгээ вэ! ■

"The Past Way of Facing the Future," Лиакхона, 2009 оны 11-р сар, 74; *"A Meaningful Celebration,"* Ensign, 1987 оны 11-р сар, 70, 72-оос авав.

Түүх бүтээж байгаа нь

Чад Э.Фарез

Сүмийн сэтгүүлүүд

Сома, Эштер, Ката Б. нар хаадын орд харш, үзэсгэлэнт олон гоё уран барилгатай Унгарын Будапешт хотод амьдардаг. Энэ гурван хүүхэд хотынхоо түүхийг сургуулийн

хичээлээр үзсэн бол эдүгээ Сүмийн түүхийг сонирхож байгаа ажээ.

“Иосеф Смитийг залбирахад Тэнгэрлэг Эцэг, Есүс хоёр түүн дээр хүрч ирснийг би тодорхой

мэдэх дуртай” гэж 7 настай Эштер ярилаа.

10 настай Сома Бага Алмагийн тухай унших дуртай гэнэ. “Тэр эхлээд муу хүн байснаа дараа нь хэрхэн сайн хүн болохоор шийдсэн нь надад таалагддаг.”

Иосеф Смит, Бага Алма нарын тухай Будапештэд цөөхөн хүмүүс мэддэг ч Сома, Эштер, 5 настай Ката нар сайн үлгэр дуурайл үзүүлж, зөвийг сонгосноор улам олон унгарчууд Сүмийн тухай мэдэх болно гэдэгт итгэлтэй байдаг ажээ. ■





Уран зураг бол Эштерийн дуртай хичээл.




Мормоны Ном унгар хэлээр 1991 онд хэвлэгджээ.



Сома гэрийнхээ ойролцоо дугуйгаар явах дуртай гэнэ.

Унгарын 2,200 хүн тутмаас нэг нь Сүмийн гишүүн ажээ.



Германы Фрайбергийн Ариун сүм бол Будапештэд хамгийн ойрхон ариун сүм бөгөөд 350 бээр (560 км) зайтай оршдог.

Германы Фрайбергийн Ариун сүм

GERMAN



Будапешт

УНГАР УЛС

УНГАР УЛС

Хар тэнгис

Газрын Дундад Тэнгис

Хүүхдийн Хэсгийн энэ сарын сэдвийн тухай илүү ихийг мэдэхийн тулд та нар энэ хичээл болон үйл ажиллагааг ашиглаж болно.

Би **сайн мэдээний** **зарчмуудаар** амьдарснаар зөвийг сонгодог.



Хэзээ гэртээ эргэж ирэхийг мэдэхгүйгээр номлолд явах талаар төсөөлж чадах уу? Чамд ямар санагдах вэ? Бэлтгэхийн тулд юу хийх вэ?

Мозая хааны дөрвөн хөвгүүн Аммон, Аарон, Омнер, Химнай болон тэдний найз Алма нар 14 жил үргэлжилсэн номлолд явсан ажээ. Мозаягийн хөвгүүд улс орныхоо хаан болж болох байсан ч тэд зүрх сэтгэлийнхээ хүслийг дагасан юм. Тэд болон Алма Есүс Христийн сайн мэдээнд хөрвөж, өөрсдийн дайснууд болох леменчүүдтэй сайн мэдээг хуваалцахыг хүсчээ.

Эдгээр залуу эрчүүд Бурханы

хүчгүйгээр зорилгоо биелүүлж чадахгүйг мэдэж байлаа. Алма 17:2–3 шүлгүүд энэхүү хүчийг тэд хэрхэн олж авсан тухай тайлбарладаг: “Тэд Бурханы үгийг мэдэж болохын тулд судруудыг хичээнгүйлэн судалсан байв. . . . Тэд өөрсдийгөө их залбирал мөн мацаг барилтанд зориулсан байв; тиймийн тул тэдэнд бошиглолын суу билэг, мөн илчлэлтийн суу билэг байлаа, мөн тэд Бурханаас хүлээн авсан хүч болон эрх мэдэлтэйгээр зааж байв.”

Мацаг барьж, залбирсан нь Бурханаас адислал авахад нь эдгээр залуу эрчүүдэд тусалсан ажээ. Алма болон Мозаягийн дөрвөн

хөвгүүн шиг Тэнгэрлэг Эцэгээс та нарт зориулсан адислалуудыг авахад өөрсдийгөө бэлтгэхийн тулд та нар мацаг барин, залбирч болно. ■



Дуу ба судар



- “The Wise Man and the Foolish Man (Ухаантай ба ухаан муутай хүн),” *Children’s Songbook*, 281.
- 1 Нифай 3:16

Зөвхөн чи

Ямар зорилгоор Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч байгаагийнхаа сануулга болгон орон дээрээ өнгөтэй чулуу тавь. Мацага эхэлсний дараа нөгөөх чулууг орныхоо хажууд шалан дээр шилжүүлж тавь. Мацаг барилт чинь дуусахад шалан дээрх чулуу өвдөг сөгдөн залбирахыг өөрт чинь сануулах болно. Сар бүр энэ чулууг мацгийн ням гарагт болон гэр бүл, тойрог, салбартайгаа тусгай мацаг барихад сануулагч болгон ашиглаж болно.

Шаардлагатай зүйлс:

нэг мөлгөр чулуу буюу хайрга
нийлэг будаг буюу самбарын
өнгөтэй харандаа, зургийн бийр




1.




Чулууг угааж хатаа.

2.



Будгийг цаасан тавган дээр буюу цаасан дээр шахаж гарга.

3.



Бийр буюу самбарын үзгээр чулууг буд. Чулуун дээр нэрээ бичих эсвэл өөр зураг зурж чимэглэ.

4.



Будгийг бүрэн хатаасны дараа чулууг орон дээрээ тавь.

Зөвийг сонгох цаг: Залбирч, мацаг барих нь

Мацаг барихын өмнө нь болон дараа нь залбирахын ач холбогдлыг гэр бүлээрээ ярилц. Дараагийн удаа мацаг барихдаа мацгийн зорилгынх нь тухай ярилц. Яагаад мацаг барьж байгаа тухайгаа Тэнгэрлэг Эцэгт хандан залбирч мацаг барилтаа эхэл.

Томасын ГЭРЧЛЭЛ

“Үнэний тухай гэрчлэлийг Их Эзэн бибээр та нарт өгч байна” (С ба Г 67:4).



Жошуа Ж.Перки

Сүмийн сэтгүүлүүд
Бодит түүхээс сэдэвлэв

Тэр бүлийн үдэшт хүн бүр ямар нэг зүйл хийх хэрэгтэй байлаа. Ээж гэр бүлийн үдшийг хөтлөн явуулж, аав хичээл заах болов. Томасаас бусад хүүхдүүд залбирал хэлж, хөгжим тоглон, үйл ажиллагаа зохион

байгуулав. Энэ долоо хоногт гэрчлэлээ хэлэх нь Томасын ээлж байсан ч тэр ичээд байсан гэнэ.

Томас өмнө нь гэрчлэлээ хуваалцсанаас хойш урт хугацаа өнгөрсөн болохоор юу гэж хэлснээ санахгүй байжээ. Тиймээс нээлтийн дуу дуусч, залбирал хэлсний дараа Томас дуугарсангүй.

“Чиний ээлж боллоо” гэж ээж нь түүнд сануулав.

Цонхоор харагдах мөнх ногоон мод юу гэж хэлэхийг нь түүнд хэлэх юм шиг Томас гадагш харлаа.

Аав нь Томасын дэргэд суугаад юу болсныг асуув.

“Гэрчлэл гэж юу болохыг би мэдэхгүй байна” гэж Томас аяархнаар хэллээ.

“Би чамд тусалъя” гэж аав нь хэллээ. “Гэрчлэлээ хэлнэ гэдэг чинь чи мэддэг эсвэл итгэдэг

юмсынхаа тухай бидэнд хэлнэ гэсэн үг. Судар яагаад унших дуртайгаа бидэнд хэлж болно. Судар унших нь Сүнснийг мэдрэхэд үргэлж тусалдаг шүү дээ.”

Гэвч Томас бэлэн биш байв. Хүн бүр түүнийг ямар нэг юм хэлэх байх гэж хүлээж байлаа. Тэр толгой сэгсрэв. “Чадахгүй нь ээ. Гэрчлэл гэж юу болохыг би мэдэхгүй.”

Аав нь Томасын мөрийг илээд, “За, яахав. Гэрчлэлээ дараа хэл дээ” гэв.

Томас тэр орой Мормоны Номыг барин орон дээрээ сууж байлаа. Аавын зөв байсан ба судар уншихад үргэлж сайхан байдаг. Томас өдөрт нэг бүлэг уншихыг хичээдэг байсан ч хэтэрхий урт санагддаг байлаа. Тэр судраа 1 Нифай 17 дээр нээв.

“Яасан урт юм бэ, энэ чинь!” гэж Томас шивнэлээ. Тэгээд Тэнгэрлэг Эцэгт хандан товчхон залбирал хэлж, тусламж хүсэв. Тэгтэл цаг хэчнээн амархан өнгөрсөнд тэр их гайхлаа.

Томасыг гэрлээ унтраахаас өмнөхөн аав нь тавтай нойрсоорой гэж хэлэхээр орж ирэв.

“Аав аа, юу болсон гээч?”

“юу болсон юм бэ, миний хүү?”

“Бүлгүүд нь дэндүү урт болохоор би бүтэн долоо хоног судар уншаагүй. Харин өнөө орой би судар уншмаар санагдаад залбирал хэлсэн чинь Тэнгэрлэг Эцэг надад тусаллаа. Бүх бүлгийг уншихад ердөө таван минут л өнгөрсөн юм шиг санагдлаа. Залбирах сайхан юм.”

“Томас, чи сая юу гэж хэлснээ мэдэж байна уу?” гэж аав нь

инээмсэглэн асуугаад, “Чи гэрчлэлээ хуваалцлаа шүү дээ!” гэв.

“Тийм үү?” гэж Томас асуув. “Энэ чинь юу гэсэн үг вэ?”

“Чи залбирлын тухай бас залбирал чамд хэрхэн тусалсан тухай ярилаа. Энэ чинь л залбирлын тухай гэрчлэл шүү дээ.”

Томас амаа ангайн таг дуугүй болов. Хүмүүс гэрчлэлийн тухай түүнд заасан бүх үеийн тухай бодлоо. Тэр үнэхээр гэрчлэлээ хуваалцсанаа мэдлээ!

Томаст сайхан санагдаж, аавыгаа чанга тэврэв.

“Яасан гоё вэ? Би гэрчлэлээ хэлсэн байна ш дээ!” гэж Томас дуу алдлаа. “Аав аа би ирэх долоо хоногт гэр бүлийн үдшээр гэрчлэлээ хуваалцаж болох уу? Миний ээлж биш л дээ. Харин би залбирлын тухай яримаар байна.”

“Тэг л дээ. Ёстой сайхан санаа байна” гэж аав нь хэллээ.

Аавыгаа өрөөнөөс нь гарсны дараа Томас болсон явдлын тухай тэр оройжингоо боджээ. Тэр гэр бүлийнхээ төлөө, судрууд, залбирал, бусад олон зүйлийн төлөө, ялангуяа гэрчлэлийнхээ төлөө бүр ч их талархалтай байлаа. Одоо тэр гэрчлэл гэж юу байдгийг болон гэрчлэлээ хэрхэн хуваалцаагийг мэддэг болжээ. ■



“Гэрчлэлээ хуваалцаж байвал гэрчлэл чинь улам хүчтэй болдгийг чи мэдэх болно.”



Арванхоёрын Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Роберт Д.Хейлс, “The Importance of Receiving a Personal Testimony,” *Ensign*, 1994 оны 11-р сар, 22.

Гэрчлэлээ өсгөх нь

Гэрчлэл бол сайхан ургамалтай адилхан юм. Гэрчлэл нэг удаа багахан өсдөг бөгөөд тордолт, хамгаалалт шаардаг. Гэрчлэлийг эрүүл саруул, гэрэл гэгээтэй байлгахын тул доорх удирдамжийг баримтал.

Хэрэв чи ямар нэг зүйлийг үнэн гэдгийг мэдэж байгаа бол чамд тэр үнэний талаар гэрчлэл байгаа нь тэр. Үнэнийг оюун ухаандаа ойлгоход чинь Ариун Сүнс чамд тусалж, амар амгалан, аз жаргал, гэрэл гэгээ, бүлээн дулаан мэдрэмжийг зүрх сэтгэлд чинь төрүүлэх болно. Доорх зүйлийг уншаад ямар нэг зүйлийг үнэн гэдгийг мэдэх бүртээ энэ хуудсан дээрх цэцгийг буд.

- Бурхан бол миний хайрт Тэнгэр дэх эцэг.
- Тэнгэрлэг Эцэг миний залбирлыг сонсож, хариулдаг.
- Би Есүс Христийн Цагаатгалын ачаар нэгэн цагт Тэнгэрлэг Эцэгтэйгээ дахин хамт амьдарч чадна.
- Иосеф Смит сайн мэдээг дэлхий дээр сэргээсэн.
- Өнөөдөр дэлхий дээр бидэнд бошиглогч байдаг.
- Тэнгэрлэг Эцэг намайг мэдээсэй гэж хүсдэг зүйлсийг судрууд надад заадаг.

Ургамлыг ургахад ус, нарны гэрэл шаардлагатай байдаг шиг чи зөв сонголтууд хийвэл гэрчлэл чинь өсч хүчтэй болно. Гэрчлэлээ хөгжүүлэхэд туслах зарим зүйлийг доор өгөв. Гэрчлэлээ өсгөн нэмэгдүүлэх талаар энэ сард ямар нэг зүйл хийх бүртээ хуудсан дээрх навчийг буд.

- Тэнгэрлэг Эцэгтээ хандан залбир.
- Гэр бүлийн үдшээр эсвэл Хүүхдийн Хэсэгт үг хэлэх үеэр гэрчлэлээ хуваалц.
- Судруудаас унш.
- Хүүхдийн Хэсгийн хичээлийн үеэр болон ариун ёслолын цуглаан дээр хэлж байгаа үгсийг сонсож, суралц.
- Гэрчлэлийнхээ тухай тэмдэглэлдээ бич.
- Бусад хүмүүст найрсаг хандаж бай.
- Гэрчлэлийн тухай бошиглогчид юу гэж заасныг унш. (2009 оны 3-р сарын Лиахона-д нийтлэгдсэн Ерөнхийлөгч Хенри Б.Айрингийн “Үнэн Сүм” өгүүллээр эхэлж болно.) ■

Бидний хуудас




Алина А., нас 7, Украин



Миний гэр бүл, Лукас О.,
нас 5, Бразил



Ариун сүм,
Шерриан П.,
нас 10, Самоа




Малайзын 12 настай Южин И. өвөөтэйгөө хятад шатар тоглох дуртай ажээ. Тэр бас чөлөөт цагаараа найз нартайгаа сагсан бөмбөг, агаарын теннис тоглох дуртай гэнэ. Южин шинэ найз нартай болж, хятад дуу сонсох дуртай.



ЕСҮС АМЬД БӨГӨӨД БИЭНД ХАЙРТАЙГ БИД МЭДНЭ

Бид аав, ээжтэйгээ орой бүр судар уншиж, Есүс Христийн сургаалуудыг судалдаг. Чуулган дээр Сүмийн удирдагчид үг хэлж, судруудаас эш татахыг сонсоод бид эдгээр сургаалуудыг гэр бүлээрээ судалж байснаа санадаг. Өдөр бүр судар судлах нь чухал болохыг бид мэддэг. Бид Тэнгэрлэг Эцэгийн хүүхдүүд гэдгийг, Тэр амьд мөн Есүс Христ, Тэнгэр дэх Эцэг хоёр бидэнд хайртайг мэднэ.

Томас А., нас 8; Аарон А., нас 6;
Сисилия А., нас 10, Аргентин



БИ ЗОРИЛГО ТАВИХ ДУРТАЙ

Би Есүс Христийн зурагтай дэр хийсэн. Учир нь ийм дэр хийх нь миний нэг зорилго байлаа. Би баптисм хүртсэндээ баяртай байна. Би тэмдэглэл хөтөлж, зорилгоо бичсэн дэвтрээ хадгалах дуртай. Бас гэрийнхээ ажилд тусалж, ээжийгээ яаж ажиллахыг харж, ээжийнхээ хийдэг ажлыг хийдэг.


Мириам К., нас 8, Мексик



Келси алдаа гаргасан нь

Жейн МкБрайд Чоейт
Бодит түүхээс сэдэвлэв

“Бид шударга байхад итгэдэг” (Итгэлийн Тунхаг 1:13).





АЛДААНААСАА СУРАЛЦАХ НЬ

Дарси Женсен

Бид заримдаа Келсигийн адил алдаа гаргадаг. Бид алдаа гаргасан үедээ үүний төлөө харамсаж байгаагаар харуулж чадна. Энэ хуудсан дээрх зургуудыг хар. Багана бүрд байгаа бусдаасаа ялгаатай зургуудыг дугуйл.

1. Буруу зүйл хийснээ хүлээн зөвшөөр.



2. "Уучлаарай" гэж хэлэн уучлалт гуй.



3. Дахиж хийхгүй гэдгээ амла.



4. Хийсэн буруу зүйлээ засахын төлөө чадах бүхнээ хий.



БИ ШУДАРГА БАЙЖ ЧАДНА

Энэ зурган дээр байгаа хүүхэд шударга байж чаддаг. Бөмбөг, лаа, гар утас, цаг, жигнэмэг, нохой, хүүхэлдэй, шувууны өд, харандаа, нарийн боов, судрууд болон халбага зэрэг зүйлсийг олж чадах эсэхээ хар.



Сүмийн МЭДЭЭ

Сүмийн мэдээ болон үйл ажиллагаануудын тухай news.lds.org -аас үзнэ үү.

Номлолын шинэ ерөнхийлөгчид үйлчлэхээр дуудагдав

Энэ жилийн эхээр Сүмээс номлолын 110 шинэ ерөнхийлөгчийн нэрийг зарласан. Энэ сард эдгээр шинэ ерөнхийлөгчдийн ихэнх нь өөрсдийн эхнэрүүдийн хамтаар хоёр эсвэл гурван жилийн дуудлагат ажлаа эхлэх гэж байна.

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Австралийн Аделиада	Брадли Д.Картер
Австралийн Перт	Р.Брус Линдси
Австралийн Сидней	Филипп Ф.Ховес
Айдахо Покателло	Марвин Т.Бринкерхоф
Английн Бирмингам	Р.Грэйг Расмуссен
Английн Лондон	Дэвид Ж.Жордан
Английн Лондон Өмнөд	Рожер С.Миллар
Аргентины Бахиа Бланка	Мануел Паррено
Аргентины Неукен	Паул Р.Ловелл
Ардчилсан Бүгд Найрамдах Конго Улсын Лубумбаши	Филипп В.МакМуллин
Атланта Жоржиа	Жонн Р.Хардинг
Балтиморын Мэриленд	Марк Л.Ричардс
Баруун Энэтхэг	Даниел С.Мейр II
Белги/Голланд	Алден С.Робинсон
Болгарын Софи	Майкл С.Вилстэд
Бразилийн Белем	Хосе С.Чичи
Бразилийн Бело Хоризонти	Пасчоал Ф.Фортунато
Бразилийн Кампинас	Карлос Э.Перротти
Бразилийн Куиаба	Кэйт Р.Ребэр
Бразилийн Порто Алежр Умард	Д.Лайн Вraith
Бразилийн Порто Алерж Өмнөд	Палменио С.Кастро
Бразилийн Салвадор Өмнөд	Марсело Андресо
Бразилийн Сан Пауло Зүүн	Роналд А.Феррин
Бразилийн Тересина	Алвасир Л.Сиедшлаг
Бүгд найрамдах Доминикан улсын Сантьяго	Жонн Дуглас
Вануату Порт Вила	Ларри Э.Брюэр
Вашингтон ДС Өмнөд	Маттью Л.Риггз
Вашингтон Спокан	Дональд Э.Муллен
Венесуэлийн Барселон	Хуан С.Часин

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Венесуэлийн Маракайбо	Хуан Ф.Зорилла
Ганийн Кумаси	Леон А.Холмес
Германы Берлин	Хенри В.Косак
Гондурасын Комаугуала	Кандидо Фортуна
Грекийн Афин	Эрик Б.Фрийстоун
Данийн Копенгаген	Шонн Д.Седерхолм
Зимбабве Хараре	Брусон С.Күк
Испанийн Барселон	Марк Л.Пэйс
Испанийн Мадрид	Скотт Т.Жексон
Испанийн Малага	Бага Монте М.Дир
Калифорнийн Оакланд/Сан Франциско	Дэвид Н.Вейдман
Калифорнийн Сан Фернандо	Кеннед Т.Холл
Калифорнийн Санта Роза	Рене Р.Аалба
Камбоджийн Фном Пен	Дэвид С.Мүүн
Канадын Виннипег	Көрк М.Томас
Канадын Калгари	Ховард Николас
Канадын Халифакс	Брайн Лийвит
Колумбын Богота Өмнөд	Летвин Лозано
Колумбын Богота Хойд	Марк Ф.Анделин
Колумбын Меделлин	Роберто О.Питарч
Коста Рика Сан Хосе	Чаад Р.Вилкинсон
Мадагаскарын Антананариво	Дэвид Р.Адамс
Массачусетсийн Бостон	Даниел В.Пакард
Мексикийн Гвадалахара	Ж.Весли Вагнер
Мексикийн Гвадалахара Зүүн	Луис Ф.Камарилло
Мексикийн Куэрнавака	Брус С.Куш
Мексикийн Мексик хот Өмнөд	Роберто Валадез
Мексикийн Монтерри Баруун	Эдвард М.Своп
Мексикийн Пуэбла Хойд	Ралф Н.Кристенсен
Мексикийн Тампико	Ралф Б.Жордан III
Мексикийн Халапа	Пауло Лопез
Мексикийн Хермосилло	Алберто Е.Хернандез

Шинэ номлолууд байгуулагдав

Сүм өөрчлөгдөж буй хэрэгцээнд нөөц боломжоо илүү сайн уялдуулан зохицуулахын тулд 10 шинэ номлолыг байгуулж, зарим номлолыг нэгтгэв.

Колумбын Барранкилья болон Кали номлолуудыг хувааж **Колумбын Меделлин номлол** –г байгууллаа.

Ганагийн Аккра болон Кейп номлолуудыг хувааж **Гана Кумаси номлол** –г байгууллаа.

Мексикийн Веракрус номлолыг хувааж **Мексикийн Халапа номлол** –г байгууллаа.

Мексикийн Пуэбла номлолыг хувааж **Мексикийн Пуэбла Умард болон Пуэбло Өмнөд номлол**-д болголоо.

Шинэ Гвинейн Папуа Порт Моресбай болон Фижи Сува номлолуудыг хувааж **Вануату Порт Вила номлол** -г байгууллаа.

Юта Солт Лейк, Юта Солт Лейк Өмнөд болон Юта Огден

номлолуудыг өөрчлөн зохицуулж **Ютагийн Солт Лейк Баруун, Ютагийн Солт Лейк Төв** гэсэн 2 номлолыг байгууллаа.

Невада Лас Вегас болон Невада Лас Вегас Баруун номлолуудыг өөрчлөн зохицуулж **Невада Рено номлол** -г байгууллаа.

Оросын Москва Баруун номлол задарч хөрш зэргэлдээ Балтик, Оросын Новосибирск болон Оросын Москва номлолуудад харьяалагдах боллоо.

Эдгээр өөрчлөлт нь номлолын удирдагчид солигдох 7-р сард хүчин төгөлдөр болно. Дэлхий даяар одоо нийт 347 номлол байна.

Шинээр байгуулсан номлолуудыг газрын зураг дээрээс харахыг хүсвэл [ldschurchnews.com/articles/62067/New-missions-created.html](https://www.ldschurchnews.com/articles/62067/New-missions-created.html) хаягаар орж үзнэ үү. ■

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Миссисипи Жексон	Марк Ж.Макдонаф
Мозамбик Мапуто	Пауло В.Кретли
Монтана Биллингс	Крис Ж.Мекам
Небраска Омаха	Майкл Д.Вестон
Невада Рено	Дэвид Н.Хермансен
Нигерийн Калибар	Жонн Е.Косин
Норвегийн Осло	Дон А.Эванс
Нью Йорк Ютика	Бага Жосеф Б.Вертлин
Нью Йоркийн Нью Йорк Өмнөд	Кевин Э.Калдервүүд
Нью Йоркийн Нью Йорк Хойд	Томас Б.Морган
Нью Мексик Фармингтон	Дойл Л.Бэйт
Огайо Кливленд	Майкл Л.Веллинга
Оклахома Талса	Скотт К.Шамвэе
Оросын Владивосток	Грегори С.Бринтон
Оросын Ростов-на-Дону	Виллиам Х.Провс
Өмнөд Дакота Рапид-сити	Куртис Э.Андерсон
Парагвай Асунсьон	П.Дэвид Агаззани
Перу Лима Дундад	Алан М.Борг
Перугийн Лима Өмнөд	Шон Дуглас
Перугийн Пиура	Чаад А.Роули
Португалийн Лисбон	Стивен Л. Флюкигер
Сингапур	Брадли С.Мэйнс
Солонгосын Сүүл	Брент Ж.Кристенсен
Тайваний Тайбэй	Дэвид О.Дэй
Тайланд Бангкок	Дэвид М.Сийнор

НОМЛОЛ	ШИНЭ ЕРӨНХИЙЛӨГЧ
Техас Хьюстон Өмнөд	Брайн К.Аштон
Украины Днепропетровск	Ж.Роберт ван Бругген
Умард Каролайна Рали	Марк А.Бернисел
Умард Каролайна Шарлотт	Роналд Л.Гравен
Унгарын Будапешт	Ловелл В.Смит
Уругвайн Монтевидео	Дэвид К.Армстронг
Филиппиний Багио	Виллиам Ж.Монахан
Филиппиний Баколод	Марло О.Лопез
Филиппиний Лаоаг	Юлиус Джона Ф.Барриентос
Францын Лион	Блайк М.Рони
Хайти Порт-ау-Фринц	Хуберманн Бэйн-Айм
Хятадын Хонг Конг	Ваал Д.Хокс
Чикаго Иллинойс	Жерри Д.Фенн
Чилийн Вина дел Мар	Фредрико М.Канлейн
Чилийн Сантьяго Зүүн	Дэвид Л.Врайт
Шинэ Гвинея Папуа Порт Моресби	Сулиаси Веа Кауфуси
Шотланд/Ирланд	Алан Х.Браун
Энэтхэгийн Шинэ Дели	Петр Е.Сакли
Юта Огден	Бага Морис Д.Йерс
Юта Прово	Жонн А.Маккун
Юта Солт Лейк Баруун	Эрл С.Суэйн
Юта Солт Лейк Төв	Ричард В.Моффат
Японы Токио	Л.Тодд Будж
Японы Фукуока	С.Самуел Густафсон



2011 оны 3-р сард болсон аюулт газар хөдлөлт болон цунамигаас хойш Японд байдал ямархуу байгааг үзэж танилцахаар ахлагч Даллин Өүкс эхнэр Кристений хамтаар очлоо. Тэд Японы Сендайд номлолд үйлчилж байсан юм.

Газар хөдлөлтөөс нэг жилийн дараа ахлагч Өүкс Японд очиж байдал ямар байгаатай танилцав

Аймшигт газар хөдлөлт ба цунами болж Японыг цочирдуулснаас хойш бараг нэг жилийн дараа Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын ахлагч Өүкс болон Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн ахлагч Доналд Л.Холлстром нар Японд айлчилж, итгэл болон хайрын захиасыг өгөв.

Энэ 2-р сард Ахлагч Өүкс болон ахлагч Доналд Л.Холлстром нар эхнэрүүдийн хамт Азийн хойд хэсгээр аялж, Кумамото, Нагасаки, Сендай, Токио болон Тогоку бүсийн эргийн олон хотуудаар 12 хоногийн турш аяллаа.

Сүмийн мэдээ дээр гарсан нийтлэл дээр ахлагч Өүкс аялалынхаа зорилгыг тайлбарлахдаа: “бид аймшигт гамшиг, цунами болсноос бараг нэг жилийн дараа тэдэнд

тайтгарлыг өгөхөөр зорьсон юм. Мөн номлогч болон сүмийн гишүүдтэй уулзахдаа үргэлж хуваалцдаг гэрчлэл болон сургаалаасаа хуваалцлаа” хэмээн бичжээ.

Ахлагч Өүкс болон Сүмийн бусад удирдагчид Японы Хожмын Үеийн Гэгээнтнүүд, номлогчид болон бусад хүмүүстэй уулзаж тэднийг “Их Эзэн та нарын зовлонг адислал болгон хувиргах тэрхүү арга замыг хай” хэмээн урамшуулжээ.

Сүмийн удирдагчдын дэлхий даяар хийсэн тохинууллын талаар news.lds.org болон prophets.lds.org-с уншина уу. Ахлагч М.Рассел Баллард Бразилд, ахлагч Жеффри А.Холланд Баруун Африкт, ахлагч Дэвид А.Беднар Карибд, ахлагч Квинтин Л.Күк Австрали болон Шинэ Зеландад, ахлагч Д.Тодд Кристофферсон Төв Европт болон ахлагч Нейл Л.Андерсен Бразилд тус тус айлчилсан байна. ■

Гишүүдийг гэр бүлийн түүхийн зарчмуудаа ойлгохыг Сүмийн удирдагчид хүсч байна

Сара Жейн Вийвер

Сүмийн мэдээ туслах редактор

Сүмийн удирдагчид Хожмын Үеийн Гэгээнтнүүдийг ариун сүмийн ёслолуудад зориулж нэрсийг оруулахдаа гэр бүлийн түүхийн зарчмуудыг илүү сайн сурч, ойлгохыг хүсч байна.

New.FamilySearch.org вэб сайтыг ашиглан нэрсийг оруулахдаа “сайн мэдээний дагуу, хүндэтгэлтэй мөн ухаалгаар” хийх ёстой хэмээн Сүмийн гэр бүлийн түүхийн хэлтсийн зохицуулах захирал Деннис С.Бримхолл ярьсан.

Энэхүү вэб сайтыг ашиглах нөхцлүүд нь энгийн бөгөөд шулуун байдаг. “Хэрэглэгч нь ариун сүмийн орлон гүйцтэгдэг ёслолуудыг хийлгэхээр хамаатан биш хүмүүсийн нэрсийг үүний дотор алдартай одууд, нэр хүндтэй хүмүүсийн нэрсийг болон зөвшөөрөлгүйгээр цуглуулсан нэрсийг оруулж болохгүй” гэсэн нөхцлийг вэб сайт руу нэвтрэхдээ зөвшөөрсөн байх ётой.

Төлөөлөн хийх баптисмын хориглох зүйлсийн тухай *Гарын авлага 2*, дээр дурьдсан заавруудыг бас тодотгон оруулсан байгаа.

“Гэр бүлийн гишүүдээ эрж хайх болон ариун сүмийн ажлыг хийлгэхээр нэрсийг бэлтгэх нь мэдээж бидний үүрэг хариуцлага гэхдээ энэ бас эрх мэдэл юм гэдгийг бид санаж байх ёстой” гэж Бримхолл ах хэлсэн. “Энэхүү эрх мэдлийг гишүүдэд энэ ажлын түлхүүрийг атгадаг хүмүүс өгдөг юм. Энэ ажлын түлхүүрүүдийг Сүмийн Тэргүүн Зөвлөлийнхөн атгадаг.”

Нас барсан хүмүүсийн төлөө төлөөлөн гүйцэтгэх баптисм хийлгэхээр нэрсийг оруулж байгаа гишүүдээс Сүмийн удирдагчид дараах зүйлсийг хүсч байна:

- Зөвхөн гэр бүлийнхээ хүрээнд ажиллах.
- Алдартай оддын нэрсийг оруулахгүй байх.
- Зөвшөөрөл аваагүй хүмүүсийн нэрсийг үүний дотор хэлмэгдсэн еврейчүүдийн нэрсийг оруулахгүй байх.

Еврей шашны удирдагч нартай ярилцан тохиролцсоны үндсэн дээр 1995 онд байгуулсан Сүмийн зарчмын талаар асуултуудад хариулт болгон 2012 оны 2-р сарын 21-нд Сүмийн удирдагчид дараах мэдэгдлийг хийсэн.

Уг мэдэгдэлд Сүм зөвшөөрөлгүй нэрсийг төлөөлөн гүйцэтгэх баптисм хийлгэхээр хүлээн авахгүй гэдгийг давтсан бөгөөд ийм нэрсийг оруулдаг гишүүд “хууран мэхлэх” арга хэрэглэж байна хэмээн сануулсан байна.

Эдгээрийг зөрчих аваас NewFamilySearch.org вэб сайт руу нэвтрэх Сүмийн гишүүний эрхийг нь түтгэлзүүлэх төдийгүй зарим нөхцөлд орон нутгийн удирдагчид нь сахилгын арга хэмжээ авч болно.

“Сүмийн зарчмыг мэдсээр байж зөрчих нь үнэхээр сэтгэл өвтгөдөг бөгөөд хайр, хүндэтгэлийн энэхүү төлөөлөн гүйцэтгэх баптисм нь үйл ойлголцлыг үүсгэдэг нь үнэхээр харамсалтай юм” гэж уг мэдэгдэлд дурьджээ.

“Бид зарим нэг зүйлсийг сурах шаардлагтай байна” гэж Бригхолл ах хэллээ. Бид өөрсөддөө түлхүүрүүдийн эрх ба үүрэг хариуцлага мөн хэн үүнийг хэрхэн, хэний заавраар хийх ёстой болохыг сануулах болно. Бид эдгээрийг л санах юм бол болж байна. . . . Бид нэрс оруулах үйл явцыг хүн бүрд хүндрэлгүйгээр хийж чадна.” ■

Нас барсан хүмүүсийн нэрсийг баптисм хийлгэхээр оруулж байгаа гишүүдээс Сүмийн удирдагчид зөвхөн гэр бүлийнхээ гишүүдийн нэрсийг оруулж, алдартай одод болон зөвшөөрөлгүй хүмүүсийн нэрсийг үүний дотор еврей хэлмэгдэгсдийн нэрсийг оруулахгүй байхыг хүсч байна.



ДЭЛХИЙ ДАХИНД

Зургийг РИК УОЛПЕС



Донтолтоос ангижрах хөтөлбөрийн удирдагчид шинэ вэб сайтдаа зориулан донтолтоос ангижирсан хувь хүмүүсийн түүхийг сонирхож байна.

Донтолтоос ангижрах хөтөлбөрөөс донтолтоос ангижирч, эдгэрсэн хүмүүсийн түүхээс мэдэхийг хүсч байна

Донтолтоос ангижрах хөтөлбөрийн (ДАХ) вэб сайтыг энэ оны эцэс гэхэд бэлэн болгохоор төлөвлөсөн бөгөөд донтолтоос ангижирсан хувь хүмүүсийн түүхээс мэдэхийг хүсч байна.

Өөрсдийн туршлагаас хуваалцахыг хүссэн хүмүүс ar@ldschurch.org хаягаар э-мэйл бичиж доорх зүйлсийг э-мэйлдээ бичнэ үү. Эдгээрийн нууцлалыг хадгалах болно.

- Овог нэр, нас, хүйс
- Өөрийн зураг (заавал шаардлагатай биш ч илгээвэл сайн)
- Сүмтэй ямар холбоотой болох/ гишүүнчлэлийн статус
- Өөрийн болон хайртай хүмүүсийнхээ донтолтын тухай товчхон тайлбар
- Өөрийн түүхийг видео бичлэгээр, дуу бичлэгээр, бичвэрээр эсвэл бүгдийг нь ашиглан бусадтай хуваалцах хүсэлтэй байгаагаа бичнэ.
- Таны түүх Донтолтоос үүдсэн үр дагаварууд (зохимжгүй зүйлсийн тухай хуваалцах хэрэггүй. Гэхдээ таны донтолт танд болон таны эргэн тойрныхонд хэрхэн нөлөөлсөн тухай оруулна уу), донтолтоос ангижрахад тусламж хэрэгтэй гэдгээ ухаарсан тухай товчхон өгүүлж, Христээр дамжуулж хэрхэн итгэл найдвараа сэргээсэн хийгээд одоо хэрхэн амьдарч байгаагаа мөн өршөөл, наманчлал, үйлчлэлээр дамжуулан юу сурч, ямар адислал хүлээн авсан тухайгаа бичнэ үү.

Фижигийн Сүмийн гишүүд үерийн хохирогсдод хүмүүнлэгийн тусламж үзүүлэв

2-р сард Фижигийн Сувагийн гурван гадасны гишүүд Фижигийн хойд болон баруун хэсэгт болсон үерт хохирол амссан хүмүүст зориулан хоол хүнс, гэр ахуйн эд зүйлс болон хичээлийн хэрэглэл цуглуулав.

Энэ оны эхээр Фижид ширүүн бороо үргэлжлэн орсны улмаас нутгийн хойд болон баруун хэсгээр үер болж, газрын хөрс нь нурсан байна. Үерт хэд хэдэн хүн амь үрэгдэж, олон мянган хүн гэр орноо орхин нүүх шаардлагатай болжээ.

Энэ үеэр Сүмийн орон нутгийн удирдагчид гэр орон нь үерт өртөх аюултай байгаа хүмүүсийг цуглааны байранд оруулжээ.

Үерийн тухай сонсонгуутаа Фижи дэх Үйлчлэлийн төвийн менежер Бүсийн далын ахлагч Таниела Ваколо 2-р сарын 6-нд тусламжийн зүйлс цуглуулах ажлыг сэджээ. Гишүүд цуглуулсан хоол хүнс, хувцас, ор дэрний цагаан хэрэглэл, гал тогооны эд зүйлс болон хичээлийн хэрэглэлийг ангилан ялгаж тусламж хэрэгтэй хүмүүст тараан өглөө.

Эдгээр болон бусад түүхийг news.lds.org-с уншина уу. ■



Энэ оны эцэс гэхэд ахлагч Снөв Сүмийн түүхч ба цэдэглэгчийн үүрэгт ажлыг бүрэн хүлээн авна.

Ахлагч Стевен Е. Снөв Сүмийн түүхчээр дуудагдлаа

Тэргүүн Зөвлөлөөс саяхан Далын Ерөнхийлөгчийн зөвлөлийн ахлагч Стевен Е.Снөвийг өмнө нь Далын ахлагч Марлин К.Женсен ахын хийж байсан Сүмийн түүхч ба цэдэглэгчийн үйлчлэлд дуудлаа.

Ахлагч Снөв Далын Ерөнхийлөгчийн Зөвлөлийн дуудлагаас чөлөөлөгдөж байна. 2012 оны 10-р сарын ерөнхий чуулган дээр ахлагч Женсен ах дуудлагат ажлаасаа чөлөөлөгдөх болно.

2012 оны 10-р сар хүртэл ахлагч Снөв, ахлагч Женсен нар хамтдаа үйлчилж, дадлага хийнэ. ■

Анхдагчид надад заасан юм

Өнгөрсөн 12 сард би санаагаар унасан байсан тул гэр орноо чимэглэж, Христийн мэндэлсний баярыг тэмдэглэх ямар ч хүсэл надад төрсөнгүй. Тэгээд би 2011 оны 12-р сарын *Лиахона* –гаас идэх зүйл хомсхон, ямар ч бэлэг сэлтгүй мөн хөгжмийн зэмсэггүй учраас амаараа дуу аялан бүжиглэж, Христийн мэндэлсний баяраа тэмдэглэсэн анхдагчдын тухай уншлаа. Уг өгүүлэл намайг зоригтой байж, үзэл бодлоо өөрчлөхөд маань тусалсан. Өөрт байгаа зүйлсээ ухаарч, үнэлэхгүй үе бидэнд тохиолддог.

Ана Роза де Мело Феррейра, Бразилын Рио де Жанейро

Өдөр бүр Бурханыг эрэлхийл

2012 оны нэгдүгээр сарын Лиахонаг хэвлэсэнд баярлалаа. Адам Олсоны “Дэлхийн гайхамшигийг дахин нээх . . . ба Сүнслэг байдлаа доройтуулахаас сэргийлэх нь” (20-р хуудас) өгүүллийг нөхөртэйгээ хамт уншсан нь үнэхээр сайхан байв. Энэ нь бидэнд өдөр бүр Бурханыг эрэлхийлэх хэрэгтэйг ойлгоход маань тусалсан юм. Сэтгүүл дээр гарсан захиасууд нь сүнслэгээр илчлэгдсэн гэдгийг би мэднэ. Учир нь тэдгээр захиас нь надад яг хэрэгтэй үед гарсан байдаг.

Дайана Арасели Белогги де Ианноне, Аргентины Буэнос Айрес

Санал хүсэлтээ

liahona@ldschurch.org хаягаар илгээнэ үү. Ирүүлсэн материалуудаас нэмж хасан, тодруулахын тулд хянан засварлаж болно. ■

Энэ дугаарт гэр бүлийн үдэшт ашиглах өгүүлэл, үйл ажиллагаануудыг бичсэн байгаа. Зарим жишээг доор өгөв:



“Үнэ цэнэтэй өв уламжлал”

16-р хуудас: Өгүүллийг гэр бүлээрээ унш. “Анхдагчид цөлийг сарнай мэт цэцэглүүлсэнтэй адил бид тэдний уламжлалыг хүндэтгэж мөн тэдний жишээг дагах аваас амьдрал болоод гэр бүл маань цэцэглэх болно” хэмээсэн Ахлагч Том Перригийн үгийг онцлон унш. Танай гэр бүлийнхэн анхдагчдын жишээг яаж илүү их дагаж чадах вэ? гэдгийг асуу. Гэр бүлийн үдшээ дуусгахдаа “Come, Come, Ye Saints” (*Hymns*, 30)-г дуулж болно.

“Ирээдүйгээ итгэл найдвараар

угтах нь,” 35-р хуудас: Та Грило ахын түүхийг эсвэл ирээдүйдээ итгэлтэй байсан өөрийнхөө болон бусад хүмүүсийн түүхээс хувцаалцаж болно. “Танд итгэлээ хадаглаж үлдэхэд саад болох ямар ирээдүйн асуудлууд байна?” гэж гэр бүлийн гишүүдээсээ асууж тэдэнд захиасыг амьдралдаа хэрэгжүүлэхэд нь туслах хэрэгтэй.

Иймэрхүү сорилт бэрхшээлүүдтэй тулгарах юм бол та нар өөдрөг үзэлтэй байхын тулд юу хийх вэ? Өгүүллийн сүүлчийн хоёр догол мөрийг уншиж хичээлээ дуусга.

“Жинхэнэ гэрчлэл гэж юу вэ?”

54-р хуудас: Хичээлээ эхлэхдээ гэрчлэл гэж юу болох тухай өгүүлсэн энэхүү өгүүллийг хуваалц. Дараа нь гэрчлэлээ хуваалцах тухай асуултуудыг дүгнэн ярилц (56–57-р хуудсыг үзнэ үү). Шаардлагтай гэж үзвэл гэр бүлийн үдшийн үеэр бие биендээ гэрчлэлээ хуваалц эсвэл өдрийн тэмдэглэл дээрээ гэрчлэлээ бичихийг гэрийнхнээсээ хүс.

“Сайхан сэтгэлийн шивнээ,” 59-р хуудас: Лук 6:27-г унш. Дараа нь Жеймс, Карсон нарын түүхийг хуваалцаж, хүүхдүүдээс эхний хуудасны доор байгаа асуултуудыг асуу. Гэр бүлийн гишүүдийг бие биендээ найрсаг байхад нь урамшуул. ■

“Гэрээсээ гадуур” хийдэг гэр бүлийн үдэш

Би арван настай байхдаа гэр бүлийнхэнтэйгээ баптисм хийлгэсэн юм. Гэр бүлийн үдшээ тогтмол хийдэг гэр бүлд өссөндөө би их баяртай байдаг. Гэр бүлийн цуглаан манай гэр бүлийнхний хувьд үнэхээр чухал байв.

Одоо би Сүмийн гишүүн болоод 45 жил болжээ. Манайх таван хүүхэдтэй бөгөөд бид гэр бүлийн үдэш хийдэг уламжлалаа хадгалсаар байгаа. Даваа гарагийн үдэш бидний хувьд гэр бүлийнхэндээ зориулах цаг байдаг.

Сар бүрийн сүүлийн даваа гараг бид ердийнхөөсөө илүү их цагийг гэр бүлийн үдэшд зарцуулдаг. Учир нь бид энэ өдөр “гэрээсээ гадуур” гэр бүлийн үдшээ хийдэг юм. Тэр өдөр бид кино эсвэл цэцэрлэгт хүрээлэн явах болон өвчтэй хүмүүсийг эргэх, өвөө эмээгийнхэндээ айлчлах зэрэг зүйлсийг хийдэг.

Нэг удаа бид гудамжны хүүхдүүдэд үйлчилсэн нь надад хамгийн дурсгалтай үйл явдал болсон юм. Бид тэдгээр хүүхдэд тусалж үгээр илэрхийлэшгүй их баяр баясгаланг мэдэрсэн. Бид тэдгээр хүүхдэд хүн бүр Бурханы хүүхэд бөгөөд тэдний төлөө санаа тавьдаг хүмүүс байдаг гэдгийг мэдүүлэхийг хичээсэн юм. Бид бас тэднийг аз жаргалтай болгохыг хичээсэн. ■

Тита Мабинга Обиал, Филиппин


ДЭЛХИЙГЭЭС БОХИРДОЛГҮЙ

Жюли Томпсон

Хэдэн жилийн өмнө би Ютагийн Баунтифул ариун сүмд шөнө орой болсон хойно цэвэрлэгээ хийхээр очиж билээ. Цэвэрлэгээ хийхээр нэлээд олон хүн ирснийг хараад заримыг нь гэр рүү нь буцаамаар юм гэсэн бодол толгойд зурсхийн орж ирэв. Би сайн дураараа гэртээ харихад бэлэн байлаа. Тэгснээ “Биднийг цагаас өмнө юу гэж явуулах вэ дээ. Тэд биднийг энд бүтэн хоёр цаг барьж байхыг үүргээ гэж бодоод биднээр хийлгэх ямар нэг хар бор ажил олж л таарна” хэмээн бодож билээ. Өмнөх цэвэрлэгээний үеэр би бүтэн цаг гаруй тоос арчиж, тоосны алчуураа буцааж өгөхөд юу ч арчаагүй юм шиг цэвэрхэн байсныг саналаа. Цэвэрлэх огт хэрэггүй юм шиг харагдаж байсан юмсыг цэвэрлэхэд бүтэн хоёр цаг зарцуулахад би өөрийгөө бэлтгэсэн юм. Мэдээж хэрэг, тэр шөнө би үйлчлэх хүсэл гэхээс илүүгээр үүрэг хариуцлагаа мэдрэхгүйгээр ариун сүм дээр хүрч ирсэн ажээ.

Нэг бүлгийг онцгой цугларалтад оролцуулахаар цуглааны жижигхэн байр руу явууллаа. Онцгой цугларалтыг хөтлөн явуулсан жижүүр нэг зүйл хэлсэн нь ариун сүмийн цэвэрлэгээний талаарх миний үзэл бодлыг бүр мөсөн өөрчилсөн юм. Тэр бидэнтэй эелдэгхэн мэндэлсний дараа бид энд цэвэрлэх шаардлагагүй юмсыг цэвэрлэхээр ирээгүй харин Их Эзэний өргөөг ямар нэг байдлаар бохирдохоос хамгаалах гэж ирснийг тайлбарлав. Дэлхий дээрх хамгийн ариун газруудын нэгнийх нь эзэмшигчид болсон бид энэхүү ариун өргөөг бохирдуулахгүй байх үүрэгтэй.

Түүний үг миний зүрх сэтгэлийн гүнд нэвтэрч, Их Эзэний өргөөг хамгаалахын тулд өөртөө даалгаж өгсөн талбайг шинэ урам зоригоор цэвэрлэж эхэллээ. Би зөөлөн үстэй зургийн багсаар хаалганы хүрээний нарийнхан ховил, сандал, ширээний хөлийн тоосыг хоёр цагийн турш нямбай арчлаа. Хэрэв өмнөх цэвэрлэгээний үед надад ийм ажил даалгасан бол би үүнд дооглонгүй хандаж, завгүй хүний дүр исгэн, хариуцуулсан



Бүх зүйл ийм сайхан цэвэрхэн байхад би яах гэж ариун сүмийг цэвэрлэх гэж ирсэндээ гайхаж билээ. Гэвч цэвэрлэгээ хамгийн чухал зүйл биш байсныг удалгүй ойлгов.

талбайгаа хайш яйш арчсан болоод өнгөрөх байсан биз ээ. Гэвч би энэ удаа багсныхаа үсийг өчүүхэн нарийн зай завсар бүр лүү оруулан тоосыг арчиж билээ.

Энэ ажил биеийн болон оюун санааны аль алиных нь хүч чармайлтыг шаардсан учраас ажиллаж байхдаа тунгаан бодох цагаар намайг адисалсан юм. Би гэрээ цэвэрлэхдээ хэзээ ч ийм нарийн чимхлүүр ажил хийж байгаагүйгээ бас энд миний цэвэрлэсэн зүйлсийг бусад хүмүүс эхлээд харна, харин гэр орондоо миний хийсэн цэвэрлэгээг зөвхөн би өөрөө болон гэр бүлийн бусад гишүүд л харах юм чинь яахав гээд тоодоггүй байснаа анх удаа ухаарч билээ.

Ариун сүмийг болон гэр орноо цэвэрлэдэг байсан миний хандлага сайн мэдээгээр амьдрахад бас илэрдэг байсныг би үүний дараа ойлгосон юм. Эргэн тойрныхоо хүмүүсийн нүдэнд илт тодорхой харагдах зарчмуудыг амьдралдаа хэрэгжүүлж, ийм ажил үүргийг биелүүлдэг атлаа зөвхөн өөрийнхөө болон хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийн мэдэх зүйлд би тоомжиргүй ханддаг байжээ. Би сүмийн цуглаануудад оролцож, дуудаага болон даалгасан бусад ажил үүргийг биелүүлэн, айлчлагч багшаар явдаг байсан нь тойргийн гишүүдийн нүдэнд ил харагддаг зүйлс юм. Гэвч ариун сүмд тогтмол орж байх, хувиараа болон гэр бүлээрээ судар судалж, залбирах, гэр бүлийн үдэш хийхэд хайхрамжгүй ханддаг байлаа. Би сүм дээр хичээл зааж, цуглаанууд дээр үг хэлдэг байсан ч заримдаа бусад хүмүүстэй харилцах буюу хамтран ажиллахад миний зүрх сэтгэлд жинхэнэ энэрэл үгүйлэгддэг байлаа.

Тэр шөнө би ариун сүм дээр зургийн зөөлөн үстэй багс гартаа бариад “Илүү их анхаарал тавих ёстой ямар жижигхэн зай завсарууд миний амьдралд байна?” гэж өөрөөсөө асууж билээ. Би өөрийн амьдралд байгаа анхаарал тавих шаардлагатай зүйлсийг дахин дахин цэвэрлэж, тэдгээрийг хэзээ ч бохир болгохгүй хэмээн хатуу шийдсэн юм.

Ариун сүмийг цэвэрлэхэд миний авсан энэхүү сургамж “дэлхийгээс бохирдолгүй” (Иаков 1:27) байхыг бидэнд үргэлж сануулдаг билээ. ■



Петерсон дахь байшин, ЛиКонте Стюарт

Ютагийн Петерсон дахь энэхүү нам гүмхэн ферм 1847 оны нэгдүгээр сард Небраскийн Винтер Квортерст Хожмын Үеийн Гэгээнтнүүдэд Их Эзэний өгсөн амлалтын биелэлт болон харагдаж байна. Гэгээнтнүүдийг Винтер Квортерс дахь түр буудлаа орхин хээр талыг туулж, Солт Лейкийн Хөндий рүү хөдлөх бэлтгэлийг хангаж байхад нь “Их Эзэний үг хийгээд таалал” хэмээх энэхүү илчлэлт Ерөнхийлөгч Бригам Янгд өгөгдсөн ажээ:

“Энэ хүмүүсийг Сионы гадас болгон Их Эзэний байршуулах тэр газарт нүүлгэхийн тулд хүн болгон бүх нөлөө хийгээд өмч хөрөнгөө ашиглаг.

Мөн хэрэв та нар үүнийг цэвэр ариун зүрх сэтгэлээр, бүхий л итгэлтэй байдалд хийх аваас та нар адислагдах болно; та нар бог болон бод малаараа мөн талбайнуудаараа мөн орон гэрээрээ, мөн гэр бүлүүдээрээ адислагдах болно” (С ба Г 136:1, 10–11).



Ерөнхийлөгч Томас С.Монсон “Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүд бидний хувьд ариун гэрээнүүддээ хүндэтгэлтэй хандаж, эдгээрт чин үнэнч байх нь аз жаргалд хүрэх шаардлага юм. Тийм ээ, би баптисмын, санваарын түүнчлэн гэрлэлтийн гэрээг жишээ болгон хэлж байна” хэмээн тайлбарлажээ. Гэрээгээ сахих нь энэ амьдралын жаргалыг мөн ирээдүйн мөнхийн амьдралыг авахад чухал үүрэг гүйцэтгэдэг тул бид Тэнгэрлэг Эцэгтээ ямар амлалтууд өгсөнөө ойлгох хэрэгтэй. “Бурхантай байгуулсан гэрээнүүдээ ойлгох нь” 20-р хуудсыг үзнэ үү.

ЕСҮС ХРИСТИЙН
ХОЖМЫН ҮЕИЙН
ГЭГЭЭНТНҮҮДИЙН СҮМ